

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРОО

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 7
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	8 – 93

1.	<i>Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./</i>	9 – 21
2.	<i>Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./</i>	21 – 58
3.	<i>Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх /Эмч, багш нарын цалинг нэмье гэсэн асуудлаар ажлын хэсэг байгуулах, үргэлжилнэ/</i>	58 – 88
4.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/</i>	88 – 91
5.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/</i>	91 – 93

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Өргөдлийн байнгын хорооны 9 дүгээр сарын 30-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Өргөдлийн байнгын хорооны дарга О.Номинчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 24 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 54.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 25 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баттулга, Б.Батцэцэг, Б.Бат-Эрдэнэ, Ч.Ундрам, С.Цэнгүүн;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батбаяр, С.Замира;

Тасалсан: П.Мөнхтулга.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Стандарт, хэмжил зүйн газрын дарга С.Ганбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, мөн яамны Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Макро эдийн засгийн бодлогын газрын шинжээч Ж.Өлзийсайхан, Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, ар талын газрын Санхүүгийн хэлтсийн дарга Т.Мөнх-Эрдэнэ, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа, Р.Ринчинбазар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Д.Наранцэцэг, референт С.Уянга, Г.Нямсүрэн, ажилтан Д.Оюун, Төсвийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа, С.Эрдэнэбат нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Р.Ринчинбазар нар хариулж, тайлбар хийв.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат үг хэлэв.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 09 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн

хамгааллын сайд Т.Аубакир, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Д.Мөнх-Эрдэнэ, Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Стандарт, хэмжил зүйн газрын дарга С.Батбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, мөн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга Я.Гантөмөр, мөн газрын Санхүү, ар талын газрын Санхүүгийн хэлтсийн дарга Т.Мөнх-Эрдэнэ, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа, Р.Ринчинбазар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Д.Наранцэцэг, референт С.Уянга, Г.Нямсүрэн, ажилтан Д.Оюун, Төсвийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Г.Лувсанжамц, Д.Ганмаа, Р.Эрдэнэбүрэн, О.Номинчимэг нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Боловсролын сайд П.Наранбаяр, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Д.Мөнх-Эрдэнэ, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа, Р.Ринчинбазар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа, С.Эрдэнэбат, Б.Пунсалмаа, Д.Рэгдэл, Д.Ганмаа, Ж.Галбадрах, Р.Эрдэнэбүрэн нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх /Эмч, багш нарын цалинг нэмье гэсэн асуудлаар ажлын хэсэг байгуулах, үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Сангийн яамны Зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Д.Наранцэцэг, референт С.Уянга, Г.Нямсүрэн, ажилтан Д.Оюун нар байлцав.

Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийн асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа, Д.Ганмаа, Ж.Галбадрах, Р.Эрдэнэбүрэн, Б.Пунсалмаа, С.Эрдэнэбат нарын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Сангийн яамны Зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, С.Эрдэнэбат, Г.Лувсанжамц, Д.Рэгдэл, Д.Ганмаа, О.Номинчимэг нар үг хэлэв.

О.Номинчимэг: Монгол Улсын иргэн Б.Номингоос ирүүлсэн эмч, багш нарын цалинг нэмье гэсэн асуудлаарх нийтийн өргөдлийг зарчмын хувьд дэмжиж, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хороогоор хэлэлцэхдээ Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг хэлэлцүүлж байгаатай холбогдуулан хүрээ хязгаарт өөрчлөлт оруулах эсэхээс шалтгаалан бодлогын шийдвэр гаргахыг дэмжих нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 4

Бүгд: 15

73.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 12 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Д.Наранцэцэг, референт С.Уянга, Г.Нямсүрэн, ажилтан Д.Оюун нар байлцав.

Байнгын хорооны дарга О.Номинчимэг Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Д.Рэгдэл нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга О.Номинчимэг хариулж, тайлбар хийв.

О.Номинчимэг: Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15

60.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 66.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Д.Наранцэцэг, референт С.Уянга, Г.Нямсүрэн, ажилтан Д.Оюун нар байлцав.

Байнгын хорооны дарга О.Номинчимэг Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга О.Номинчимэг хариулж, тайлбар хийв.

О.Номинчимэг: Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 6

Бүгд: 15

60.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 66.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 31 минут үргэлжилж, 24 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 12 цаг 57 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

О.НОМИНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхим
09 цаг 25 минут

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

О.Номинчимэг: Энэ өдрийн өглөөний мэнд хүргэе. Эрхэм Байнгын хорооны гишүүддээ.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Өргөдлийн байнгын хорооны 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Нийт 24 гишүүнээс 13 гишүүн буюу 54.2 хувийн ирцтэй байна.

Жамбын Батсуурь, Хажекберийн Жангабыл, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Бадамдоржийн Пунсалмаа, Сүхбаатарын Эрдэнэбат, Жанчивын Галбадрах, Жаргалсайханы Золжаргал, Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Дүгэрийн Рэгдэл, Даваасамбуугийн Ганмаа, Ганзоригийн Лувсанжамц, Одсүрэнгийн Номинчимэг, Мягмардашийн Сарнай гишүүд өнөөдөр Байнгын хорооны хуралдаанд оролцож байна.

Далайн Батбаяр, Сонгобайн Замира гишүүд эмнэлгийн чөлөөтэй байгаа юм байна.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр 5 асуудалтай байгаа. 5 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг. Нэгдүгээр асуудал байна.

Хоёрдугаар асуудал. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэнэ.

Гуравдугаарт, Нийтийн өргөдлийн тухай буюу Монгол Улсын иргэн Б.Номингоос ирүүлсэн эмч, багш нарын цалинг нэмье гэсэн асуудлаар ажлын хэсэг байгуулах нийтийн өргөдлийг үргэлжлүүлэн бид хэлэлцэхээр байна.

Дөрөвдүгээрт, Байнгын хорооны тогтоолын төсөл. Ахмадын зөвлөл болон нэр бүхий иргэдээс ирүүлсэн ахмадын тэтгэвэр нэмэгдүүлэх, тэтгэврийн зээлийг бууруулах, ахмадуудад зориулсан эрүүл мэндийн болон асрах үйлчилгээг сайжруулах тухай өргөдөл, гомдлоор “Ажлын хэсэг байгуулах тухай” асуудал байна.

Тавдугаарт, Байнгын хорооны тогтоолын төсөл буюу D-Parliament, D-Petition дээрх нийтийн өргөдлийг хүлээн авах, шийдвэрлэх журмыг боловсронгуй болгох ажлын хэсэг байгуулах Байнгын хорооны тогтоолын төсөл хэлэлцэхээр тов дараалалд орсон байна.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудлаа баталлаа. /алх цохив/

Ингээд асуудалдаа оръё.

**Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл,
2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**
/Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хоёр дахь хэлэлцүүлэг,
санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд
хүргүүлнэ./

Нэгдүгээр асуудал. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64.1.2-т Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд Төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэж, гишүүд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, гаргасан саналынхаа үндэслэлийг тайлбарлаж үг хэлж болно гэж заасан.

Ингээд манай Байнгын хороо шинээр байгуулагдсан Байнгын хороо. Эрхлэх асуудлын хүрээнд гэж бодохоор их өргөн цар хүрээ байгаа. Ялангуяа нийтийн өргөдлөөс, нийтийн иргэдээс ирж байгаа өргөдөл, гомдлууд, хувь гишүүд дээр ирж байгаа өргөдөл, гомдлууд. Дээр нь бас иргэдээс ирж байгаа саналууд дээр үндэслэж бид энэ асуудлуудыг төсвийн төсөөлөл, төсвийн

хүрээний мэдэгдэл болон төсвийг хэлэлцэхээр байна гэж Тамгын газраас мэргэжил, арга зүйн зөвлөгөөг өгсөн байгаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Сандагийн Бямбацогт Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Болдын Жавхлан Сангийн сайд, Л.Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Р.Ринчинбазар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, И.Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ж.Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, С.Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Ж.Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, С.Ганбаатар Стандарт, хэмжил зүйн газрын дарга, О.Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний Төлөвлөлтийн хэлтсийн дарга, Ц.Мөнхдэлгэр Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга, Ж.Өлзийсайхан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын шинжээч, Т.Мөнх-Эрдэнэ Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, ар талын газрын Санхүүгийн хэлтсийн дарга нар оролцож байна.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд хуулийн төсөл 2 зүйлтэй.

Гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон Төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж болох ийм дэгтэй байна.

Тэгээд хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Манайхан бүгдэд нь төсвийн хүрээний мэдэгдэл байгаа. Тийм ээ? Эхлээд эхний асуудал төсвийн хүрээний мэдэгдэл. Зүйл бүрээр бид хоёрдугаар хэлэлцүүлгийг явуулна.

1 дүгээр зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүн байна уу? 2 гишүүн байна уу Тийм ээ.

С.Эрдэнэбат гишүүнээр тасалъя. Ц.Мөнхтуяа гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Хуулийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээг 1.8 их наядаар бууруулж, 31 их наяд 600.0 тэрбум болгохоор оруулж ирсэн.

Энэ орлогоо нэмэгдүүлэх ямар боломж байгаа вэ? Б.Жавхлан сайдаас асууж байгаа шүү. Хэрвээ орлого зорьсон түвшиндээ хүрэхгүй бол гаднаас зээл авах уу? Хоёрдугаар асуулт.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-д нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх. Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөө, 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлд төсвийн урсгал зардлыг бууруулж, дотоодын нийт бүтээгдэхүүний 24 хувиас хэтрүүлэхгүй байна гэсэн энэ хоёр шаардлагын хайчинд багш нарын цалинг нэмж болохгүй, ахмадын тэтгэврийг нэмж болохгүй, хуулиар хориглосон гээд яриад байгаа.

Энэ 24 хувийн шаардлагаа Засгийн газар 25, 26 хувьд хүргэж болох уу? Хэрвээ болохгүй гэвэл Их Хурлын гишүүд эндээс санаачлаад явна гэсэн ийм бодолтой байна.

Гуравдугаарт, өнгөрсөн жил 2025 оны төсөв батлах гээд сууж байхад инфляц 6 хувьтай байна гэж байсан. Тийм ээ. Тэгсэн чинь одоо статистикийн мэдээгээр 9-өөс 10 хувь бараг хүрсэн байна. Яг бодит амьдралд дээр хэд хүрснийг таашгүй байна.

Тэгэхээр ирэх жил бид 6 хувьтай байна гээд байсан. Бас л энэ жил шиг 9, 10 хувь хүрвэл яах вэ? Энэ үнийн өсөлтийг чинь ард түмэн, бизнесүүд нуруундаа үүрээд яваад байх уу гэдэг нэг асуулт байна.

Дараагийн асуулт. Засгийн газраас 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарласан. 2026 оны хөгжлийн төлөвлөгөө, үүн дотор бодлогын тэргүүлэх чиглэлийн 2.1.18-д багш, ажилчдын цалин хөлс, нийгмийн баталгааны асуудлыг тэргүүн ээлжид сайжруулна гэж заасан мөртлөө өнөөдөр салбарын багш, ажилтны цалин хөлсийг нэмэхэд ямар ч бодитой шийдэл, тодорхой тоо алга байна. Үүнийгээ одоо яах вэ? Та нар үүнийгээ биелүүлэхгүй байгаа юм чинь төсвийн урсгал зардлаа 24 хувиас хэтрүүлэхгүй гэдгээ бас биелүүлэхгүй байж болох биш үү? Ийм 4 асуулт байна.

О.Номинчимэг: Эхлээд Болдын Жавхлан сайд хариулах уу? Эдийн засаг, хөгжлийн яам уу? Танаас бас нэг асуулттай. Тийм ээ.

2 номер И.Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга.

И.Батхүү: Ц.Мөнхтуяа гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яам Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү.

Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг боловсруулахдаа нүүрсний үнийг өнөөгийн гадаад, дотоод нөхцөл байдалтай уялдуулаад яг эрсдэлээс болгоомжлоод 70 ам.доллараар хилийн дундаж үнийг тооцсон байгаа.

Үнийг бид дээшээ нэмэгдүүлж тооцох нь илүү эрсдэлтэй гэж үзэж байгаа юм. Гадаад өнөөгийн нөхцөл байдалд.

Биет хэмжээний хувьд Засгийн газраас 2026 онд 90 сая тонн нүүрс гаргахаар ажиллаж байгаа. Энэ нүүрсний зөвхөн биет хэмжээг нэмэгдүүлэх биш бас баяжуулсан нүүрсний хэмжээг нэмэгдүүлэх талаар Засгийн газраас хувийн хэвшлийг дэмжих бодлогын зорилт тавьж ажиллаж байгаа.

Биет хэмжээг нэмэгдүүлэхтэй холбоотой хилийн боомт бүрээр гарах боломжтой хүчин чадал, төрийн болон хувийн хэвшлийн уул уурхайн компаниудын бодитой бизнесийн төлөвлөгөө, уулын ажлын төлөвлөгөө, экспортын гэрээнүүдэд үндэслээд арай бодитойгоор төлөвлөхийг хичээсэн байгаа.

Тэнцвэржүүлсэн орлогыг яг өнөөгийн байдлаар нэмж тооцох яг тодорхой үндэслэл бас байхгүй байгаа.

Хэрвээ нэмье гээд явах юм бол бас хиймлээр нэмэгдэх эрсдэлтэй гэж үзэж байгаа. Таны сая дурдсан орлого тасарвал яах вэ гэдэг асуудал дагаад үүснэ.

Урсгал зардлын тухайд хууль дээр заасан хэмжээ нь дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувь гэж байгаа ч гэсэн өнгөрсөн оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг Их Хурлаар батлуулахдаа урсгал зардлын хэмжээг 24 хувь гэж зааж өгсөн байгаа. Их Хурлаар батлагдсан хүчин төгөлдөр баримт бичигтээ бас нийцүүлсэн байгаа.

Ер нь урсгал зардлыг үе шаттайгаар бууруулах нь саяын таны дурдсан инфляцын дарамтыг бууруулахад Засгийн газар сангийн бодлого талаасаа хувь нэмэр оруулах асуудал юм.

Инфляцын хувьд ирэх оны инфляцыг 7 хувь гэж зорилтот түвшнийг тавьж байгаа. Монголбанкны тавьсан зорилтот интервалд нийцэж байгаа. Инфляц маань өөрөө Засгийн газар, Монголбанк хоёр талаасаа бодлогын үр дүнгээ нийцтэйгээр хамтарч ажиллах ёстой. Бодлогын уялдаатай. Эрэлт талын инфляцыг бууруулах талаас Монголбанкны мөнгөний бодлогын үр дүн гарах ёстой. Нийлүүлэлт талаасаа Засгийн газрын зүгээс саяын урсгал зардлын хэмжээг үе шаттайгаар бууруулах. Дээр нь нэмээд тээвэр ложистикийн зохион байгуулалтыг сайжруулах, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж байгаа “Хүнсний хувьсгал”, “Атар-IV”, “Цагаан алт”, “Шинэ хоршоо” зэрэг хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж үр дүнг нь гаргах шаардлагатай байгаа.

Бусад зохион байгуулалтуудын асуудлууд дээр анхаарч инфляцыг бууруулах зорилт тавьж ажиллаж байгаа.

Инфляцын зорилтот түвшин, гүйцэтгэлийн тоо хоёр өөр учраас 7 хувийн зорилт гэж тавьж байгаа.

Инфляцын түвшнийг үе шаттайгаар бууруулах нь ер нь дунд хугацаандаа макро эдийн засгийг тогтворжуулах, хүүгийн түвшнийг бууруулахад бас чухал ач холбогдолтой. Зээлжих зэрэглэлийг бас бууруулахгүй байх чухал ач холбогдолтой учраас инфляцыг ийм зорилт түвшинд тавьж ажиллаж байгаа.

О.Номинчимэг: 5 номер. Болдын Жавхлан. Сангийн сайд.

Б.Жавхлан: Баярлалаа. Гишүүддээ өглөөний мэнд хүргэе.

Ц.Мөнхтуяа гишүүний асуулт дээр зүгээр би гишүүнийхээ хувиар хэдэн санал, санаа хэлье. Үнэхээр яг хоёр том хязгаарын дунд төсвийн бодлогын орон зай ер нь байхгүй болж ирж байгаа.

Дээрээс нь 24 хувь гээд хязгаарласан. Доороос нь 200 гаруй хуулийн мянга гаран заалтаар аль хэдийн төсвийн зардлыг нь хуваарилсан байж байдаг.

Энэ орон зай ер нь л байхгүй болж ирж байгаа. Ер нь “тэг” болж ирж байгаа. Ийм өнцгөөс л бүгдээрээ үүнийг ойлгож харах хэрэгтэй байгаа юм. Түүнээс биш хуулиар хориглосон учраас эрүүл мэндийн салбарын болон боловсролын салбарын ажилтнуудын, төрийн албан хаагч нарын цалинг нэмэх боломжгүй гэдэг. Энэ бол худлаа гуйвуулсан тайлбар шүү.

Тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль дээр “тэтгэвэр авагчдын цалинг үнийн өсөлттэй холбоотойгоор жил бүр нэмнэ” гэсэн хуулийн заалт байдаг. Одоо яалт ч үгүй... /минут дуусав/

О.Номинчимэг: 5 номер гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Тийм. Яалт ч үгүй ийм хуулийн заалт байдаг учраас миний түрүүн хэлсэн тэр 200 гаруй хуулийн чинь нэг хууль нь бас энэ байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ чинь ерөөсөө ингээд хуулийнхаа дагуу 1, 2, 3 гэж байгаад л бүх зардлуудаа автомат тавьдаг. Тэгээд тэрийгээ ч хязгаартай тавьдаг. Тэгж байж 24 хувьдаа барьж байгаа юм.

Тэгэхээр тэр орон зайг гаргахын тулд 24 хувиа тэлэх хэрэгтэй, эсвэл тэр хуулиар тавьсан баахан зардлуудаа, хуулиудыг нь хүчингүй болгох хэрэгтэй. Ингэж байж л орон зай гарч ирнэ.

Зүгээр харин 24-ийн хязгаарыг авна гэдэг бол эрсдэлтэй. Тэр нь байж байх хэрэгтэй гэж би боддог. Харин тэр хуулиар аль хэдийн зоосон байгаа тэр зардлуудыг, тэр хуулиудыг л хүчингүй болгох хэрэгтэй. Энэ дээр харин хамтарч ажиллахад бид бэлэн шүү. Ц.Мөнхтуяа гишүүн ээ. Тийм.

О.Номинчимэг: Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн тодруулъя.

Ц.Мөнхтуяа: Манай сайд, дарга нар дандаа болохгүй, бүтэхгүй талаас нь л ер нь хариулдаг л даа. Болгоё, бүтээе гэсэн ийм хариулт ер нь авч байсангүй.

Тэгээд одоо энэ 24 хувиас хэтрүүлэхгүй гээд нэг ийм нэг саад тавьсан. Одоо тэгээд үүнийгээ өөрчилж болохгүй гээд сууж байна.

Ер нь 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” гэж ер нь яах гэж анхнаасаа зарласан юм бэ? Засгийн газар. Тэгээд өнөөдөр багш нар чинь маш их хүлээлттэй байдаг. Төсөв дээр нь нэмэх байтугай бараг 1 их наяд төгрөгийн алдагдалтай байгаа шүү дээ. Боловсролын салбар. Тэгээд өнөөдөр гадаа ахмадууд нь жагссан, багш нар нь жагссан, эрүүл мэндийн салбарын ажилтнууд нь бас жагсах гээд хүлээлттэй байж байдаг.

Тэгээд ер нь эрүүл мэнд, боловсролынхоо салбарыг дэмжихгүй юм бол төр засаг гэж байгаад яах юм. Бид. Тэгээд дандаа урдаас болохгүй, бүтэхгүй, байхгүй, болгохгүй талын юм ярих юм. Тэгээд нүүрс гаргаад л байна, ухаад л байна, ухаад л байна. Ард түмэнд хэрэгтэй, өгөөжтэй юм нэг ч байхгүй байна шүү дээ. Тэгээд тэр мөнгө нь хаашаа яваад өгдөг юм. /минут дуусав/

О.Номинчимэг: Үг хэллээ. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Би үүнийг чуулганд хэлж байсан. Тэр төлөвлөгөөнд орсон 24-ийн төсвийн хязгаарлалт 24 хувийн заалт нэг талд нь байж байгаа. Нөгөө талд нь жил болгон цалин хөлсийг нэмнэ гэсэн заалт бас байгаа.

Тэгэхээр төлөвлөгөөнөөс нэг заалтыг нь аваад нөгөө заалтыг нь орхих байдлаар асуудалд хандаж болмооргүй байгаа юм. Яг үнэнээ хэлэхэд улсын төсөв өөрөө иргэн бүрд тодорхой, миний бодит орлого яаж нэмэгдэх нь вэ, надад ямар нөлөөтэй юм бэ гэдэг талаас харж байгаа байх.

Тийм учраас тэтгэврийн тэр инфляцтай уялдуулж нэмэхээс гадна цалин хөлс дээр тодорхой хэмжээний эх үүсвэрийг тавих шаардлагатай гэж би харж байгаа.

Цалин нэмэнгүүт инфляц учир зүггүй өснө гэдэг ийм зүйлээс ерөөсөө манайх салахгүй юм. Нөлөөлөх хүчин зүйл мөн боловчиг яг инфляцад нөлөөлж байгаа гол хүчин зүйл бол би энэ цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж биш гэдгийг хэлмээр байгаа юм.

Энэ олон гадна дотноос импортыг өдөөсөн зүйл чинь яг ний нуугүй хэлэхэд бүтээн байгуулалтын ажлуудтай ч холбоотой.

Тэгэхээр энэ 24 хувийн хязгаарыг Б.Жавхлан сайд Эдийн засаг, хөгжлийн яам. Анх Эдийн засаг, хөгжлийн яамнаас орж ирсэн шүү дээ. Тийм үү? Одоо Л.Гантөмөр сайд энэ урсгал зардлыг багасгая. Томоохон бүтээн байгуулалтаа хөдөлгөө гэсэн. Одоо тэр том бүтээн байгуулалт бүгдийг нь больсон. Ихэнхийг нь.

Тийм учраас үүнийгээ эргэж хараад тодорхой нөхцөлтэйгөөр, төлөвлөгөө дээр хууль биш төлөвлөгөө дээр байгаа асуудал байгаа учраас төсвийг Засгийн газар цалин хөлс, энэ олон шаардлагууд дээр боловсрол, эрүүл мэнд, ахмадын юун дээр тодорхой хэмжээний төсөв тавих боломжийг нь төсвийн хүрээний мэдэгдэл дээрээ ч гэсэн тэр, мөн төсөв дээрээ ч гэсэн оруулж ирэх хэрэгтэй байна.

Тийм учраас би яг энэ асуудал дээр тэр төлөвлөгөө дээр өөрчлөлт оруулах саналыг Их Хурлын гишүүд үнэхээр цалин хөлс тэтгэвэр, тэтгэмж дээрээ дэмжье гэж байгаа. Бүгдээрээ л дэмжье гээд байгаа юм.

Тийм учраас би бүгдээрээ дэмжих болов уу гэж бодож байна. Үүнийг оруулж ирье. Тэр хуулийн мянга гаруй заалтууд байгаа гэдэг дотор зарим нь үнэхээр бодлогын асуудлууд байгаа. Тэгэхдээ яг Б.Жавхлан сайдаас тодруулахад яг ямар аваад хаямаар тийм заалтууд байна. Том масст нөлөөтэй. Тэрийгээ асуумаар байна.

Дээрээс нь Эдийн засаг, хөгжлийн яамнаас асуухад одоо ингээд бид цалин хөлс тэтгэвэр, тэтгэмжээ бүгдийг нь хаагаад бүх юмнуудаа, дээрээс нь баахан хүмүүсийг 9, 10 хувийн ажилгүйдлыг бий болгоод, тэгээд ирэхээр чинь наад эдийн засаг чинь улам агшаад, эргээд нөгөө чөтгөрийн тойрогт орох юм биш үү? Тэгээд та хэд үүнийг юу гэж харж байгаа юм бэ?

Инфляцыг 6 хувьд барина гэдэг. Өнөөдөр 8 орчим хувьтай байна. Он гартал хэдэн хувь гэж төсөөлж байгаа вэ? Нэг.

Дээрээс нь төсвийн олох орлох боломжуудаа дайчил. Тэр Оюу Толгойг харж байхад үндсэндээ бид долларын 11 хувийн зээлийг аваад арван хэдэн жил явсан байна лээ шүү дээ. Гэтэл долларын хадгаламж чинь Монголд 3 хувь. Долларын зээл нь бараг хоёр дахин бага хүүтэй гэж байгаа шүү дээ.

Дээрээс нь Тогтвортой байдлын зөвлөлөөс асууя. Гадаадад Ирээдүйн өв сангийн мөнгийг 3, 4 хувийн хүүтэй хадгалсан нь төсвийн зардлыг бас нэг талаараа өсгөж байна гэж дүгнэлт хийсэн байна лээ.

Тэгэхээр энэ тал дээр тэрийг ирэх жилүүдэд Ирээдүйн өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулаад заавал гадаадын банканд хямд дүнгээр хадгалах гэхээсээ илүүтэйгээр дотоодод хэрэгцээтэй байгаа валютын нөөц, дээрээс нь

- тэтгэврийн зээлийн асуудал,
- цалингийн зээлийн асуудал,
- бизнесийн зээлийн асуудал

гэдэг ийм зүйлүүдээ тодорхой эрсдэл дэх хүчин зүйлийг нь харгалзаж байгаад оруулж ирвэл яасан юм бэ. Энэ тал дээр тэр зүйлийг би тодруулж асуумаар байна. Мөнгөний бодлогынхноос.

О.Номинчимэг: Нэлээн олон хэд хэдэн асуулт байх шиг байна. Болдын Жавхлан сайд. 5 номер.

Б.Жавхлан: С.Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя.

Үнэхээр энэ удаагийн Их Хурал төсвийн зардлыг нэмээд байгаа хуулиудаа эргээд хараад нэг янзалбал их л сайн байгаа юм. Ноднин бид санаачилга гаргаад Их Хурлын төсөв баталсан, дагасан тогтоол дээр энэ заалтыг уг нь оруулаад, хугацаанд нь бид саналаа Их Хурал руу хүргүүлсэн. Ийм эрэмбэ дараатайгаар энэ хуулиудыг нь хүчингүй болгож өгөөч, хойшлуулж өгөөч гээд.

Тэгээд Их Хурал дээрээс ажлын хэсэг байгуулаад, бараг та ч орсон байгаа байх. Гэвч тэндээс Их Хурал руу шийдвэр ороогүй. Буцаагаад Засгийн газар луу явуулсан байгаа.

Тэгээд эдгээр хуулиудаас ядаж ганц хуулийг нь шүү дээ. Ганц хуулийг нь тодотголын үеэр оруулсан. Тэгээд хэлэлцэх нь битгий хэл хэлэлцүүлэг ч үгүй бүгдийг нь буцаасан. Та маш сайн санаж байгаа байх.

Тэгэхээр ер нь энэ зардлуудаа бууруулах дээр хуулиудаа барьж авах дээр зоригтой хөдөлцгөөсөн нь дээр байх. Бүгдээрээ. Ер нь санал бэлэн болсон. Хүргүүлсэн байгаа. Орлогоо нэмнэ гэж байгаа юм. Магадгүй манай борлуулалтууд нэмэгдээд, орлого нэмэгдэж магадгүй.

Гэхдээ бид орлого нэмэгдсэний хэрээр алдагдал буурна уу гэхээс зардлаа нэмж чадахгүй. Нөгөө 24 хувь гэсэн хязгаартаа л баригдана. Ийм хайчин дунд байгаа гэдгийг хэлье.

Яах вэ, Ирээдүй өв санг Эдийн засаг, хөгжлийн яамнаас асуух шиг боллоо. Зүгээр би зүгээр саналаа хэлье.

Тэр Ирээдүй өв сан дээр одоо хүн харахад мөнгөтэй болсон байгаа байхгүй юу. Өмнө нь зүгээр дансны хуулга дээр байсан юм. Одоо тэр чинь

эхлээд найдвартай байх хэрэгтэй, хөрвөх чадвартай байх хэрэгтэй. Түүний дараа өгөөж хайж болно уу гэхээс одоо тэрийг зүгээр нэг хувьцаанд аваачиж хийгээд Монгол Улсынхаа зээлжих зэрэглэлийг нөөцөө алдаж болохгүй.

Бага хүүтэй гэж байгаа юм. 4.3-аас 4.8 хувийн хүүтэй Английн Төв банк, Люксембургийн Төв банк дээр байгаа юм. Хамгийн найдвартайгаар. Ингээд энэ жилдээ 96 тэрбум төгрөгийн өгөөж авч байгаа юм. 96 тэрбум шүү. Энэ ч бас бага мөнгө биш. Тэгэхдээ найдвартай бөгөөд манай Монгол Улсын валютын нөөц дээр тооцогдож байгаа.

Хэрвээ тэрийг аваад нэг хувьцаа худалдаад авах юм бол нөгөө 5.7 тэрбум гээд байгаа нөөц маань шууд 1.5 тэрбум доллароор багасаад бид маргааш нь гэхэд л зээлжих зэрэглэлээ буцаад нөгөө 12 жилийн өмнө алддаг шигээ алдана.

Тэгэхээр тал талын юмнууд бодож байж энэ Ирээдүй өв сангийнхаа мөнгөнд хүрэх хэрэгтэй. Ямар ч байсан үүнийг дансыг нь бүрэн бүтэн болгоод өнгөрсөн жилүүдэд найдвартай хадгалж байгаа. Бас өсөж байгаа.

О.Номинчимэг: 2 номер.

И.Батхүү: С.Эрдэнэбат гишүүний асуултад нэмэлтээр хариулъя.

Урсгал зардлын хувьд яг сүүлийн жилүүдэд ямар чиг хандлагатай байгаа талаар танд мэдээлэл танилцуулъя.

- Номинал дүнгийнхээ хувьд:
 - 2024 онд 22.1 их наяд төгрөг,
 - 2025 онд 23.9 их наяд төгрөг,
 - 2026 оны төсвийн төсөлд 24.6 их наяд төгрөг

гээд номинал дүнгээрээ өсөлттэй явж байгаа.

- Дотоодын нийт бүтээгдэхүүн эзлэх хувийн хувьд:
 - 2024 онд 27.5 хувь,
 - 2025 онд 26.6 хувь.

Бидний зорьж байгаа нь 2026 онд 24 хувь болгоё гэж буурч байгаа.

Шалтгаан нь сүүлийн жилүүдэд урсгал зардал хэт өндөр өсөлттэй байсан.

- 2024 онд гэхэд 30.0 хувийн өсөлттэй.
- 2025 онд 8.0 хувийн өсөлттэй байсан.

Энэ хэт өсөлт нь хөрөнгө оруулалтын зардалтай харьцуулахад урсгал зардлын эдийн засагт үзүүлэх үржүүлэгчийн нөлөө нь бага байдаг учраас.

Хоёрдугаарт нь, инфляцад үзүүлэх дарамт нь өндөр байдаг учраас бууруулъя гэж ярьж байгаа.

Энэ тал дээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гээд холбогдох мэргэжлийн байгууллагуудаас байнга санал, дүгнэлтүүд өгч байдаг.

О.Номинчимэг: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл. 4 номерын микрофон өгье.

Р.Ринчинбазар: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл. Р.Ринчинбазар.

Тэгэхээр Ирээдүй өв сангийн хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх боломжийг хайх хэрэгтэй байна гэдэг тийм дүгнэлт. Тэгэхдээ энэ хүрээн дээр биш, төсвийн гарсан дүгнэлт дээр бичсэн зүйл шүү.

Нэг талаар Б.Жавхлан сайдын хэлдэг зөв. 2030 он хүртэл гар дүрэхгүй байх хуультай. Замд нь хуульд өөрчлөлт ороод зарцуулж байсан тохиолдол бий.

Тийм учраас эхний ээлжид ямар ч байсан Ирээдүй өв сангийн хөрөнгө найдвартай байршиж байх ёстой гэж.

Зүгээр бидний хийсэн дүгнэлт юу гэхээр энэ 4 орчим хүүтэй. Тэгтэл нөгөө гадаад зах зээлээс Монгол Улсын Засгийн газар босгож байгаа бонд 6 орчим хүүтэй. Ингээд хүүгийн зөрүү байгаа. Үүнийг анхаараарай гэсэн байдлаар бичсэн байгаа. Тэгэхдээ үүнийг тэр бонд руу хийх нь эрсдэлтэй.

О.Номинчимэг: С.Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: Бид гадаадад 4 хувиар хадгалаад, өөрсдөө буцаагаад 7 хувиар зээл аваад байгаа байхгүй юу.

Тэгээд ямар ч эрүүл хүний ухаанаар бодсон өөр хүмүүст аваачиж мөнгөө 4 хувьд хадгалангуутаа буцаагаад 7, 8 хувиар аваад байхаар чинь зардал өсөх нь ойлгомжтой шүү дээ.

Тэгээд тэр мөнгөөр бонд ав гэж ерөөсөө хэлээгүй. Өөрөөр хэлбэл тэр Ирээдүйн өв сангийнхаа мөнгийг эргээд Монголынхоо дотоод зах зээл рүү, энэ өндөр хүүтэй, 20, 30 хувийн хүүтэй. Бизнес хийхэд 20, 30 хувь. Хэрэглээний тэр бизнесийг дэмжиж байгаа шүү дээ. Энэ тэтгэвэр, цалин чинь өөрөө нөгөө талаараа хүн аваад гудсан доороо хадгалахгүй шүү дээ. Мөнгө аваад. Яаж байна вэ гэхээр нөгөө эдийн засаг буюу ажлын байр бий болгож байгаа энэ

олон мянган жижиг, дунд үйлдвэрлэл, том татвар төлж байгаа гээд байгаа хүмүүсийн чинь л бараа, үйлчилгээг худалдаж авч байгаа байхгүй юу.

Тэд нар чинь эргээд төсөвт татвараа төлдөг. Тэгээд ийм зүйл дээр л би хэлээд байгаа юм.

О.Номинчимэг: Үг хэллээ. Тийм ээ. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? 2 дугаар зүйл бол дагаж мөрдөх хугацаа байгаа. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? С.Эрдэнэбат гишүүнээр тасалъя. С.Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Би энэ төсвийн хүрээний мэдэгдэл дээр тэр урсгал зардлыг тэр 24 хувьд барих гэдэг зүйлийг өөрчилмөөр байна.

Сая гишүүд хэлж байх шиг байна. Одоо бид ирэх жил төдийгүй тэрний дараах 2 жилийг дахиад тийм байдлаар төсөөлөх байдлаар урсгал зардлыг хязгаарлаад явбал үндсэндээ бид, улс төрийн намууд ч гэсэн бүгдээрээ, Засгийн газар ч гэсэн тэр хүмүүсийн бодит орлого нэмэгдүүлэх ямар ч боломж байхгүй.

- Цалин нэмэхгүй гэсэн үг.
- Тэтгэвэр нэмэхгүй гэсэн үг.

Та нар нэг юм боддоо. Манай төсөв, сангийнхан. 29 мянган хүүхдээр энэ жил нэмэгдэж байгаа байхгүй юу. Хүн ам чинь огцом өсөж байна. Нөгөө 2000 оны үед огт хүрэхгүй байж байгаад эргээд эдийн засаг жоохон сайжрангуут нь маш их төрөлт бий болсон. Тэрийг чинь дагаад эрүүл мэндийн үйлчилгээ, боловсролын үйлчилгээ, сургууль, цэцэрлэг, түүнийг дагасан хүний нөөцийн нэмэгдэл хэрэгтэй. Эсвэл хүн амын өсөн нэмэгдэж байгаа ирэх жилүүдэд нэмэгдэх тэр зүйлийг шийддэг үндсэн арга нь урсгал зардал.

Одоо эрүүл мэнд дээр Та нар хараарай. Эмнэлгүүд дээр очоод хараарай. Бүгд зардлаа хязгаарлалтаар орж байна. Одоо дахиад өнөөдрийн тэр урсгал зардлын хязгаар дотор эрүүл мэндийнхээ санд тодорхой хэмжээний мөнгө нэмж хуваарилахгүй бол дахиад хязгаарлалтууд явна. Эмнэлгүүд дээр дахиад өвчтөнүүдийн эмнэлгийн үйлчилгээнүүдийг хязгаарлана. Мөнгө авна. Боловсрол дээр яах вэ гэхээр дахиад бид сургууль барих хэрэгцээ байгаа.

Тэгэхээр хүмүүсийн бодит худалдан авах чадваруудыг нь бүгдийг нь жил болгон дунджаар 8, 10 хувиар унагаад, нөгөө хүмүүсийн бодит орлого сайжруулах биш. Тэгээд энэ төсөв хэнд хэрэгтэй юм тэгвэл.

Тэгээд хэдэн тоо тавингуутаа түүндээ нийцүүлнэ гээд. Би ойлгож байгаа. Тэр инфляцаа барих, тодорхой хэмжээний зарлагаа хязгаарлах гээд. Тэгээд яг бодит байдал дээр чинь Та хэд тэр эмнэлгүүдээр яваад үз. Боловсрол дээр тэр 70, 60 хүүхэдтэй сууж байгаа хүмүүсээ яваад үз. Цэцэрлэгээр яваад үз. Яг ний нуугүй хэлэхэд төрийн албан хаагч нар ч гэсэн тойрч суучхаад... /минут дуусав/

О.Номинчимэг: 2 дугаар заалт дагаж мөрдөх хугацаа байгаа. Цөмөөрөө дэгээ барьж явъя. Тэгэх үү? Тийм.

Гэхдээ та дагаж мөрдөх хугацаатай холбоотой зарчмын зөрүүтэй санал гаргах гэж байгаа юу, үгүй юу гэдэг л асуудал дээр байгаа шүү дээ. Тийм.

Таны хэлж байгаа 24 хувьтай холбоотой асуудал 2026 оны төлөвлөгөө Улсын Их Хурлаар батлагдсан. Хэрвээ та томъёоллоо бэлдээд ороод ирсэн бол түрүүн 1 дүгээр зүйл дээр ярилцах боломжтой байсан. Томъёолол бэлдэж ажлын албанд өгсөн байгаа юм уу? Эсвэл зүгээр л санал, байр сууриа илэрхийлж байгаа юм уу?

Харин тийм. Зарчмын зөрүүтэй санал маань байхгүй. Тийм. 2 дугаар зүйл рүү явсан хойно. 2 дугаар зүйл чинь дагаж мөрдөх хугацаа байгаа шүү дээ. Эсвэл та Эдийн засгийн байнгын хороо яг энэ гол асуудал эдийн засгийн төлөвлөгөө. Бид танилцуулгаа Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэх байгаа.

Түүн дээр үүнийг илүү тэр 24 хувийг яах вэ, ийх вэ гэдэг дээр нэлээн нарийн ярилцах байх гэж бодож байна. Тэгвэл тэн дээр С.Эрдэнэбат гишүүн саналаа гаргах уу? Тэгээд одоо алх тогшоод явсан болохоор юу яая тэгэх үү? С.Эрдэнэбат гишүүн ээ.

2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн алга байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Өргөдлийн байнгын хорооны танилцуулга, санал, дүгнэлтийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ.

Хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Дараагийн асуудалд оръё. Санал, дүгнэлтийг танилцуулах Улсын Их Хурлын гишүүнийг томилох юм байна. Төсөв болон Эдийн засгийн байнгын хороон дээр. Тэнд харьяалалтай гишүүд байгаа билүү. Эдийн засгийн байнгын хороонд танилцуулга санал, дүгнэлтийг Г.Лувсанжамц гишүүн танилцуулъя.

Төсвийн байнгын хороонд хамтарч хэлэлцэх юм шиг байна. Тэгэхээр Г.Лувсанжамц гишүүн танилцуулъя.

Дараагийн асуудалд оръё.

**Хоёр.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай,
Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай,
Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай,
Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд
/Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хоёр дахь хэлэлцүүлэг,
танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./**

Хоёр.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Өргөдлийн байнгын хороо Монгол Улсын Засгийн газраас 2026 оны төсвийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн хэлэлцүүлгээр иргэд, олон нийтээс гаргасан саналууд төсвийн төсөлд тусгагдсан, эс тусгагдсан талаарх асуудлыг хэлэлцэнэ.

Мөн Өргөдлийн байнгын хороонд олон нийтээс ирж байгаа санал, нийтийн өргөдлийн системээр дамжуулан ирж байгаа өргөдлүүдийн хүрээнд энэ асуудлыг хэлэлцэхээр байгаа.

Сангийн яамнаас ирүүлсэн олон нийтийн хэлэлцүүлгийг тайланг Та бүхэнд Өргөдлийн байнгын хорооны гишүүнд хүргүүлсэн байгаа болно.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Сайд нар гараад явсан уу? С.Бямбацогт сайд тэргүүн дэд даргаа үлдээе гэсэн. Тэргүүн дэд дарга нь хаана байна? Дуудаарай. Хэрэг эрхлэхээс Мөнх-Эрдэнэ дарга түрүүн тэнд сууж байсан. Гол нь Хэрэг эрхлэх газар шүү дээ. Энэ дээр. Байна уу? Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Д.Мөнх-Эрдэнийг дуудъя.

П.Наранбаяр Боловсролын сайд ирсэн байна. Ж.Чинбүрэн Эрүүл мэндийн сайд ирсэн байна. И.Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ж.Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Х.Батжаргал Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ц.Наранчимэг Санхүүгийн аудитын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор, С.Нацагдорж Санхүүгийн аудитын газрын менежер, Ю.Энхтуяа Гүйцэтгэлийн аудитын газрын

менежер. Аудитынхан байхгүй байна. Аудитынхан бүгдийг нь оруулаарай. Хоёрдугаар асуудал эхэлсэн гээд.

Э.Баттогтох Нийцлийн аудитын газрын менежер, Т.Баясгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ж.Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, С.Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, С.Батбаатар Стандарт, хэмжил зүйн газрын дарга, Я.Гантөмөр Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, Б.Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, О.Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Ц.Мөнхдэлгэр Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга, Т.Мөнх-Эрдэнэ Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, ар талын газрын Санхүүгийн хэлтсийн дарга. Онцгой байдлынхан байхгүй байх шиг байна. Тийм үү? Энд ирсэн байна уу?

Ийм албан тушаалтнууд хоёрдугаар асуудал хэлэлцэх хүрээнд оролцож байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т Байнгын хорооны хуралдаанд гишүүд тухайн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагч, Монгол Улсын Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, үг хэлнэ.

Төсвийн төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга нь хаана байгаа юм. Өмнөх гишүүд маань байна. Тийм ээ. Энэ хүмүүсээс гишүүд асуулт асууж, үг хэлж болно.

Төсвийн хууль болон дэгийн хуульд оруулсан шинэ дэгийн дагуу бид анх удаа төсөв хэлэлцэж байна. Дээр нь манай Байнгын хороо шинэчилж анх удаа байгуулагдаад эрхлэх асуудлын хүрээний хувьд гарч байна.

Тийм учраас хоёрдугаар хэлэлцүүлэг ерөнхийдөө асуулт асууж, үг хэлэхээр зохицуулалттай байгаа. Гуравдугаар хэлэлцүүлгээс зарчмын зөрүүтэй санал гаргахаар дэгийн хуульд тусгасан байгаа гэдгийг гишүүддээ хэлье.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар асуулт асуух гишүүн нэрсээ өгнө үү. С.Эрдэнэбат гишүүнээр тасалъя. Ирцийн дагуу Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Нэлээн олон асуулт байгаад байна.

Нэгдүгээрт, саяын тэр 24 хувийн хязгаарыг өөрчлөх боломж дээр манай Засгийн газар өөрөө ямар байр суурьтай байгаа юм бэ? Их Хурал шийдвэл бид

асуудалгүй оруулаад ирье гэж ийм байр суурьтай байна уу? Эсвэл ерөөсөө төсвийн урсгал зардлын 24-ийн хязгаарыг өөрчилье. Тийм сонирхол байх байхгүй байна уу гэдэг ийм хоёр байр суурийг Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яамнаас асууя.

Хоёрдугаарт, эдийн засгийн тэр төлөвлөгөөний дагуу жил болгон цалин хөлсийг нэмнэ гэсэн байгаа. Тэгээд үүнийг яагаад үндэслэж оруулж ирээгүй юм бэ гэдгийг асуумаар байна.

Гуравдугаарт, боловсролын салбар дээр төсвийг 200 тэрбумаар түрүү жил тодотголоор хассан. Одоо эргээд 100 тэрбум орчим төгрөгөөр нэмэгдүүлж орж ирсэн. Тэр урсгал зардал гэдэгтэй холбоотой. Хувьсах зардал гэдэгтэйгээ холбоотой. Үүнийг дахиад нэмэх. Боловсролын сайдаас асууя.

Энэ төсвүүд яг одоо та бүгдийн энэ багш нар, боловсролын энэ үйлдвэрчний эвлэлийн тавиад байгаа санал, шаардлагыг хэрэгжүүлэхэд яг хэдэн төгрөгийн хэрэгцээтэй байгаа вэ?

Эрүүл мэндийн салбараас. Ирэх жил урсгал зардал дээрээ эрүүл мэндийн салбар мөнгө нэмээгүй байна лээ. Тэгэхээр одоо энэ өсөн нэмэгдэж байгаа иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээний хэрэгцээг гүйцэтгэлээр нь аваад үзэх юм бол энэ чинь бараг дахиад 300, 400 тэрбум байтугай төгрөг хэрэгтэй мэт харагдаж байна лээ.

Тэгэхээр дотор нь зохицуулаад гэдэг чинь өөрөө нэг талаараа жоохон эрсдэлтэй. Ж.Чинбүрэн сайд аа. Та аягүй сайн мэдэж байгаа. Урт хугацаандаа хийх ёстой. 2, 3, 4 жилийн хугацаандаа тэр буруу, зөрүү талаар гараад байгаагаа.

Тийм учраас хөрөнгө оруулалт, урсгал зардал хоёрын өсөлт гэдэг зүйлээ харьцааг нь авч үзээд. Магадгүй зарим хөрөнгө оруулалтаа гаргах зардлуудыг нь дунд нь тодорхой хугацааг нь жоохон нэмдэг юм уу, эсвэл шинээр эрүүл мэндийн салбар дээр төсөв, урсгал зардал дээр нэмж тавихгүй хэцүү. Бид өвөл, магадгүй Их Хурлын гишүүд бүгдээрээ энэ өвдсөн, зовсон хүмүүсийн жагсаал, цуглаан, шаардлага элдэв асуудалд дарагдах, өөрсдөө амаа асуулгах ийм зүйл рүүгээ орох байх шүү.

Өчигдөр бид сонссон. Нэлээн хүнд юмнууд сонсогдож байна лээ. Ийм зүйлийг тодруулж асуумаар байна.

Дээрээс нь ахмадын тэтгэврийн зээлийн асуудал гээд дараа дараагийн хэлэлцэх асуудал байж байгаа. Энэ асуудал дээр өчигдөр банкуудтай уулзахад манай яам болон Засгийн газраас санал ирээд, дараа нь Монголбанк оролцохгүй гээд арилжааны банкнууд нь ер нь бид энэ ахмадын тэтгэврийн зээлийг заавал аймаар хязгаарлаад байх ч тийм айхтар өндөр сонирхол байхгүй гэж өөрсдөө яриад байгаа юм.

Тэгээд энэ дээр хэн цаагуур нь багасга гэдэг ийм чиглэл өгөөд байгаа юм? Сангийн яам өгөөд байгаа юм уу? Засгийн газар өгөөд байгаа юм уу? Энэ тал дээр нэг тийм байр суурь байна уу?

О.Номинчимэг: Хэд хэдэн асуулт асуулаа. Хуралдаанд бас Т.Аубакир Гэр бүл, нийгмийн хамгааллын сайд оролцож байна.

Эхний асуулт 26 хувьтай холбоотой төсвийн зардлын хэмжээтэй. 24 билүү? Эдийн засаг, хөгжлийн яам Төрийн нарийн бичгийн дарга. 2 номерын микрофон.

И.Батхүү: С.Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя.

2026 оны төсвийн төсөл дээр урсгал зардлын хэмжээ маань 24.6 их наяд төгрөг байгаа.

Тэгэхээр сая дурдагдсан асуудлуудаар ямархуу хэмжээний төсөв хуваарилах гэдэг нь заавал урсгал зардлын эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр шийдэх боломжтой байх гэж харж байна.

Яагаад 24 хувийг өсгөх нь зохисгүй вэ гэдэг тал дээр эдийн засагчид маань олон удаа ярьж байгаа. Хөрөнгө оруулалтын зардалтай харьцуулалт урсгал зардлын хэмжээ сүүлийн жилд эрс огцом нэмэгдэж ирсэн. Үүнийгээ дагаад эдийн засагт үзүүлэх үр нөлөө маань багасаад байна. Төсвийн үр ашигтай зарцуулалт, үр өгөөж нь муу байна гэдэг дүгнэлтүүд их хийгдэж байгаа.

Тэгэхээр энэ дээр 24.6 их наяд төгрөг байгаа учраас энэ дотроо зохицуулах боломжтой гэж үзэж байна

Хоёрдугаарт, зардлын хэмжээг нэмэгдүүлбэл төсвийн хүрээний мэдэгдэл дээр байгаа суурь тэнцлийн 2 хувийн ашигтай байх гэдэг заалт маань зөрчигдөх аюултай байгаа.

Тэгэхээр зардлын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр дотор нь өөрчлөлт хийх талаасаа л гаргалгаа байгаа юм болов уу гэсэн бодолтой байна.

О.Номинчимэг: Ахмадын тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой асуудал дээр Т.Аубакир сайд.

Т.Аубакир: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе.

Тэтгэврийн зээлтэй холбоотой асуулт тавьж байна. Өчигдөр С.Эрдэнэбат төлөөлөлтэй уулзсан. Тэтгэврийн зээлийн хүүг буулгах бололцоо бий юу гэж.

Арилжааны банкны зүгээс ямар шаардлага тавьж эхлэх вэ гэхээр манай салбар дээр зарим сангуудын чөлөөт үлдэгдлүүд байдаг. Энэ сангуудын чөлөөт үлдэгдлүүд маань Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулагддаг. Зориулалт нь хүүгийн зээлийн зөрүүг олгох гэсэн зүйл байхгүй.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны зүгээс болон Монголбанкны зүгээс арилжааны банкн дээр тэтгэврийн зээлд тодорхой хэмжээний хязгаарлалт тавиач гэсэн ямар ч асуудал байхгүй. Энэ өнгөрсөн 6 сараас эхлээд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголбанкт хамтраад 50, 50 гэж байсныг хугацааны хувьд хязгаарлалт байсныг бүгдийг нь чөлөөлж өгсөн. /минут дуусав/

О.Номинчимэг: Гүйцээж хариулъя. Т.Аубакир сайдын микрофоныг өгье.

Т.Аубакир: Одоо тэтгэврийн зээлийн зохицуулалтыг хийх бүрэн гарт нь байгаа байгууллагууд зөвхөн энэ арилжааны банкнууд байгаа. Иргэн “Б”-д зээлээ хэдий хугацаатай, ямар хувь хэмжээтэй өгөх вэ гэдгийг зохицуулалт хийх нь зөвхөн арилжааны банкны асуудал болж үлдсэн байгаа.

Монголбанкны зүгээс болон манай Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны зүгээс ямар нэгэн хязгаарлалт байхгүй.

Хоёр гишүүн маань өчигдрөөс эхлээд ажиллаад эхэллээ. Зээлийн хүүг тодорхой хэмжээнд бууруулах, түүнд нь төсвийн болоод зарим тусгай сангуудын үлдэгдлүүдийг ашиглах ямар боломж бололцоо байна вэ гээд ажиллаад эхэлж байгаа. Энэ эргээд эцэстээ зарим нэг хуулиудыг өөрчлөх асуудал дээр л очиж үлдэх байх.

Тийм учраас Монголбанк болон манай яамны зүгээс тэтгэврийн зээл дээр ямар нэгэн хязгаарлалт тавихыг дэмжихгүй байгаа.

О.Номинчимэг: Эрүүл мэндийн сайд. Урсгал зардалтай холбоотой асуулт асуусан.

Ж.Чинбүрэн: С.Эрдэнэбат гишүүн чухал зүйл ярьж байгаа. Энэ дээр бүгдээрээ л санаа зовж байна.

Урсгал зардал, хөрөнгө оруулалт хоёрын харьцаа. Улсын төсөвт ер нь 270.0 тэрбум төгрөг. Энэ бол нөгөө 36 сарын тэтгэвэрт гарахад авдаг гол мөнгө л байгаа. Түүнээс өөр нэг их урсгал зардалд ороод байх санхүүжилт байхгүй.

Яг улсын төсвийн хөрөнгө оруулалт 211.6 тэрбум. Харин бид өнөөдөр Их Хуралд өргөн бариад байгаа гаднын хөрөнгө оруулалт, зээл, тусламж 1.2 их наяд төгрөг буюу энэ бол нөгөө төсөвт ачаалал болохгүй бусад хөрөнгө оруулалтаар хийх гэж байгаа ажлуудын л ийм хөрөнгө оруулалт байгаа.

Зарим гишүүд үүнийг андуурч, ийм их мөнгө байгаа бол тэрийгээ шууд даатгалдаа оруулаач ээ. Тэгээд даатгалаараа дамжуулаад цалин хөлсөө нэмэх боломж байхгүй юм уу гэсэн... /минут дуусав/

О.Номинчимэг: 1 минут нэмж өгье. Ж.Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр мөнгөний боломж нь өөрөө хязгаартай байгаа учраас бид энэ дээр нэмэх боломжгүй байгаа юм.

Тэгэхээр гол санаа бол би С.Эрдэнэбат гишүүнд бас хэлэх гээд. Түрүүн асууж байх шиг байна. Юуг өөрчилж болох юм бэ гээд байгаа юм. Тийм ээ.

Тэгэхээр төсвийн тооцоолол хийдэг, төсвийг бүртгэдэг бүртгэлийн системээ өөрчлөөд Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгал, хувь хүний эрсдэлээ даатгуулж байгаа даатгалын мөнгийг урсгал зардалд тооцдоггүй л болговол энэ тэлэх боломж гарах юм.

Тэгэхээр энэ дээр гишүүд маань анхаарч өгөөч ээ л гэж гол хүсэх зүйл байна. Ингэх юм бол бид Эрүүл мэндийн даатгалын сангаа 3 их наяд руу аваачих. Ингээд ирэх юм бол бид цалин хөлсөө нэмэх бүрэн боломж нэмэгдээд явах харагдаад байгаа.

О.Номинчимэг: Боловсролын салбартай цалин хөлстэй холбоотой асуудал. П.Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Уучлаарай. Микрофон нь асуудалтай.

Тэгэхээр өнөөдрийн байдлаар бид 2026 оныхоо урсгал төсвийг 3.9 их наяд төгрөгөөр өргөн барьчхаад үүнээс цалингийн санд нь 2.8 их наяд төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байгаа.

Бидний хийсэн тооцоогоор жишээлбэл багш нарынхаа цалинг 25 хувиар хэрвээ нэмэгдүүлье гэвэл 560.0 тэрбум төгрөг шинээр шаардлагатай. Өнөөдөр хувьсах зардалд нь шингээсэн байдлаар 100 тэрбум төгрөгийн орон зай гаргасан.

Хэрвээ 3.5 сая руу оруулъя гэвэл 3.3 их наяд төгрөг шинээр шаардлагатай ийм нөхцөл байдалтай байгаа.

Тэгэхээр энэ урсгал зардал дээр явдаг цалин хөлсийг нэмэгдүүлэхэд бид түрүүн олон гишүүд яриад байгаа тэр 24 хувийн асуудал байгаа... /минут дуусав/

О.Номинчимэг: 1 минут нэмж өгье. П.Наранбаяр сайд.

П.Наранбаяр: 24 хувийн асуудал байгаа. Тэгэхээрээ энэ бол дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх зарлагынх нь хувь хэмжээг бид улсынхаа төлөвлөгөөнд 24 хувь гээд заагаад оруулсантай холбоотой.

Хуулиар 30 хүртэл хувийг зөвшөөрсөн байгаа. Хэрвээ 30 хүртэл хувь дээр нь бид хэрвээ орон зайг тэлж чадах юм бол нэг ойролцоогоор 5 их наяд төгрөг бас боломжтой болох юм байна гэж харж байгаа.

Гэхдээ энэ бол нөгөө төсвийн орлого биш, шууд төсөв дээрээ энэ шууд зарлагдаад явах учраас инфляцад нөлөөлөх нөлөөг тооцох ёстой гэж харж байгаа.

С.Эрдэнэбат гишүүний яриад байгаа тэр бичилтийн асуудал. Сая Ж.Чинбүрэн сайд бас хэлж байна. Энэ асуудлаа бид цэгцэлж чадах юм бол зарим нэг хэмжээнд цалин нэмэх боломжийг бий болгож байна гэж харж байна.

Өнөөдөр Та бүхэн мэдэж байгаа. Боловсролын салбар жагсаад цалингаа нэмэх шаардлага тавиад байгаа. Бусад салбаруудад нөхцөл байдал хүнд байгаа. Тэгэхээр аль аль тал дээрээ бид бодож төсвийнхөө өнөөдрийн орон зайг хэрхэн бий болгох вэ гэдгийг л Улсын Их Хурал дээр... /минут дуусав/

О.Номинчимэг: С.Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: Манай эдийн засагч нар гээд байдаг. Ямар эдийн засагч нар тийм тооцоо хийгээд байгаа юм бол. Ер нь бараг цалин, тэтгэвэр нэмэхгүй, ямар ч үр ашиггүй л гэж хэлэх гээд байна л даа.

Тэгэхээр энэ тал дээрээ тодорхой хариулт өгөх хэрэгтэй байна.

Хоёрдугаарт, та хэд энэ төсөв дээрээ. Би дахин л хэлээд байгаа. Энэ нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын мөнгө чинь төрийн мөнгө биш шүү дээ. Хүмүүс өөрсдөө мөнгөө төлөөд, татвар, шимтгэлээ төлөөд буцаагаад үүнийгээ эв санааны нэгдлийн зарчмаар хэрэглэж байгаа мөнгө. Тэрийг аваачиж төсвийн урсгал зардал дотор оруулж ирээд тэгээд урсгал зардал аягүй өндөр байна гэдэг юм яриад байгаа байхгүй юу.

Тэгэхээр бичилтийнх нь асуудал гэдэг юм уу, энэ зүйлээ. Тодорхой хугацаа орох юм шиг байна лээ.

Гэхдээ мөн чанарын хувьд, төсвийн юуны хувьд аваад үзэхэд наадах чинь урсгал зардалд тэр төр хариуцдаг хэсэг нь л орно уу гэхээс биш иргэдийн өөрсдийн төлөөд буцаад өөрсдөө үйлчилгээгээ авч байгаа бүр тусдаа бие даасан сан байх ёстой юмыг урсгал зардал руу оруулж ирээд.

Тэгээд энэ бол ер нь тэгээд цаагуураа тэр урсгал зардлыг ямар нэгэн аргаар нэмэхгүй гэдгийн цаана цалин хөлс тэтгэвэр, тэтгэмжээ нэмэхгүй л гэсэн... /минут дуусав/

О.Номинчимэг: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл ярих уу? Эдийн засаг, хөгжлийн яам уу? Эдийн засаг, хөгжлийн яам. 2 номерын микрофон.

И.Батхүү: Багш, эмнэлгийн ажилтнуудын цалинг нэмэхгүй гэдэг асуудал ерөөсөө яриагүй. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, 24.6 их наяд төгрөгийн урсгал зардлыг нэмэгдүүлэхийг заавал энэ цалингийн нэмэгдэлтэй холбож тайлбарлаад байгаа бас зохистой биш байх гэж ойлгож байгаа.

Урсгал зардал дотроо ямар зардалд нь ямар хэмжээний дүн хуваарилах вэ гэдэг өөр асуудал байгаа. Үүнийгээ шууд 24 хувьтай холбож тайлбарлаад байгаа нь зохисгүй байх л гэсэн тайлбар хэлье.

Тэгээд ерөнхий зардлын хэмжээг нэмэгдүүлж саяын асуудлуудыг шийдье гэвэл төсвийн тусгай шаардлага маань зөрчигдөх гээд байгаа. Суурь зарлагын хэмжээ 2 хувиас дээш ашигтай байна гэж заалттай. Төсвийн тусгай шаардлага. Яг одоо өргөн барьсан төсөл дээр 2 хувьд нь тулгасан байгаа юм.

Тэгэхээр зардлаа хий байдлаар нэмэгдүүлье гэвэл орлогоо дахиад худал төлөвлөх асуудал руу орох гээд байгаа. Тэгэхээр зарлагыг нэмэгдүүлэхгүй, байгаа зардал дотроо оновчтой хуваарилалт хийх асуудал гэж үзэж байна.

О.Номинчимэг: С.Эрдэнэбат гишүүн дахин тодруулъя.

С.Эрдэнэбат: Урсгал зардал тойроод л үзэх гээд байх шиг байна.

Одоо энэ хөрөнгө оруулалт гэдэг зардал дотор чинь үр ашиггүй зүйлүүд их байна шүү дээ. Зарим нь бараг 2, 3 сум хүртэл тийм ямар ч засмал зам, даваагүй, гүүр ч байхгүй байж байхад зарим сум дээр нь аваачаад сум доторх засмал зам засна гээд тавьсан. Нуур луу нуур үзэхийн тулд тийшээ зам тавина гээд тавьсан.

Тэгээд энэ чинь үр ашигтай зардал юм уу? Жингийн туухайн дээр аваад үзэх юм бол ярих юм их байна.

Тийм учраас Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам энэ үр ашиггүй зардлынхаа хойшлуулж болох, тэвчиж болох тийм зардлуудаа хойш нь татаад оруулаад ирэх боломж байгаа шүү дээ. Та хэдэд.

24 хувь дотор тэгвэл урсгал зардал юу танамаар байгаа юм? Хэлчих тэгвэл. Та нар энэ төсөв зохиож байгаа шүү дээ. Ямар үр ашиггүй зардал урсгал зардал дотор байгаа юм? Би хайгаад олохгүй байна. Урсгал зардал дотор чинь.

Одоо энэ бүх байшингууд чинь цаанаа дотор нь хүн ажиллана, халаалт дулаан нэхнэ.

О.Номинчимэг: Урсгал зардлаас чинь хасах юм байгаа юм уу гээд маш тодорхой асуулаа шүү дээ. Хэн хариулах юм? 6 номер хариулах юм уу? Сангийн яам хариулах юм уу? Эдийн засаг, хөгжлийн яам хариулах юм уу?

6 номер. Ж.Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга.

Ж.Ганбат: Ийм л юм хэлэх гээд байгаа юм. Сая хийсэн төсвийн тодотголоо төсвийн орлогыг 3.3 их наядаар, зардлыг 2 их наядаар хассан тодотгол батлагдсан.

Бид сая Улсын Их Хуралд өргөн барьсан 2026 оны төсөв дээр зардлыг нэлээн бууруулаад ингэсэн. Тэгээд тэр 24 хувьдаа бариад. Ер нь бид аль болох л урсгал зардлыг нэмэгдүүлэх ийм бодлого барьж байгаа шүү дээ.

Нөгөө талдаа бид төрийн оролцоог багасгана гэдэг юмыг сүүлийн үед нэлээн эрчтэй ярьж байгаа. Бид хувийн хэвшлээр хийх бололцоотой бүх үйлчилгээнүүдийг ер нь энэ төсвөөс гаргая гэдэг ийм бодлого барьж байгаа шүү дээ. Хэд хэдэн удаа оролдлогууд бид хийж байсан. Ялангуяа ТҮ-нүүдыг бид хувийн хэвшилд гаргая гэдэг алхам хэд хэдэн удаа оролдлого хийгээд бас дэмжлэг аваагүй.

Тэгэхдээ бид урсгал зардлыг хязгаарлаж байж бид энд хувийн хэвшлээрээ хийлгэх бололцоотой ажил, үйлчилгээнүүдийг хувийн хэвшил рүү шилжүүлэхгүй бол урсгал зардлаа нэмээд л, бид цалин, тэтгэврээ нэмээд л байх юм бол нөгөө талдаа хувийн хэвшил рүү гарах хүмүүс чинь энэ төр дээрээ байгаад л байна гэдэг ийм л байдлаар. Бид ингээд бүх юмыг... /минут дуусав/

О.Номинчимэг: 4 номер. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хариулъя.

Р.Ринчинбазар: Би ерөнхий ганцхан тоо Та бүхэнд сануулъя.

Энэ 2010 онд Монгол Улсын төсвийн зарлага 3 их наяд орчим. 2024 онтойгоо харьцуулахад 30 их наяд. 10 дахин нэмэгдсэн. Мөн үү. Тэгвэл энэ нийгмийн үйлчилгээ, боловсрол, соёлын хүртээмж, чанар, энэ бүх юм 10 дахин нэмэгдэж чадсан уу гэвэл худлаа. Зарим үзүүлэлт нь дордсон байгаа.

Тэгэхээр энэ зардал нэмснээр асуудлыг ерөөсөө шийдэхгүй юм байна гэдэг. Яах вэ, цаана нь зүгээр үр ашгийн асуудал, алдагдсан боломж гэдэг юм

уу тэр өөр яриа байж болно. Гэхдээ зардал нэмээд өнөөдөр асуудлаа шийдсэнгүй гэвэл худлаа байгаа байхгүй юу.

Тэгээд энэ төсвийн байгууллагын зардлыг хараарай. 80 хувь нь цалин, урамшуулал. Тэгээд үүнийг чинь одоо ингээд нэмээд дээш нь татсан юмыг чинь яаж буулгах юм. Бололцоо байхгүй шүү дээ. Хүний цалин хасах юм уу. Тэгээд энэ чинь ТҮ-гээс бусад төрийн албаны цалинг чинь 2023, 2024 он дамжуулаад... /минут дуусав/

О.Номинчимэг: Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуулт асууя.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе.

Нэгдсэн чуулган дээр Б.Жавхлан сайдаас асуугаад ерөөсөө хариу авч чаддаггүй ээ. Бүтэн жил шалгуур үзүүлэлт буюу “Кэй Пи Ай” /Key Performance Indicator/ л ярьсан. Хөгжлийн төлөвлөгөө, төсөв хоёрын шалгуур үзүүлэлтийн хавсралт нь хоорондоо уялдахгүй байгаа.

Төсөв дээр 397 “Кэй Пи Ай” тавьж ороод байна.

Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам хоёроос асууя. Энэ хоёр төлөвлөгөө, төсөв хоёрын шалгуур үзүүлэлт уялдахгүй байна гэдэг чинь бид төлөвлөж ч чадахгүй байна, төсөвлөж ч чадахгүй байна гэсэн үг шүү дээ.

Энэ дээр яаж анхаарч ажилласан юм бол оо? Та хэд маань өөрсдөө яам болгоны хавсралтыг нь боогоод Улсын Их Хуралд өргөн барьж байгаа. Үнэхээр шаардлага хангахгүй байгаа бол яам руу нь, төсвийн ерөнхийлөн захирагч руу нь буцаах ёстой гэж бодож байгаа байхгүй юу.

Энгийн л, 10 жилийн хүүхдийн боловсролын л юм ярья даа. Тэгээд эрчим хүчний сайд дээр 455.0 тэрбум төгрөг байгаа.

► Сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлнэ гэсэн зорилго тавьсан.

Юугаар хэмжих юм бэ гэсэн чинь “километр” гэж тавьж байгаа байхгүй юу. “Ватт”-аар хэмждэггүй юм уу? “Километр” гээд юуг хэмжих гэж байгаа юм?

► Гэр хорооллын айл өрхүүдэд цахилгааны хөнгөлөлт үзүүлнэ гээд.

Үүнийг өмнө жилжингээ ярьсан. Утааг бууруулах гээд л хөнгөлөлт үзүүлж байгаа гээд. Тэгсэн чинь шалгуур үзүүлэлт нь “цахилгааны үнийн хөнгөлөлт үзүүлсэн айл өрх” гээд мөнгө үрэх зориулалттай л шалгуур үзүүлэлт тавьчихаад.

Өмнө нь засаад зарчмын зөрүүтэй санал оруулахаар тэрийг нь Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам дээр нэгтгээд яамнаас нь дахиад өргөн барихад

нь өмнөх төсөв, төлөвлөгөөн дээр энэ шалгуур үзүүлэлтийг чинь зассан учраас та хэд дахиж ийм алдаатай юм битгий өргөн барь гэж ярьж болохгүй юу? Тийм ажил хийгдсэн үү?

▷ Ерөнхийлөгчийн Тамгын газар.

33.6 тэрбум төгрөгтэй. Шалгуур үзүүлэлт нь бүгдээрээ төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх. Ингэж хэмжиж болохгүй шүү дээ. Бас л мөнгө үрэх зориулалттай “Кей Пи Ай” байна шүү дээ.

▷ Авлигатай тэмцэх газар.

Олон улс биднийг авлигын төсөөллийн индексээр л хэмжиж байгаа. Тэгсэн чинь бид Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтээр өөрсдийгөө авлигатай тэмцэж байгааг хэмжинэ гэсэн байгаа.

Маш энгийн логик яриад байгаа шүү дээ. Уг нь бол. Үүнийг Сангийн яамнаас өргөн барихад нь буцааж болдоггүй юм уу? Үгүй та нар арай ч дээ. 10 жилийн хүүхдийн боловсролгүй ийм төсвийн шалгуур үзүүлэлт оруулна гэж юу байх вэ дээ. Эдийн засаг, хөгжлийн яам ч гэсэн энэ дээр ярилцаж болдоггүй юм уу? Ажлын хэсэг байгаа юу? Өмнө нь анхаарч ажиллаж байгаа гэдэг зүйлийг нэгдсэн чуулган дээр зөндөө сонссон.

Яг бодитоор өргөн бариад ирсэн юмыг нь харахаар анхаарч ажиллаж байгаа гэж хэлэх боломжгүй байна л даа. Шууд буцааж байгаа ч. Энэ яам руу нь. Төсвийн ерөнхийлөн захирагч руу нь.

Татвар төлж байгаа ард түмнийг, хувийн хэвшлийг доромжлоод байгаа юм уу? Би үүнийг цаашдаа 3 жил ярина.

О.Номинчимэг: 2 номер. Эдийн засаг, хөгжлийн яам хариулъя 2 номерын микрофон.

И.Батхүү: Г.Лувсанжамц гишүүний асуултад хариулъя.

Эдийн засаг, хөгжлийн яамны зүгээс боловсруулж байгаа хөгжлийн бодлогын баримт бичгүүд дээр таны хэлсэн санал, зөвлөмжийн дагуу салбарын яамдтай нягт ажиллаж байгаа. Оны эхнээс эхлүүлээд ажлын хэсгүүд гаргаад сургалт, зөвлөн туслах арга хэмжээ зохион байгуулаад, олон удаагийн уулзалт хийж байгаа.

Харамсалтай нь хүний нөөцийн тогтвортой бус байдал, янз бүрийн шалтгаанаар ирүүлж байгаа материал нь шаардлага хангахгүй тохиолдлууд их байгаа.

Төсвийн цаглавар маань өөрөө хуулийн хугацаатай учраас тодорхой нөхцөл байдалд бүрэн асуудал шийдвэрлэгдээгүй нөхцөл байдал үүссэн байх гэж ойлгож байгаа.

Яг одоо ирэх 5 жилийн хөгжлийн үндсэн чиглэл боловсруулах ажил дээр бид бүх яамдтай өдөр болгон хэлэлцүүлэг зохион байгуулаад, хамт суугаад ажиллаж байгаа.

О.Номинчимэг: Сангийн яам. 6 номер.

Ж.Ганбат: Таны хэлж байгаатай нэг санал нэг байгаа.

Яах вэ, одоо ингээд төсвийн төсөл хуульд заасан хугацаандаа Сангийн яаманд ирээд бид буцааж байсан тохиолдлууд байгаа. Өмнөх жилүүдэд.

Гэхдээ яг үнэхээр яамд дээр асуудлууд байна уу. Байгаа. Зорилт нь тодорхой бус. Түүндээ хүрдэггүй. Үр ашиггүй зарлага гаргадаг энэ тэр гээд. Тэгээд одоо үүнийг бид төлөвлөлтөөр болон үе шаттай юмнуудыг нь авч хэрэгжүүлж байгаа. Хариуцлага гэдэг юм нэхэж байна. Одоо ялангуяа төсөв батлагдахад нэгдүгээр хавсралтаар батлагддаг тэр зорилт өгсөн дүнгийн талаар тайлангуудыг нь авдаг. Тэрийг нэхдэг. Тэр дагуу юмаа төлөвлөдөг болгох гэж бүх яамд дээр энэ дээр арга хэмжээнүүдийг авч байна.

Яах вэ бид аль болох л төсвийн сахилга батыг сайжруулах байдлаар Төсвийн тогтвортой байдлын байдлын хууль дээр арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа.

Нөгөө талдаа яах вэ, одоо бид энэ хязгаарлагдмал төсвийнхөө... /минут дуусав/

О.Номинчимэг: Нэмэлт хариулах уу? Нэмэлт 1 минут. 6 номер.

Ж.Ганбат: Уг нь санаагаар болдог бол яамд маань мэдээж нөөц боломж хомс байгаа энэ үед яг энэ хүрээндээ бид яаж үүнийг хүргэх вэ, яаж үүнийг зүй зохистой зарцуулах вэ, яаж үр дүнд хүргэх вэ гэдэг дээрээ л аягүй сайн ажиллах ёстой байгаа. Бид ч ийм шаардлага тавьж байгаа. Сангийн яам.

Ер нь бүх салбарын яамд дээр бид энэ асуудлыг тавьж байгаа. Жишээ нь, урамшуулал гэдэг асуудлыг үр дүнтэй болгооч гэдэг асуудлууд дээр нэлээн эрчтэй байр суурийг тавьдаг. Энэ урамшууллууд хэзээ нэгэн цагт дуусах ёстой. Өнгөрсөн жилийн түүхийг нь аваад үзэхээр энэ бол ингээд бараг нэг, хоёр жилийн хугацаатай хэрэгжээд зогсох байсан. Өнөөдрийг хүртэл арван хэдэн жил явсан юмнууд байгаа л даа.

Сангийн яам Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай нийлээд бүх шаардлагуудыг шахаж ажиллаж байгаа.

Тэгээд хариуцлагын асуудлууд дээр манай дээр хууль бол хангалттай байна. Түүн дээр арга хэмжээ авдаг сангын асуудлууд байна. Энэ асуудлуудыг тодорхой болгох асуудал сүүлийн үед яах вэ, хуулиуд нэлээн чангарсан. Тэгээд энэ жилийн төсөв ирэх жил гүйцэтгэл гарахад энэ... /минут дуусав/

О.Номинчимэг: Г.Лувсанжамц гишүүн тодруулъя.

Г.Лувсанжамц: Тэгээд нэхэл хатуу хүний хувьд Та хэд маань дахиж ийм логикийн алдаатай хавсралт өргөн барих юм бол битгий ийш нь оруулж ирээрэй.

Би ичихгүй. Яамд ичихгүй бол үнэхээр би ичихгүй. Сайд нар ичихгүй бол би ичихгүй шүү би бүгдийг нь ярина.

Нөгөө талдаа Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яамыг сайшааж байна. Үнэхээр нягт ажилладаг. Танай хоёр яам болоод байгаа. Бусад яамдаа л сайхан болгомоор байна.

Тэгээд улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй төсөл, арга хэмжээ, зураг төсөв, төсөлгүй төсөл, арга хэмжээ, санхүүжилт нь хэрэгжүүлэх хугацаатай уялдаагүй 75 төсөл, арга хэмжээ гээд нийтдээ 682.0 тэрбум төгрөг. Үүнийг нэгдсэн чуулган дээр асуусан.

Энэ 682-ыг хасах зарчмын зөрүүтэй санал би орууллаа. Нөгөө талдаа тэтгэвэрт гарахдаа нэг удаа олгодог 36 сар хүртэлх тэтгэмжийн 176.0 тэрбум төгрөгийг заавал оруулмаар байна. Энэ боломжтой юу? Сангийн яам.

О.Номинчимэг: Сангийн яам. 5 номерын микрофон.

М.Санжаадорж: Үндсэн хууль дээр орсон зарчим болон Зөрчлийн тухай хууль дээр орсон зарчмын дагуу нөгөө “нэмбэл хас” гэдэг зарчмаараа явах ёстой.

Тэр агуулгаараа парламентын түвшинд хэлэлцүүлгийн шатанд гишүүн саналаа гаргаад “нэмбэл хас” гэдгээр явах боломжтой байгаа.

Тэгээд мөн 1 дүгээр хавсралт дээр мөн нэмээд хэлэхэд Сангийн яамнаас <https://bps.mof.gov.mn> гээд тань руу вебсайтын хаягийг нь явуулъя. Хаяг нээсэн байгаа.

Энэ гол зорилго нь юу вэ гэхээр “Төсвийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн систем” гээд ийм нэг систем бид хийгээд тэрийгээ туршилт байдлаар оруулсан.

Энэ жилийн хувьд яах вэ, эрүүл мэндийн салбарыг арай өөр түвшинд гаргах гээд үзүүлэлтүүдийг нь сайжруулсан тийм байдлаар байгаа. Та бас нэг үзээрэй.

Тэгээд яах вэ, бусад яамдын хувьд бид ажиллах гэж үзсэн. Мөн 21 аймаг энэ дээр огт орохгүй яваад байгаа. Хүрэх үр дүнгээ тодруулж чадахгүй, хийж чадахгүй. Мөн сургалтууд хийгээд явж байгаа. Тэгээд түрүүний хүн хүчний асуудал бас байна.

О.Номинчимэг: Г.Лувсанжамц гишүүн тодруулъя.

Г.Лувсанжамц: Баярлалаа. Яг тийм шүү. Нөгөө орон нутгийнхаа бид нарын хөгжлийн төлөвлөгөө, төсөв хоёрыг нь хэдүүлээ харах ёстой. Одоо жишээ нь нийслэл 12 сарын 05-нд багтаж төсвөө батална шүү дээ. Тийм ээ. Тэр дээр нь бас манай Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам хараад ач холбогдол, тэгээд хүргэж байгаа үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдийг нь сайн харж өгөхгүй бол.

Гэхдээ бас яг үнэнийг хэлэхэд зарим орон нутаг зарим яамнаас хамаагүй дээр байгаа шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр тэрийг нь улам сайжруулаад хэдүүлээ хамтраад явцгаая. Тэгээд бусад яам, Гэр бүлийн яам, Боловсролын яам, Эрүүл мэндийн яам харьцангуй сүүлийн 4 жилийн хугацаанд гайгүй болоод эхэлсэн.

Гэхдээ ялангуяа дэд бүтцийг хариуцаж байгаа, ирээдүйн хөгжлийг хариуцаж байгаа яамдын шалгуур үзүүлэлтийг нь бид зөв болгох ажил хэрэгтэй байгаа. Тэгээд 5 жилийн чиглэл дээрээ бас үргэлжлүүлээд ажиллацгаая. Амжилт хүсье.

О.Номинчимэг: Үг хэллээ. Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууя.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу?

Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд санхүүжих хавсралт 2-оор төсөл, арга хэмжээ барилга, байгууламжийн жагсаалтыг харж байгаад өндөр дүн үнэтэй, их хэмжээний, тэгээд зайлшгүй шаардлагатай эсэх нь тодорхой биш өртөг нь бодитой эсэхийг тодруулмаар хөрөнгө оруулалтын жагсаалтуудыг бүгдийг нь нэг нэгэнгүй түүж бичлээ.

Зүгээр ингээд цаг их орох учраас ганц хоёрыг энд жишээ болгоод харъя. Жишээлбэл, Батлан хамгаалах сайд гэхэд тусгай зориулалтын барилга, байгууламж гээд дэд бүтцээр баруун бүс, төвийн бүс, одоо юу гэдэг юм Улаанбаатар хот гээд 8-аас 9 тэрбум тус бүр янз янзын төлбөртэй.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд гэхэд 2026 онд зөвхөн санхүүжүүлэх дүнгүүдийг нь уншъя гэхэд Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцын 17 дугаар бага хурлыг зохион байгуулахтай холбоотой барилга, байгууламж Улаанбаатар, Баянзүрх дүүрэг гэснээ 150.0 тэрбум төгрөг.

Нэмээд энэ дээр ахиад тоног төхөөрөмж, техник хэрэгсэл яг саяын зориулалтаар буюу Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцын 17 дугаар Бага хуралд зориулсан 67 гаруй тэрбум төгрөг гэх мэтчилэн урт жагсаалтууд явж байна.

Энэ дээр бид хэд одоо ингээд урсгал зардлаа нэмж чадахгүй, мөнгө байхгүй байгаа.

Тэгэхээр зэрэг юу гэдэг юм ард түмнээс авсан санал асуулга, энэ тэрээс болоод бид эдгээр эдгээр зардлуудыг нэмлээ гэж нэрлээд тэр нь тэгээд хөрөнгө оруулалт дээрээ илүү орж байгаа юм. Гэтэл энэ хөрөнгө оруулалт чинь энэ барилга, байгууламж нь нэмэгдээд ирэхээр нэмээд урсгал зардал нэмэгдэнэ биз дээ. Дотор нь ажиллах хүн хүч, тоног төхөөрөмж, халаалт, тог цахилгаан одоо юу байдаг юм. Тийм биз дээ. Жил жилээр. Тэгээд л 2027 оноос бид гэнэтхэн аймаар мөнгөтэй болохгүй.

Үүнийг ерөнхийд нь эрэмбэлдэг асуудлыг. Би бараг гишүүн болоод миний хамгийн анхны асуулт бүлэг дээр асууж байсан асуулт. Энэ том том төслүүдийг яаж эрэмбэлдэг вэ гэж асуугаад би ерөөсөө би хариулт авч чадаагүй. Одоо ч гэсэн энэ асуултын хариулт их тодорхой биш. Яаж эрэмбэлдэг юм бэ? Яам яам болгоноос хүсэл хүслээ бичиж өгөөд, тэрийг нь хаана очиж эрэмбэлээд.

Энэ Засгийн газар, Монгол Улс чинь нэгдмэл нэгдсэн бодлоготой юм байгаа биз дээ. Бодвол эрэмбэлээд энэ үүнийг нь оруулаад, энэ үүнийг нь болиод, энэ нь дараа, үүнийг нь хадгалж болно, үүнийг нь явуулъя гээд явдаг байх. Тийм ээ. Энэ нь яаж эрэмбэлэгддэг вэ гэдгийг маш тодорхой асууж үзмээр байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, чуулган дээр ч гэсэн ярьж байсан. Одоо энэ барилга, байгууламж барихад чинь өөрийн гэсэн эрдэм шинжилгээ, судалгаа гэж хэлэхээсээ илүү шинжлэх ухаан байхгүй юу. Тийм биз дээ. Анализ хийх боломжууд байгаа шүү дээ. Эрүүл мэндээр гэхэд чинь л эрүүл мэндийн хэрэглээний үнэлгээ.

Бас дээрээс нь Health Impact Assessment (HIA) гэдэг шиг юмнууд байдаг. Үүний дагуу барилга, байгууламж. Тэр нь дараа нь хүндээ, эрүүл мэнддээ, бусадтай яаж нөлөөлдөг юм?

Дэд бүтцэд ч гэсэн энэ нь яг хангалттай тийм байгаа байх. Жишээлбэл, одоо ингээд бид дэд бүтцүүдийг эрэмбэлэхдээ юу юугаар эрэмбэлэх юм бэ?

Cost-Effectiveness Analysis буюу “үр ашгийн үнэлгээ” ч гэдэг юм уу. Тус бүрд нь байгаа. Тийм ээ? Эдгээр... /минут дуусав/

О.Номинчимэг: Асуултад хариулъя. Сангийн яам хариулах уу? Хөрөнгө оруулалтын саналуудын эрэмбийг яаж тогтоосон юм? 6 номер. Ж.Ганбат. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга.

Ж.Ганбат: Гишүүний асуултад хариулъя.

Бид хөрөнгө оруулалтын төслүүдийг яах вэ, ер нь бүтэн жилээр нь төлөвлөдөг. Энэ дээр ямар байдлаар төлөвлөлт явж байна гэхээр хуулийн шаардлагууд байгаа. Зурагтай, төсөвтэй, тэгээд нэн зайлшгүй шаардлагатай гэдэг ийм байдлаар Засгийн газар дотор ч гэсэн энэ асуудлыг эрэмбэлэх асуудлыг ярьдаг. Ямар байдлаар явах вэ гэдэг ийм байдлаар байгаа.

Тэр 2026 оны 8 сард болох COP /Conference of the Parties/ олон улсын хуралтай холбоотой тоног төхөөрөмж 67.0 тэрбум төгрөг тавигдсан. Энэ хурал ирэх 2026 оны 8 сард олон улсын хурал болно. Энэ дээр 10 мянга гаруй гадаад орны өндөр дээд хэмжээний зочид төлөөлөгч оролцох энэ хурал байгаа. Энэ хуралтай холбоотой зардлуудыг 2026 оны төсөв дээр нэн шаардлагатай зардлууд гэдэг байдлаар эрэмбэлж тавьсан.

Энэ дээр тэр тоног төхөөрөмж гээд 67.0 тэрбум төгрөг тавьсан нь хурлын тоног төхөөрөмж биш. Энэ бол тэр хуралд оролцогчдын аюулгүй байдлыг хангахтай холбоотой тоног төхөөрөмжүүд тавигдсан байгаа.

Бид хөрөнгө оруулалтыг хуульд заасан төслүүдийг журамд заасны дагуу эрэмбэлээд нэн шаардлагатай гэдэг байдлаар энэ асуудлыг авч үзэж байна. Нийт ирж байгаа саналууд нь асар их саналууд ирж байгаа шүү дээ. Тийм.

14 их наядын санал ирснийг бид эрэмбэлж авч үзээд, Засгийн газар дотроо ярилцаад, бас Ерөнхий сайдын түвшинд сайд нар ярьж байгаад эднийгээ эрэмбэлж ингэж авч байгаа.

Нөгөө талдаа яг төсвийн хууль дээр ямар шаардлагууд хангагдсан хөрөнгө оруулалт төсөвт тусгах вэ гэдэг дээр бид тэр шаардлагыг хангасан байдлаар л хянадаг. Цахимаар төсвийн ерөнхийлөн захирагч нар саналаа ирүүлээд тэр саналыг нь хуулийн шаардлагыг хангуулах байдлаар эрэмбэлж авсан.

2026 оны төсвийн хүрээний мэдэгдэлээр тусгагдсан хөрөнгийн зардлын хязгаарынхаа хүрээнд буюу 3.2 их наядын хөрөнгө оруулалтыг нийт дүнгээр нь хянаж авсан байгаа.

О.Номинчимэг: Д.Ганмаа гишүүн тодруулъя.

Д.Ганмаа: Эрэмбэлэхдээ ТЭЗҮ гол нь байдаг эсэхээр үнэлдэг юм байна гэж ойлголоо. Тийм үү?

Бусад тодорхой салбар тус бүр дээр үнэлдэг тийм үнэлгээний аргачлалууд байх ёстой. Тэр аргачлалыг хэрэглэдэг юм уу, хэрэглэдэггүй юм уу?

Жишээлбэл,

- “Нийтийн хөрөнгө оруулалтын менежмент” гэж байдаг юм байна. PIM – PUBLIC INVESTMENT MANAGEMENT.
- “Нийгмийн өгөөжийн үнэлгээ” гэж байдаг юм байна. Зөвхөн санхүүгийн бус нийгмийн үр өгөөжийг бодсон. Тийм ээ.

Наад зах нь тэр COST-EFFECTIVENESS ANALYSIS гэж би төлөвлөсөн шүү дээ. “Өртөг, үр ашгийн шинжилгээ”. Үүнийгээ хийдэг үү?

Тэр байтугай “Олон шалгуурт шинжилгээ” гэж байдаг юм байна. MULTI-CRITERIA ANALYSIS гээд нэртэй.

Энэ нь зөвхөн мөнгөн дүнгээр биш нийгэмд зайлшгүй ямар шаардлагатай юм? Байгальд гэх мэтчилэн ийм үнэлгээнүүд.

Надад гомдолтой санагдаад байх юм. Тийм ээ. Шинжлэх ухаанчаар ярьж гэхээр яахаараа Нэгдсэн Үндэстний Байгууллагын тийм том хурал болох гэж байгаа болохоор... /минут дуусав/

О.Номинчимэг: Дахиад 1 минут өгье. Д.Ганмаа гишүүн.

Д.Ганмаа: Барилга, байшинд нь гэхэд л 150.0 тэрбум. Дээрээс нь тоног төхөөрөмж, хэрэгсэл гээд орсон. Тэр нь аюулгүй байдлыг хангахад 67.0 тэрбум гээд нэмдэг юм бэ?

Тэр байгаа байдлаар нь ер нь тэр хүмүүстээ харуулбал яасан юм. Цөмөөрөө. Шинээр барилга барихгүй, шинээр янз янзын юм хийхгүйгээр.

Нэгдсэн Үндэстний Байгууллага чинь хүн, боловсрол, эрүүл мэнд, нийтийн эрүүл мэнд сайн сайхны төлөө байдаг байгууллага шүү дээ. Тэгээд хэдэн жил хамтарч ажилласан энэ байгууллага нь ямар нөхцөл байдалтай байгааг байгаагаар нь хараг л дээ. Ер нь. Эсвэл үнэхээр аюулгүй байдал энэ тэр ярих гээд байгаа бол урьд нь баахан мөнгө төгрөг бариад АСЕМ, юу юу ч билээ баахан юм барьсан биз дээ. Тэрэндээ байлгаж болдоггүй юм уу. Гэх мэтчилэн ийм асуултууд дуусашгүй байгаад байна.

Би энэ листийг тус бүрээр нь яам болгон руу явуулаад хариултыг нь авъя.

О.Номинчимэг: Д.Ганмаа гишүүний асуугаад байгаа эрэмбэлэхдээ тавьдаг шалгуур гэж юм байна уу? Яаж эрэмбэлээд, ямар шалгуур үзүүлэлтээр эрэмбэлээд байна гэдгийг 6 номерын микрофон. Сангийн яам хариулъя.

Ж.Ганбат: Яах вэ, бид эрэмбэлэх аргачлал бүгд байгаа л даа. Бид зүгээр юу гэдэг юм тэр нь энэ гээд аваад байдаг юм байдаггүй. Сангийн яам төлөвлөлтийг маш олон жил хийж байгаа шүү дээ. Эрэмбэлээд.

Энэ тал дээр олон улсын байгууллагуудтай хамтарч бид энэ жилийн төлөвлөгөө болон дунд хугацааны төслүүдийг эрэмбэлэх асуудал дээр нэлээн ажилласан. Тэр нь бүрэн цахимжуулсан байгаа. Сангийн сайдын тушаалаар батлагдсан аргачлал байдаг. Тэгээд шалгуур үзүүлэлтээ тогтоож өгөөд түүн дээрээ бид эрэмбэлэх байдлаар хийдэг. Тэгээд шинжилгээг хийдэг. Бид төсөвт өртгөөс хамаараад зардал, үр дүнгийн, тэр үр ашгийн энэ тэр гээд бүгд тооцоо хийж байгаа. Ялангуяа орон нутаг дээр тухайн орон нутгийн хүн амын тоотой уялдуулсан ийм байдлаар.

Сүүлийн үед яг ийм байдлаар бид нарын хийсэн үр дүнгүүд нэлээн гарч байгаа л даа. Хүн амын тооноос илүү хэт давсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар юм баригдахаа больсон гээд тоочоод байвал нэлээн олон том асуудлууд байна.

О.Номинчимэг: Д.Ганмаа гишүүний хэлээд байгаа юм чинь COP17 билүү. Тийм ээ. Түүнд зориулсан барилга, байгууламж чинь одоо нийгэмд тулгамдаад байгаа юмнаас л илүү үр дүнтэй гэж үзээд байгаа юм уу? Яаж шалгуур үзүүлэлтээр яагаад. Энэ дээрээ илүү хөрөнгө оруулалт тавиад дутагдаад байгаа эмч, багш нарын цалин байдаг юм уу, юмнуудаа шийдэхгүй байгаа юм бэ л гэдэг асуулт шүү дээ. Энгийнээр. 6 номер гүйцээж хариулъя.

Ж.Ганбат: Ер нь COP, энэ хуралтай холбоотой энэ дээр тусгагдсан зардлуудыг бид нэг л зарчим барьж байгаа шүү дээ. Хамгийн бага зардлаар бид яаж үүнийг богино хугацаанд үр ашигтай хийх вэ гэдэг ийм байдлаар хандаж байгаа.

Энэ бол Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр хүртэл нэлээн хэдэн удаа яригдсан. Бид Засгийн түвшинд ч яригдсан. Тэгээд хамгийн бага түвшинд хянаад л ийм байдлаар зайлшгүй гарах зардлуудыг Монголын талын хүлээсэн зардлууд гэдэг байдлаар эд нарыг тусгаад, эрэмбэлээд ингэж л оруулж ирж байгаа.

Түүнээс биш нэг удаагийн чанартай, зөөврийн, хувийн хэвслүүдийг оруулж ирье. Зарим нэг хувийн хэвшлийн компаниуд, аж ахуйн нэгжүүдийн дэмжлэгтэйгээр зарим хөрөнгүүдийг нь түрээсэлье, тэдний байр савыг ашиглая. Нэг удаагийн шинж чанартай. Тэр зун цаг учраас гадаа аль болох тийм нэг их зардал шаардагдахгүй энэ тэр байдлаар гээд Байгаль орчны сайдаар

ахлуулсан Үндэсний хороо ажиллаж байгаа. Энэ дээр бүр маш дэлгэрэнгүй ярьж байгаа шүү дээ. Тэд нарын яг хүсээд байгаа зардлаас нь бид... /минут дуусав/

О.Номинчимэг: Р.Эрдэнэбүрэн гишүүн асуулт асууя.

Р.Эрдэнэбүрэн: Энэ өдрийн мэнд хүргэе.

Уурсгал зардалтай холбоод урсгал зардал бол цэвэр манай энэ улс төржилтийн л үр дүн шүү дээ. Сонгуулийн өмнө болгон л цалин нэмнэ, тэтгэвэр нэмнэ, тэрийг ч гоё болгоно гэсээр байгаад л ийм байдалд хүрсэн.

Энэ урсгал зардлыг Сангийн яам хязгаарлаж чадахгүй. Одоо тэр СОР гээд л ярьж байна. Сангийн яам мэдэж байсан бол энэ СОР-ыг хийлгэхгүй л байсан. Энэ СОР чинь бас л манай нэг улс төрчийн л санал гаргаад л явуулсан асуудал шүү дээ. Одоо тэгээд манай сайд нар хэн нь ч энэ урсгал зардлаа багасгана, бид цалин нэмэхгүй гэж хэлж чадахгүй шүү дээ. Бүх сайд нар л бүгдээрээ яаж ийгээд л тэдэн хувиар нэмж болно, эдэн хувиар нэмж болно гээд л явж байгаа. Аль ч нам тэтгэврийг нэмэхгүй гэж хэлж чадахгүй.

Тэгэхээр миний бодлоор Сангийн яамны хийх ажил нь орлогоо яаж нэмэгдүүлж урсгал зардлаа нөхөж явах вэ гэдэг дээр л хөрөнгө оруулалтаа эрэмбэлж, нөгөө мөнгө олдог хөрөнгө оруулалтууд руугаа яаж хурдан явуулах вэ, хөрөнгөө яаж эрэмбэлэх вэ гэдэг дээр л их анхаармаар юм шиг санагдаад байгаа юм.

Одоо энэ хөрөнгө оруулалтыг үр дүнгүй болгож байгаа хамгийн хэцүү асуудал бол ялангуяа 10 тэрбумаас доош бага дүнтэй хөрөнгө оруулалтуудыг хувааж тавьж байгаагаас болоод хөрөнгө оруулалтын чинь төсөв нь аймаар их өсөж байна. Одоо би Өргөдлийн байнгын хороон дээр ярьж байна. Манай гишүүд бүгдээрээ мэдэж байгаа байх. Ирж байгаа хүсэлтүүдийн төсөвтэй холбоотой төсөв нь ингээд ингээд тэдэн жилийн өмнөөс ингээд тэд дахин өслөө. Үүнийг л нэмж оруулж өгөөч ээ л гэсэн хүсэлтүүд байна шүү дээ.

Манай төсвийн хөрөнгө оруулалт чинь хувиараа гайгүй өндөр дүнтэй л явдаг юм байна. Одоо жишээлбэл 2026 оны төсөв 9.6 их наядын өртөгтэй 579 төсөл, арга хэмжээ байгаа юм байна. Энэ онд 3.2-ыг нь тавих юм байна. Гэтэл 10 тэрбумаас дээш нь асуудалгүй хувааж тавьж болох байх. 10 тэрбумаас доошоо. Одоо жишээлбэл нэг сумын төв дээр 5 тэрбумаар хийгдэх ажлыг 3 хуваагаад тавихаар мянган километр явж очих гэж байгаа компани 3 дахиж очих болж байгаа юм. 3 жил дараалан.

Тэгэхээр чинь төсөв нь өсөхөөс өөр аргагүй болоод байгаа юм л даа.

Тийм учраас 5-аас доош дүнтэй ч юм уу. Одоо энэ 579 төсөл, арга хэмжээний чинь 187 төсөл, арга хэмжээ нь 10-аас дээш, 392 нь 10-аас доош тэрбумын төсөвтэй ийм арга хэмжээ... /минут дуусав/

О.Номинчимэг: Тодруулгын 1 минут нэмье. 1 минут нэмж өгье. Р.Эрдэнэбүрэн, Равжихын Эрдэнэбүрэн гишүүнд 1 минут нэмж өгье.

Р.Эрдэнэбүрэн: Тэгэхээр энэ 10 тэрбумаас доош өртөгтэй 392 төсөл, арга хэмжээ чинь ингээд 3 хуваагаад тавихаар ихэнх нь, бараг 80, 90 хувь нь хэдэн жилийн дараа дахиад л төсөв нь өссөн, дуусаагүй явах гээд байна.

Тэгээд төсвийн заалт байгаа юм байна. Хувааж тавьж болно гээд. Тэрийг л баримталж байгаа гэж байгаа юм байна.

Тэгэхээр ялангуяа хөдөө орон нутагт хол газар хийгдэх гэж байгаа 5 тэрбумаас доош 5 хүртэл тэрбум төгрөгийн ажлуудыг нэг бол бүтнээр нь тавиад дуусгадаг болмоор байна. Нэг бол тавихгүй. Мөнгө болохгүй бол тавихгүй баймаар байна. Тэгээд энэ тал дээр Сангийн яам ямар бодолтой байгаа вэ? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, орлого олдог хөрөнгө оруулалтууд руугаа анхаарч байгаа юм уу гэхээр ерөөсөө тийм юм алга. Гол олж байгаа орлого чинь говийн бүсийн уул уурхай байгаа.

Би зөвхөн Өмнөговь, Дорноговыг хэлэхгүй байна, Дундговийг хэлэхгүй байна. Баянхонгор, Говь-Алтайг.

О.Номинчимэг: Сангийн яам. 6 номер.

Ж.Ганбат: Бид ийм байгаа. Ер нь өмнө нь төсвийн хууль дээр 3 жилд хувааж тавина гэж заалт байдаггүй байсан юм. Нөгөө амсуулж тавина гэдгээр 10 жил явна. 7, 8 жил явна. Ингээд дуусдаггүй. Тэгээд л амсуулаад л яваад байдаг. 50 саяар хүртэл юмыг эхлүүлэхээр тавиад явж байсан түүхүүд өмнөх жилүүдэд байгаа шүү дээ.

Тийм учраас Сангийн яамнаас сахилга батыг, төсвийн хөрөнгийг, татвар төлөгчдийн мөнгийг үр ашигтай болгох байдлаар ийм зохицуулалтыг бид зориуд оруулж өгсөн байгаа.

Энэ дээр нэг ийм асуудал байгаа юм. Яах вэ, бид 10-аас дооших биш.

Ер нь 2-оос 5 тэрбум хүртэлх жил хүртэлх тийм төсөвт өртөгтэй барилгыг 2 жил. Тэгээд түүнээс дээшхийг нь 2-оос 3 жилд гэж байгаа юм.

Гэхдээ энэ дээр нэг зохицуулалт бас байгаа юм. Яах вэ, 3 жил хувааж тавьчихаад үнэхээр тэр компани чадалтай компани орж ирээд тэр ажлыг сайн

гүйцэтгэж байх юм бол бид төсөв дотор нь зохицуулалт хийгээд төсөвт өртгийг нь нэмэгдүүлэхгүйгээр тэр салбарын сайдынх нь багц дотор гүйцэтгэлийнх нь явцтай уялдуулаад зохицуулалт хийгээд санхүүжилт нэмэгдүүлээд өгөх нэг боломж байгаа юм.

Хоёр дахь нь, үнэхээр ажил нь сайн яваад дараа жил нь дуусахаар бол бид дараа жилийн төсөв төлөвлөхдөө түүнийг тэр төсөвт өртгийг нь дараагийн 2 дахь жил дуусна гэж хэлээд л үлдэгдэл мөнгийг нь тавьж өгөөд л бид батлаад явдаг. Ийм байдлаар зохицуулалтыг хийгээд явж байгаа.

Нөгөө талдаа бид сүүлийн 2 жилд хийгдсэн ТЭЗҮ, зураг, төсөвтэй байна гэдэг ийм байдлаар хууль дээр тусгаж өгсөн шүү дээ. Тэгэхгүй бол бүр 5 жилийн өмнөх, 10 жилийн өмнөх, бүр хэзээ хийсэн нь тодорхойгүй зураг, төсөв хийгдсэн, ТЭЗҮ хийгдсэн. Түүгээрээ улсын төсвийн хөрөнгө оруулалт тавигддагаас болоод төсөвт өртөг нэмэгдээд байгаа учраас үүнийг бид зогсоохын тулд зориуд бид хууль дээрээ сүүлийн 2 жилийн хугацаанд хийгдсэн ТЭЗҮ, зураг, төсөвтэй байна гэдэг заалтыг оруулж өгсөн.

Саяын хэлдгээр 3 жилийг ингээд зориуд оруулж өгсөн ийм байдлаар уг нь зохицуулалт хийснээр аягүй сайн үр дүн гарч байгаа шүү дээ. Энэ бол өмнөх жилүүдэд явж ирж байсан юмнуудыг уг нь бид аль болох жил болгон сайжруулаад л, үр ашгийг нь нэмэгдүүлээд л, сахилга батыг нь сайжруулах байдлаар алхам алхмаар зохицуулалтыг нь хууль дээрээ чангатгаад л яваад байгаа л даа.

О.Номинчимэг: Р.Эрдэнэбүрэн гишүүн тодруулъя.

Р.Эрдэнэбүрэн: Одоо тэгээд яах вэ, ирж байгаа бүх, бид нарт төсөв хэлэлцэх үеэр ирж байгаа бүх хүсэлтүүд 100 хувьд ийм байна шүү. Энэ үнэ өссөн л гэдэг. Тэгээд тэдийг нэмж өгөөч ээ л гэдэг ийм байгаа.

Би хоёрдугаарт нь нэг ийм юм асуух гэсэн юм. Нэмээд асууж тодруулмаар байна.

2026 оны юун дээр. Энэ хөрөнгө оруулалтыг хийгээд бид маш богино хугацаанд, ойрын хугацаанд хэдэн жилийн дотор ийм орлого олох гэж байгаа юм гээд томоохон дэд бүтцийн шинж чанартай ялгасан тийм зүйл байдаг юм уу, байдаггүй юм уу? Тэдэн хувиар орлого өснө гээд.

Гуравт нь, хэмнэлтийн хууль гээд нэг сайхан юутай болсон. Төсвийн орлого болохоо болингуут хэмнэлтийн хуулийн дагуу бүгдийг нь зогсоож байна гээд л цалин, тэтгэвэр лүүгээ шилжүүлээд хөрөнгө оруулалтууд чинь ерөөсөө явахгүй болж байгаа. Энэ дээр цаашдаа ямар бодолтой байгаа вэ?

О.Номинчимэг: 6 номер. Ж.Ганбат. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга.

Ж.Ганбат: Хэмнэлтийн хууль дээр 5 сарын 31 гэж оруулаад ингэсэн. Үүнээс өмнө, уг нь одоо яг манай хуулийн зохицуулалтаар 11 сарын 15-нд төсөв батлагдана.

Төсөвт батлагдангуут худалдан авалтын зохион байгуулах эрх нь нээгдэж байгаа юм. Тэгэхээр өөрөөр хэлэх юм бол яг бэлэн зураг төсөвтэй, ТЭЗҮ-тэй ямар ч асуудалгүй төсөл, арга хэмжээг 11 сарын 15-нд төсөв батлагдахад л маргааш нь тендерийг нь зарлаад л худалдан авалтыг нь зохион байгуулаад л тэгээд л тэр дулааны улирал нь 2, 3 сард эхлэхэд бүх ажил хийгээд явдаг ийм байдлаар л бид ингээд бүтэн жилийн циклийг нь зурж байгаад л үүнийг батлуулсан.

Яг энэ журмаараа ингээд явбал тэр 5 сарын 31-нд тэр худалдан авалт зохион хууль ямар нэгэн хураагдах юм уг нь байхгүй.

Өмнөх жилүүдэд санхүүжилтийг нь он дамжуулаад л өгөөд л үр дүн ерөөсөө гарч байгаагүй юмнууд байсан. Бид хамгийн үр дүнтэй гэж уг нь бусад орнуудын юмыг нэлээн судалж судалж байгаад л ер нь бэлэн төслүүд Улсын Их Хурлаар батлагдлаа. Маргааш нь худалдан авалтыг зохион байгуулаад л... /минут дуусав/

О.Номинчимэг: Тийм. Хоёр дахь асуулт нь орлого нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын эрэмбэ. Үүнийг явуулбал ямар орлого нэмэгдэх вэ гэдэг тооцоо, судалгаа хийдэг үү гэдэг асуулт байсан. Энд хариулъя. Сангийн яам. 6 номер.

Бид орлого нэмэгдүүлэх дээр дэд бүтцийн боомтын хөрөнгө оруулалт дээр улсын төсвийн болон гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр боомтууд дээр бид онцгой анхаарч байгаа. Гол экспортын орлого орж ирдэг боомтууд дээр Шивээхүрэн, Гашуунсухайт, Ханги-Мандал гэсэн ийм ийм боомтууд дээр бид онцгой анхаарч байгаа.

Нөгөө талдаа энэ оны төсвийн хөрөнгө оруулалтыг үзэхэд ерөнхийд нь замуудын асуудлууд л байгаа шүү дээ. Бид яг дэд бүтэц дээрээ л онцгой анхаарч байгаа. Ялангуяа энэ урагшаа чиглэсэн экспортын боомтууд дээрээ чиглэсэн арга хэмжээнүүд дээрээ онцгой анхаарч байгаа.

Одоо Гашуунсухайт энэ онд ерөнхийдөө ажлууд нь дуусаж байгаа.

Яах вэ, тэр Гашуунсухайтын тэр замын асуудлыг “Эрдэнэс Монгол” компани, “Эрдэнэс Тавантолгой” компани хариуцаад өөрсдөө уг нь тэрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр зохион байгуулна гээд явсан нэг тийм асуудлууд байгаа.

О.Номинчимэг: Эдийн засгийн яам хариулах уу? Болсон юм уу? Би хоёр асуулт асууя. Тэгэх үү?

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс асуумаар байна. Ер нь яах вэ, манай Өргөдлийн байнгын хороон дээр ирж байгаа санал, хүсэлт, иргэдийн нийтлэг хандлага ерөөсөө авч байгаа цалин, тэтгэвэр нь өдөр тутмын амьжиргаанд нь хүрэхээ болилоо. Тэгээд татварын дарамт байгаа нь ерөөсөө л үнийн өсөлттэй холбоотой асуудал байгаа. Инфляц болж байна. Өдөр тутам өргөн хэрэглээний барааны үнэ өсөж байна. Энд нь авч байгаа цалин, тэтгэвэр нь хүрэлцэхгүй болоод байна. Тэгээд л бүгдээрээ цалин, тэтгэврээ нэмүүлье гээд.

Тэгээд яг бүгдийг нь бид хүссэн хэмжээгээр нэмье гэвэл мэдээж төсвийн орон зай ямар байгааг тодорхой хэмжээгээр ойлгож байгаа. Тэгээд нэг талаараа ийм байгаа болохоор үнийн өсөлт гэдэг юм чинь ард иргэдийн амьдралд маш хүнд тусаад байна шүү дээ. Энэ инфляцыг бууруулах талаар, үнийн өсөлтийг хязгаарлах талаар мэдээж мөнгөний бодлого, төсвийн бодлого уялдаатай явах ёстой. Тэр элдэв долоон хөнгөлөлт, зээл, мөнгө тараах асуудлыг багасгах хэрэгтэй байна. Мөнгөний бодлогоо чангатгах хэрэгтэй байна гээд.

Тэгээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтээр энэ төсөв дээр яг энэ чиглэлийн, инфляцаа барих чиглэлийн бодлогуудыг үнэхээр хангалттай хийж чадсан байна уу? Эсвэл цаашид юун дээр анхаарч ажиллах ёстой байна гэдэг дээр Та бүхэн бас нэг байр суурь илэрхийлээд өгөөч ээ гэж хүсэж байна.

Хоёрдугаар асуудал. Бид түрүүн 24 хувийн тэр хязгаарлалтыг С.Эрдэнэбат гишүүн нэлээн хөндөж ярилаа.

Гэхдээ нийгэмд үнэхээр иргэд хүсэж хүлээж байгаа зүйл нь татварын ачааллаа багасгая, цалин, тэтгэврийн асуудлаа нэмье л гэдэг юм явж байна. Бид мэдээж өмнөх явж байсан хуулиудаа, дааж давшгүй хуулиудаа баталсан гэдгийг тодорхой хэмжээнд хүлээн зөвшөөрөх ёстой.

Гэхдээ одоо бид яг юу хийж чадах вэ гэдэг дээрээ бас анхаарах ёстой байгаа юм. Тэгээд ингээд харахаар бид одоогийн өнөөдрийн энэ 2026 оны төсвийн төсөл дээр ямар орон зай гаргаж болох вэ гэдэг дээр анхаарах хэрэгтэй байгаад байдаг.

Тэгээд 2026 оны улсын төлөвлөгөө Улсын Их Хурал батлахдаа төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах тал дээр тэргүүлэх чиглэл гээд нэлээн олон зүйлийг оруулж өгсөн. Энэ дотор төрийн өмчит компаниудын зардлыг 15 хувь бууруулъя, бүтээмжийг 30 хувь сайжруулъя гэдэг энэ шалгуур үзүүлэлтийг оруулж өгсөн.

Төсвийн төсөлд энэ компаниудтай холбоотой зардал үнэхээр 15 хувь бууж орж ирсэн үү? Үр ашиг нь 30 хувьд ихэснэ гэсэн тооцооллоор орж ирсэн үү? Үүнийг тодруулмаар байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтээр 2028 онд, 2026 онд гээд явахаар тэр дундаж эдийн засаг дахь төрийн оролцоо буурахгүй байна. Хангалттай хэмжээнд буурахгүй байна гэдэг дээр дүгнэлт өгсөн байсан. Энэ төрийн өмчийн оролцоогоо, төрийн оролцоогоо, эдийн засаг дахь оролцоог багасгахын тулд бид төрийн өмчит компаниудынхаа асуудлыг л нэг цэгцлэх ёстой байгаад байдаг.

Тэгэхээр энэ дээр яг энэ 2026 оны төлөвлөгөө, Та бүхэн 24 хувийн тэр хязгаарыг маш сайн барьж орж ирсэн юм байна. Төрийн өмчит компаниудын зардлыг бууруулах, үр ашгийг дээшлүүлэх гэдэг 15, 30 хувийг яг тас барьж орж ирсэн юм уу гэдэг дээр. Энэ дээр бас нэг хариулт авъя гэж бодож байна.

Эхлээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл 3 номерын микрофоныг өгье.

Л.Отгонтуяа: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа. О.Номинчимэг даргын асуултад хариулья.

Зөвлөлийн зүгээс бид төсвийн хүрээний мэдэгдэлдээ өгсөн дүгнэлт дээр инфляцтай холбоотой зүйлүүд маань илүү орж ирж байгаа. Тэгэхдээ манай төсөөллөөр 8 хувийн инфляцтай байна гэж 2026 оныг бид төсөөлсөн. Тэгэхдээ Засгийн газрын зүгээс 7 хувийн санал оруулж ирсэн. Тэгээд төсвийн хүрээнийхээ мэдэгдлийн шаардлагуудаа яах вэ эд нар маань хангаж байна гэж үзсэн.

Төсөв, мөнгөний бодлогын зохицол, уялдаа энэ дээр зайлшгүй чухал.

Тэгэхээр бидний өнгөрсөн намар ч гэсэн өгсөн төсвийн дүгнэлт дээр, төсвийн хүрээний мэдэгдлийн дүгнэлт дээр ч бий. Нийт зарлага дотоодын нийт бүтээгдэхүүний 25 хувиас илүү гараад явах юм инфляцаа илүү өдөөдөг гэдэг ийм шаардлагууд байсан. Энэ ч утгаараа жилийн хөгжлийн төлөвлөгөө дээр 24 хувийн хязгаарыг тавиад Засгийн газрын зүгээс үүнийг баримталж орж ирсэн нь бидний зүгээс энэ саналыг илүүтэй дэмжиж байгаа.

Нөгөө талдаа сая төсвийн хүрээний мэдэгдэл дээр, манай дүгнэлт дээр ч байгаа. Зарлагыг нийт зарлагаа 30 хувьд барьсан байна.

Гэхдээ бүр 27 байлгахгүй бол 2030 он гэхэд манай урсгал зардалдаа тавих тусгай шаардлага маань ч хангагдах боломжгүй болох нь гэдэг зүйлийг хэлсэн.

Зүгээр цалин, тэтгэвэртэй холбоотой иргэдээс ирж байгаа гомдол, саналтай холбоотой бодлогын нэг санал хэлэхийг би хүсэж байна. Түүн дээр юу вэ гэхээр бид үндсэндээ тэтгэврийг нэмнэ гээд явахаар нэг талдаа бүгдийг нь жигд нэмэх боломж угаасаа хүнд байгаа. Гэтэл бага тэтгэврээ нэмээд өндөр тэтгэврийг нь орхъё гэхээр бас шударга бус байдлууд үүсэхээр байгаа.

Тэгэхээр бага тэтгэвэртэй байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэрүүд тэр бага байгаа тохиолдолд бид цаашдаа үүнийгээ халамжийн бодлоготойгоо илүү уялдуулж явмаар. Ингэж бидний зүгээс үзэж байгаа.

Тэр нь юу гэсэн үг вэ гэхээр өрхийн амьжиргааны түвшнээ бид орлого орлуулан тооцох аргачлалаар амьжиргааны түвшингээ тооцдог бол тухайлбал Армен Улсад гэхэд амьжиргааны түвшингээ өрхөө тооцоод 5 бүлгээр өрхийн тэтгэмж, өрхийн халамжийн үйлчилгээ үзүүлдэг. Тэр нь ямар нөхцөлд байгаагаас хамаарч.

Тэгэхээр эндээс үнэхээр тэтгэвэр нь хүрэлцэхгүй байгаа ганц бие өндөр настан, тэжээгчээ алдсан хүүхдүүд гэх мэтчилэн зорилтот халамжийн бүлгүүд маань үнэхээр хүнд байвал мэдээж халамжийн бодлогоо үзүүлнэ. Тэтгэвэр багатай өндөр настнууддаа магадгүй халамжийн бодлогоороо бид илүү үйлчилгээ үзүүлэх.

Тэгэхийн тулд нийгмийн халамжийн үйлчилгээ дээр багтаад байгаа хүүхдийн мөнгөө болж өгвөл “Үндэсний баялгийн сан”, “Ирээдүйн өв сан”-гийнхаа хэлбэрээр хуримтлалын сан үүсгэх хэлбэрээр зарцуулаад, харин халамжийнхаа үйлчилгээг зорилтот бүлэг, тэгээд үнэхээр хүнд амьдралтай байгаа тэр өрхүүддээ, өндөр настнууддаа, хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ зориулах тэр тал руугаа илүү анхаараасай. Энэ дээр Их Хурлын гишүүд маань бодлогын хувьд мэдээж өнөөдөр, энэ удаадаа, ирэх ондоо шийдэх асуудал биш. Гэхдээ үүнийгээ бодолцох шаардлага байна.

Дээр тэр нь нэмээд салбаруудын дотоод. Одоо Боловсролын сайд ч тэр, Эрүүл мэндийн сайд ч тэр төсөв хүнд байгаагаа үнэхээр бидний олж байгаа боломжийнхоо хэмжээнд бид энэ мөнгөний хязгаартай байна, энэ хүрээндээ ажиллая гэж хэлж байгаатай би санал нэг байгаа. Дэмжиж байгаа.

Гэхдээ салбарын дотооддоо зардлаа эрэмбэлэх, яг гүйцэтгэх ёстой Сангийн яамны хэлээд байгаа төр гүйцэтгэх албагүй үйлчилгээнүүдээ шилжүүлээд, өөрөө өөрсдөө санхүүжээд явах тэр боломжуудаа нээх талаасаа бид бас бодлогын ийм хувилбаруудаа яриад, дараагийн жилийнхээ төсвийн. Тийм ээ. 2027 оны жилийн төлөвлөгөө энэ тэрдээ үүнийгээ анхаарч үзээсэй гэдэг ийм байр суурийг илэрхийлмээр байна. Баярлалаа.

О.Номинчимэг: Эдийн засаг, хөгжлийн яам. Энэ макро эдийн засгийн хувьд бид үнийн өсөлтийг хязгаарлах тал дээр ямар бодлого энэ төсөв дээрээ оруулж ирсэн бэ гэдэг асуултад хариулаадхаач.

И.Батхүү: О.Номинчимэг даргын асуултад хариулья.

Яг төсөв дээр гэхээсээ илүү үүднээс төсвийн хүрээний мэдэгдэл ирэх 3 жилийн макро эдийн засгийн бодлого дээрээ энэ чиглэлээр бодлогоо оруулж ирсэн. Тухайлбал, инфляцыг

- 2026 онд 7 хувь,
- 2027 онд 8 хувь,
- 2028 онд 6 хувь, 5 хувь гээд бууруулж байгаа.

Инфляц, ханш хоёр өөрөө хүлээлт дагаж явдаг учраас хэт өндрөөр төлөвлөх нь өөрөө зах зээл дээр буруу дохио өгөх. Үүнийгээ дагаад инфляцыг өөрийг нь өдөөх, ханшийн тогтворгүй байдал руу хөтлөх эрсдэлтэй байдаг. Тэр агуулгаараа зорилтын түвшнүүдийг ингэж тусгасан байгаа.

Энэ нөгөө талаасаа мөнгөний бодлогоо хариуцаж явдаг Монголбанкны зорилтот түвшиндээ бас нийцэж байгаа.

Ирэх жилүүдэд интервалаа 6 дээр нэмэх, хасах 2 гэдгээ 5 дээр нэмэх, хасах 2 гээд бууруулах чиглэлээр бодлогоо баримталж байгаа юм билээ.

Инфляцыг эрэлт, нийлүүлэлт гэдэг хоёр талаас харж үзнэ. Бас импортын гаралтай инфляц, дотоодын гаралтай инфляц гэж бас хоёр талаас нь авч үзэж болно.

О.Номинчимэг: Сангийн яам юу яая тэгэх үү? Яг энэ тэгээд инфляц өдөөгөөд байдаг юмнууд нь бид нарын харснаар хэвээрээ л янз бүрийн тусламж юунууд нь байна гэж хараад байгаа. Дээр нь төрийн өмчит компаниудын зардал бууруулах, үр ашиг сайжруулах тал дээр төсөв дээр юу сууж ирсэн юм? Энэ 15, 30 хувиа яг барьж орж ирсэн юм уу? Энэ мэдээллийг өгөөч.

5 номер уу? 6 номер уу? 5 номер. Сангийн яам.

М.Санжаадорж: Сангийн яам М.Санжаадорж.

Одоо дотоодын нийт бүтээгдэхүүнд эзэлж байгаа хувь өөрөө 3 орчим хувиар буурч орж ирж байгаа. Энэ нь эдийн засаг дахь төрийн оролцоо буурч байна гэсэн үг.

Төсвийн нийт төрийн хэрэглээ буурч байгаа нь нөгөө талдаа мөнгөний бодлогын хувьд арай хүү багатай, зээлийн олдоц нэмэгдэх боломж орж ирж байгаа. Энэ нь өөрөө хувийн хэвшил хөгжих боломж гарч ирнэ гэсэн үг.

Нөгөө талдаа нийтдээ Монгол Улсад 1.4 сая хүн ажил эрхэлж байна. Үүнээс төртэй хамааралтайгаар ажил эрхэлж байгаа нь 280-аас 290 мянган хүн байна. Төрийн өмчит компаниудыг оролцуулаад.

Төрийн албан хаагчдын цалин, хөлсийг бид хэрвээ зардал өндөр үед нэмэх юм бол энэ нь инфляцад илүү өндрөөр нөлөөлдөг гэдэг тийм Монголбанкнаас хийсэн тооцоолол байдаг. 10 хувиар нэмэхэд 4.4 хувиар.

Тэгэхээр зардлаа бууруулж байж цалингаа нэмэх ийм боломж ирэх жилүүдээс гарч ирэхээр байна гэж харж байгаа.

О.Номинчимэг: ТӨК-тэй холбоотой асуултад хариулъя.

Хэрэг эрхлэх үү? 1 номер. Д.Мөнх-Эрдэнэ дарга.

Д.Мөнх-Эрдэнэ: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Төрийн өмчит компаниудыг үр ашигтай ажиллуулах зорилтын хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар ажлын хэсэг гараад Хэрэг эрхлэх газрын дарга ахлан ажиллаж байна.

Энэ ажлын хүрээнд үр ашиггүй ажиллаж байгаа төрийн өмчит компаниудыг татан буулгах, зардлыг хэмнэх, 30 хүртэл хувиар урсгал зардлыг хэмнэх, ашиггүй ажиллаж байгаа компаниудыг татан буулгах, нийлүүлэх, нэгтгэх замаар өөрчлөн байгуулах ажил хийгдээд явж байна.

Тухайлаад хэлэх юм баруун бүсийн 9 эрчим хүчний компанийг нэгтгэн нийлүүлэх замаар 4 болгож өөрчлөн байгуулсан байгаа. Засгийн газрын шийдвэр гарч.

Мөн зарим нэг ашиггүй ажиллаж байгаа шаардлагагүй мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой гэж үзсэн компаниудыг төрийн өмчит үйлдвэрийн газруудыг татан буулгасан ийм Засгийн газрын шийдвэр гарсан.

Тэгээд энэ ажлыг цогц байдлаар... /минут дуусав/

О.Номинчимэг: 3.Мөнх-Эрдэнэ дарга аа, миний асуулт болохоор улсын 2026 оны улсын төлөвлөгөөнд дотоодын нийт бүтээгдэхүүний 24 хувиас дээшгүй зардал урсгал зардал байна гэдэг юуг Сангийн яам энэ төсөв дээрээ яг бариад ороод ирсэн.

Яг энэ адилхан төлөвлөгөөнд байгаа хоёр тоо буюу ТӨК-ийн зардлыг 15 хувиар бууруулна, бүтээмжийг 30 хувиар бууруулна гэдэг тооцоолол нь хийгдээд яг үүний дагуу төсөвт суусан байгаа юу? Үүний яг тодорхой мэдээллийг өгөөч ээ гэж байгаа юм.

1 номер. Д.Мөнх-Эрдэнэ дарга. Хэрэг эрхлэх газар.

Д.Мөнх-Эрдэнэ: Төсвийн хувьд яг тусгагдаагүй байгаа.

Гэхдээ энэ ажил өөрөө түрүүн хэлдгээр цогц байдлаар нэгдсэн, аль асуудлыг нь Улсын Их Хурлын түвшинд шийдэх вэ, аль асуудлыг нь Засгийн газрын түвшинд өөрөө шийдэх вэ гэдгээ ажлын хэсгийн хүрээнд нэгдсэн цогц

байдлаар саналаа боловсруулаад танилцуулахаар ажиллаж байгаа гэдгийг хэлье.

О.Номинчимэг: Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн асуулт, хариулт дууслаа.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Үг хэлэх гишүүд. Ж.Галбадрах гишүүнээр тасалъя.

Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн үг хэлье.

Ц.Мөнтуяа: 2026 оны улсын төсөв хэлэлцэж байгаатай холбогдуулан Боловсролын сайд П.Наранбаяраас асуулт байна.

Энэ 2026 оны. Тийм. Санал байна. “Боловсролын жил” гэж зарласан. Тэгээд энэ боловсролын салбарын төсвөөс бараг 1 их наяд төгрөгийн алдагдалтай төсөв батлагдсан.

Энэ дээр тэгээд хариуцлагыг хэн үүрэх вэ. 300 мянган хүүхдийн эрх ашиг зөрчигдөж, 16 мянган багш, ажилтны цалин, хөлс юмнаас нь багасаж байгаа шүү дээ. Энэ хохирлыг хэн барагдуулах юм. Тэгээд бүгдээрээ чимээгүй байгаад байх юм уу.

2026 оныг “Боловсролын жил” гээд зарласан байдаг. Тэгээд боловсролын салбарын багш, ажилтнууд нь хамаг мөнгө, хамаг төсвөө тануулсан. Хүүхдүүд нь хувьсах зардлаа тануулсан сууж байна шүү дээ.

Тэгээд одоо П.Наранбаяр сайд хөөрхий гүйгээд л байна, гүйгээд л байна. 100 тэрбум төгрөг л олсон гээд яриад байгаа юм. Тэгээд дахиад цаана нь 400 гаруй тэрбум төгрөг олох шаардлагатай байна шүү дээ.

Тэгээд түрүүн манай Д.Ганмаа гишүүн хэлж байна шүү дээ. Баахан барилга, байшин барих болохоороо мөнгө байгаад олдоод байдаг. Хүндээ мөнгө өгье, зарцуулъя гэхээр мөнгө байхгүй. Мөнгө ерөөсөө бүтэхгүй, болохгүй. 24 хувийн юуг дээш нь болгож болохгүй гээд яриад байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ хүн рүү чиглэсэн мөнгө төгрөгөө танаж хасаж, харамладгаа хэзээ болих вэ. Жишээ нь, тэр Азийн хөгжлийн банк 150.0 сая доллар зээлээд сургууль, цэцэрлэг барина гээд байгаа юм. Тэр сургууль, цэцэрлэгт нь ажиллах багш байхгүй шүү дээ. Сая энэ намар 5 мянган багшийн хомсдолтой. 2030 онд 23 мянган багшийн хомсдолд орно гээд Боловсролын яамнаас судалгаа гарсан байна шүү дээ.

Энэ асуудлаа ярихгүй юм уу. Ингээд л нэг тулга тойрсон. Нэг нь асууж, нөгөөдөх нь хариулсан болоод ингэж цаг барж суух хэрэг байгаа юм уу.

Энэ хүн рүү чиглэсэн урсгалаа яах юм. Мөнгөний урсгалаа. Багш нар чинь өнөөдөр бас ингээд итгэлээ алдаагүй, итгэлээ хөсөрдүүлээгүй хүлээгээд л суугаад байгаа шүү дээ. Энэ бодлого барьж байгаа хүмүүс ямар шийдвэр гаргах нь вэ гээд бид нарыг хүлээж байна шүү дээ.

Тэгээд бид өнөөдөр энд худлаа хэдэн тоо наана цаана нь оруулж яриад л. Байшин, барилга барих болохоор мөнгөтэй болдог. Энд тэндээс мөнгө зээлдэг.

Ахмадуудынхаа тэтгэврийг тавья, багш, эмч нарынхаа цалинг нэмье гэхээр мөнгө байхгүй.

АСЕМ гээд нэг том юм байгуулсан шүү дээ. Хэчнээн тэрбум, хэдэн их наядаар ч боссон юм. Хэдэн баячууд нь хуваагаад авсан гээд ярьдаг биз дээ. Тэгээд дахиад тэр 150.0 тэрбумаар байшин босгоод, дотор нь 60 хэдэн тэрбум төгрөгөөр 200 гаруй тэрбумыг дахиад салхинд хийсгэх гэж байгаа юм уу. Энэ чинь ахмадын тэтгэвэр нэмэх мөнгө биш юм уу.

Ингээд яривал ярих юм бид нарт зөндөө байна.

Ингээд хамгийн гол нь П.Наранбаяр сайд одоо энэ багш нарын цалинг 25 хувиар нэмнэ гээд л яриад байгаа. Тэр асуудал дээрээ ямар ажил хийж санаачилж явна. Нэг ажлын хэсэг байгуулсан. Түүндээ багш нарынхаа үйлдвэрчнийг оруулахгүй ялгаварлан гадуурхаад, хүний эрх зөрчөөд, Үйлдвэрчний эвлүүдийн эрхийн тухай хуулиа зөрчөөд явж байгаа шүү дээ. Та нар.

Багш нар чинь гадаа хүлээгээд жагсаад, ажил хаялт хийх гээд байж байхад энэ дотор бид худлаа хэдэн тоо хойно урд нь оруулж яриад байх шаардлага ер нь байхгүй.

Тэгээд энэ 560 тэрбумаасаа 100 тэрбумыг нь олсон. Үлдсэн мөнгийг нь яаж олох гэж байна П.Наранбаяр сайд аа. Энэ дээр нэг хариулт өгөөч. Тодорхой.

Анхааралдаа аваарай. Тийм.

О.Номинчимэг: Энэ дараагийн хэлэлцэх асуудалтай холбоотой хариулт байна байх.

Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн үг хэлье.

С.Эрдэнэбат: Инфляцыг жил болгон төлөвлөхдөө ойлгож байна. Хамгийн багаар тавьж хүлээлттэй байдаг учраас, нийгэмд нөлөө үзүүлдэг учраас 6 хувь, 7 хувь л гээд байдаг.

Тэгэхдээ бодит байдал дээр энэ дээрээ хүрдэггүй. Үр дүнд юу вэ гэхээр хүмүүсийн бодит орлого 2-оос 3 пункт, 4 пунктээр худалдан авах чадвар нь буурч байна л гэсэн үг байхгүй юу.

Яг ний нуугүй хэлэхэд бас бид боломжоо дайчилбал боломж байгаа шүү дээ. 2023 онд гэхэд Эрдэнэс Тавантолгойн тэр нэг нүүрсний хулгай хийдэг, цавчаа юу хийдэг юмыг нь ингээд нэг БЭТ томилоод. Одоо Ж.Ганбат дарга өөрөө очсон санаж байна.

Тэндээс бараг 900, 1 их наяд төгрөг гараад л байсан шүү дээ. Тэгээд түүгээр цалин, тэтгэврээ нэмсэн шүү дээ. Тэгэхээр иймэрхүү арга хэмжээнүүдийг хиймээр байна.

Түрүүн О.Номинчимэг даргын асуудаг тэр төрийн өмчийн компанийн бусад боломжтой эх үүсвэрүүд дайчлах юм бол асар их мөнгө харин энэ элдэв янзын авлига, хулгайн замаар орж байгаа асуудал байгаа шүү гэдгийг хэлмээр байна.

Хоёрдугаарт, хөрөнгө оруулалтыг эрэмбэлээд харах юм бол энэ хэдэн сайд нар хоорондоо ярьж сууж байгаад л тэгээд л өөрийнхөө тойрог руу л нэг жоохон юм хийдэг л юм шиг байна л даа. Хэлж чадахгүй байх шиг байна. Одоо ингээд харсан чинь нэг хэсэг авто замд холбосон.

Одоо тэгсэн чинь говь руу баахан замаа холбоно гээд л. Одоо тэгээд энэ бүсүүд нь өөрийн бүсээс Зам, тээврийн сайдтай зам, гүүр нь олигтой явдаг нэг ийм жишиг баймааргүй байгаа.

Тэгэхээр эрэмбэлэх юмаа яг тодорхой, шударга хүртээмжтэй байдлаар хиймээр байна.

Би ганцхан жишээ хэлье. Хөвсгөл аймгийн тэр Багтагын гүүр гээд үйл ажиллагааны төлөвлөгөөнд оруулсан. 3 сум нь тэр гүүр байхгүй бол хойшоо явах боломж байхгүй. Аялал жуулчлалын хамгийн гол бүс нутаг байхгүй. Тэгэнгүүт зүгээр нэг нуур луу зам татна гээд тавьж байгаа байхгүй юу. Хүнд үзүүлэхийн тулд. Нуурыг үзүүлэхийн тулд. Эсвэл нэг сүм рүү. Нэг сүм үзүүлэхийн тулд.

Энэ чинь төсвийн эрэмбэ юм уу? Би хэрвээ үүнийгээ засахгүй бол, үүнийгээ маш тодорхой ойлгомжтой тайлбарлахгүй бол зарчмын санал гаргаад үүнийг өөрчлөхгүй бол яг л энэ байдлаар явна. Бид мянга үг хэлээд нэмэр байхгүй. Тэгээд хэн илүү тэр сайдтай нөлөөлсөн, Сангийн яаманд нөлөөлсөн тэр хүмүүс нь л юмаа тавиулдаг л нэг ийм юм мөнхөд үргэлжлэх юм байна л даа.

Тэгэхээр Сангийн яам маань зарчмаа баривал яг барь. Бүгдийг нь хас. Эсвэл. Эсвэл бүгдийг нь жигд шударгаар тавь.

Дараагийнх нь, зарим боломж гээд л байх юм. Алт тушаалт гээд л байдаг юм. Одоо тэгээд манай хамгийн их үнэ нь өсөж байгаа юм маань алт тушаалт нь бараг хоёр, гурав дахин буурсан. Үнэ нь өсөөд байдаг. Тэгээд энэ хууль хяналт, Сангийн яам маань ямар арга хэмжээ авдаг юм. Одоо энэ хажуухан талд сайд нар тэр Оюу Толгойн юутай ажлын хэсэг гээд л хуралдаж байна. Бид чинь бараг цалин, тэтгэвэр, тэтгэмж, энэ салбараа өөд нь татах хэмжээний өчнөөн их наядын хэмжээний боломжийг алдсан юм байна лээ шүү дээ.

Тэгэхээр ийм ийм боломжоо дайчилдаггүй. Эс үйлддэг. Тэгэхээр энэ зүйлүүдээ энэ төсөв дээрээ нэмж оруулж ирэх боломж хэрэгтэй байна.

Дээрээс нь би ганц санал хэлье. Түрүү жилжингээ хөдөлмөрийн аюулгүй байдлын зардал гээд л хэлээд л байсан. Эрчим хүчний яаман дээр 400 сая төгрөг тавиулсан. Тэрийг нь хэрэгжүүлээгүй юм билээ. Гэтэл яасан. 100 тэрбум төгрөгөөр станц шатсан. Маш жижигхэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлийг хаах хэмжээний ажил хийсэн бол өнөөдөрийн III цахилгаан станц дэлбэрэх байсан уу, үгүй байсан уу. Ингээд нөгөө харамч хүн хоёр дахин төлнө гэгчээр харахад нэг тийм чухал биш зардал харагдаж байгаа боловч цаанаа маш их олон нийгэм, эдийн засаг, хөрөнгө мөнгөний эрсдэл гараад байгаа юм.

Тийм учраас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардал дээрээ хуулийнх нь дагуу, шаардлагынх нь дагуу тэр мөнгийг нь тавиарай гэдгийг хэлмээр байна.

Эцэст нь хэлэхэд тэр төрийн албан хаагчийн 20, 30 жил хүлээж байгаа тэр тэтгэмжийг нэг их олон оролдоод хэрэггүй байх. Магадгүй үүнийг олон оролдох юм бол тэр сургаар нь маш олон хүмүүс тэтгэвэртээ гаръя гэдэг байдлаар энэ жил төсвийн ачааллыг бараг 100 тэрбум төгрөгөөр ороод ирсэн байна шүү дээ. Аргагүй шүү дээ. Эд нар чинь.

О.Номинчимэг: Б.Пунсалмаа гишүүн үг хэлье.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу? Өдрийн мэнд хүргэе.

2026 оны төсөв хэлэлцэж байгаа энэ үед Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг асуулт асуух гэж байгаад сая бас хурал давхацлаа. Тэгээд үг хэлье.

Эрүүл мэндийн даатгалын санд хандаад хэлэхэд өнөөдөр хүмүүс иргэд маань өвдөөд эмчид цаг авахаар сарын дараа цаг өгөөд байгаа юм. Тэгээд сар хүлээдэг өвчлөл гэж байхгүй шүү дээ.

Тэгээд хувийн эмнэлэг, тэгээд таньдаг тал гээд. Энэ тогтолцооны хувьд зөв тогтолцоо гэж үзээд байна уу. Манай Эрүүл мэндийн яамныхан.

Иргэд маань бүгдээрээ татвараа төлж байгаа, Эрүүл мэндийн даатгалаа төлж байгаа. Энэ зүгээр л Эрүүл мэндийн даатгалаар асуудалгүй үзүүлмээр байгаа юм шүү дээ.

2019 оноос хойш энэ сан чинь ерөөсөө 6, 7 дахин өссөн байгаа. Хүн ам 6, 7 өсөөгүй. Эм, эмчилгээний чанар 6, 7 дахин сайжраагүй байдаг. Тэгээд манай энэ Эрүүл мэндийн яамныхан энэ тал дээрээ Та бүхэн минь ямар дүгнэлт хийж, хаанаа ер нь гацаа үүсээд эрүүл мэндийн салбар чинь асуудал болоод байгаа юм бэ. Энэ дээрээ Та бүхэн минь яаж ажиллаж байгаа юм.

Манай Ардчилсан намаас Эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагаан дээр хяналт тавих ажлын хэсэг байгуулагдсан. Бид энэ эмнэлгүүдээр орж тэндхийн зовлон жаргалуудыг бүгдийг нь сонссон. Мэдэж байгаа. Яамнаас бид хамтарч ажиллах, бид ийм хөтөлбөрүүд хэрэглэж байна, энэн дээр хамтарч ажиллая гэдэг энэ саналыг хэлэх байх гэсэн хэлээгүй байна.

Тэгэхээр яамнаас би гишүүнийхээ хувиас нэг мэдээлэл нэмж авмаар байна. Энэ эмнэлгүүдэд ер нь тарифаар хагалгаа, эмчилгээ сувилгаанд ямар тарифаар санхүүжилт олгож байгаа юм бэ. Энэ санхүүжилтийн хэмжээг 2025 оны байдлаар авмаар байна. Ингэж байж бид энэ дээрээ үнэн бодит анализ дүгнэлт хийгээд, энэ салбарыг сайжруулах хэрэгтэй. Хөрөнгө мөнгө дутаагүй. Энд менежмент дутаж байгаа. Бид хамтдаа үүнийг менежментийг нь олоод ер нь ямар асуудал байгааг манай Ардчилсан намынхан бүгдийг нь аягүй сайн ойлгосон байгаа. Одоо бид энэ асуудлуудаа нэгтгээд гаргалгааг нь гаргах л ийм хэрэгтэй байгаа. Манай энэ Эрүүл мэндийн яамныхан энэ дээрээ илүү анхааралтай, бас хурдтай ажиллах хэрэгтэй байна. 2025 оны төсөв баталж байхдаа л эгий минь энэ жил хамгийн сайн ажиллана, ашигтай ажиллана гэсэн. Дахиад л алдагдалтай, өртэй байгаад байдаг. Бид нарт цаг хугацаа байна. Боломж байна. Одоо ер нь яаралтай л энэ шийдлүүдээ гаргамаар байна. Баярлалаа.

О.Номинчимэг: Үг хэллээ. Дүгэрийн Рэгдэл гишүүн үг хэлье.

Д.Рэгдэл: Баярлалаа.

Энэ жил Засгийн газраас оруулж ирж байгаа төсөв дээр хөрөнгө оруулалтын бодлого дээр нэлээн ахиц гарсан гэж харж байгаа. Ганцхан жишээг хэлэхэд ямар ч байсан 2026 онд графикайнхаа дагуу дуусгах хөрөнгө оруулалтууд, бүтээн байгуулалтаа ондоо багтааж дуусгахаар зориод, үлдсэн санхүүжилтийг өгч байгаа бол их том дэвшил. Үүгээр дамжуулж он дамжсан бүтээн байгуулалтууд цаашдаа багасах байх гэж бодож байгаа. Үүнийгээ хатуу барьж явмаар байгаа юм.

Ер нь Их Хурлын гишүүд маань Засгаас оруулж ирсэн төсвийн зарлагыг нэмэх, зарлага талыг нь нэмэх. Түүгээрээ дамжуулаад тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг нэмэгдүүлэх ийм санал хэлэх эрх угаасаа байдаггүй учраас манай гишүүд тэр 24 хувь дээр их олон санал хэллээ. Дараа дараагийн хэлэлцүүлэгт энэ 24 хувийг яах вэ гэдэг дээрээ Засгийн газар тодорхой саналтай орж ирмээр байна.

Зүгээр яах вэ, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлдэггүй юм гэхэд хадгалах бодлого дээр Эдийн засаг, хөгжлийн яам анхаарч ажилламаар байгаа юм.

Ер нь яах вэ, үнийн өсөлтөөс сэргийлэх бодлого байна. Тэгэхдээ энэ бодлого төсөв дээр яаж бодитойгоор орж ирэх вэ. Энэ гаргалгааг олж явах юм бол цалин, тэтгэврийг нэмнэ гэхээсээ урьд энэ орлогыг нь хамгаалах ажил бодитойгоор хийгдэнэ. Үүнийг зүгээр нэг тийм бодлогын баримт бичиг байдаг гэдэг хэмжээгээр явмааргүй байна.

Гурав дахь асуудал бол Баялгийн сангийн тухай асуудал байгаа юм. Энэ дотор чинь Хөгжлийн сан гээд нэг сан байгуулагдах ёстой юм. Тэгтэл өдийг хүртэл Хөгжлийн санд ерөөсөө юм орж ирэхгүй байгаа. Хөгжлийн сан байгуулагдвал эндээс тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хөгжүүлэх суурь салбарууд руу орох боломж нээгдэнэ гэж бид хүлээж байдаг. Үүнийг бий болгох тал дээр Сангийн яам их анхаармаар байгаа юм. Хуулийн шинэчлэл энэ тэрээрээ дамжуулдаг юм уу, ямар нэгэн байдлаар анхаарч өгвөл их чухал.

Хөрөнгө оруулалтын хувьд энэ зураг төсөвгүй нэлээн объект байх шиг байгаа юм. Үүнийг хасмаар байгаа юм. Шууд.

Тэгэхээр дараа нь тийм юм оруулах гэдэг. Оруулж та нарыг зовоодог улсуудын тоо их цөөрнө. Тэрнийгээ хасаад ороод ирвэл их сайн.

Тэтгэвэр, тэтгэмжийн. Манай ахмад настнууд энэ гадаа яагаад жагсаад байна вэ гэхтэй зэрэг энэ бага тэтгэвэртэй хэсэг нь жагсаж байгаа. Бага тэтгэвэртэй гэдэг нь 2013 оны 09 сарын 01-нээс өмнө тэтгэврээ тогтоолгосон. Зарим судалгаагаар 90 мянга гэдэг. Зарим судалгаагаар 200 мянга ч гэж гардаг. Ахмадууд. Эд нарын маань тэтгэвэр тэдний тэр өдрийн маргааш нь тэтгэвэр тогтоолгосон улсуудынхаасаа үндсэндээ 3 дахин доогуур болсон. Энэ зөрүүг арилгаад өгөх юм бол энэ жил болгон инфляцтай уялдуулж тэтгэвэр нэмдэг энэ тогтолцоо бодитойгоор ажиллана гэж би үздэг.

Зүгээр жил болгон инфляцтай уялдуулж тэтгэвэр нэмнэ гэдэг уг нь их том дэвшил болсон шүү дээ. Үүнийг үнэгүйдүүлж байгаа юм нь энэ зөрүүн дээр ерөөсөө ажиллахгүй, энэ индексийг нь шинэчлэхгүй гээд бараг хууль, тогтоол ч гарсан юм уу ийм юм болоод байгаа юм.

Үүнийг сайн судалж, энэ хэсэг улсуудын тэтгэврийн зөрүүг арилгах юм бол энэ жил болгоны нэмэгдэл ач холбогдлоо өгнө.

Ингээд бодоод байхад ер нь хийвэл зохих ажлууд нэлээн байна. Энэ тэтгэвэр маш амин чухал. Зүгээр хэмнэлтийн бодлого бид хэрэгжүүлэх ёстой. Хэмнэлтийн бодлого хэмнэлтийн тухай хууль гээд нэг сайхан хуультай.

1 минут авчих уу?

О.Номинчимэг: Д.Рэгдэл гуайн тэр инфляцыг бууруулах урьд арга хэмжээнүүд чинь төсөв дээр яг буусан байх ёстой шүү. Төсөөлөөд төсвийн хүрээний мэдэгдэл дээр орох биш, яг инфляц өдөөдөг энэ асуудлуудаа бас шийдсэн юмнууд орох ёстой шүү гэдэг юмыг И.Батхүү дарга таныг байхгүй хойгуур хэллээ. Та бүхэн бас энэ дээр анхаарна биз.

Эдийн засаг, хөгжлийн яамыг анх байгуулахдаа яг энэ макро эдийн засгийн бодлогоо л аягүй сайн авч явъя гээд л уг нь байгуулсан шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр бодит амьдрал дээр тэр бодлого чинь тусдаг байх арга хэмжээнүүдээ бас харж авахгүй зүгээр нэг тооцоолол хийгээд орхидог байгууллага биш байгаасай гэж хүсэж байгаа.

Даваасамбуугийн Ганмаа гишүүн үг хэлье.

Д.Ганмаа: Түрүүн асуусан асуултад яах аргагүй арга, аргачлалд тулгуурлаж эрэмбэлдэг гэсэн хариултыг авсан. Их баяртай байна. Энэ арга аргачлал байгаад.

Тэгээд миний гаргасан жагсаалт 5 хуудас жагсаалт байгаа. Зөвхөн жишээ болгож минутдаа багтааж хоёр яаман дээр тавьсныг хэлсэн. Энэ жагсаалтын 5 хуудсыг би Өргөдлийн байнгын хороонд сая тавилаа. Энэ Өргөдлийн байнгын хорооноос ийм санал л байна. Надад.

Сангийн яамнаас, Эдийн засгийн яамнаас, энэ эрэмбэлдэг газруудаас хөрөнгө оруулалтын төсөл барилга, байгууламжийн санхүүжилтийг эрэмбэлэхдээ хэрэглэдэг нэрлэсэн арга, аргачлалууд тус бүрээр нь Монгол Улсад хэрхэн албан ёсоор хэрэглэсэн юм. Аль салбарт, хэдэн удаа, яаж, ямар баримт бичиг дээр тулгуурлан ашигласан юм. Үр дүн нь хаана тусгасан юм гэдэг нарийвчилсан жагсаалт тайланг гаргуулж авъя.

Тэгснээрээ хэрвээ шаардлагатай гэж үзвэл эдгээр хөрөнгө оруулалтыг бид Улсын Их Хурал дээр бас танилцуулъя. Өргөдлийн байнгын хорооноосоо дүгнэлт гаргаад.

Ингэснээрээ бид энэ эрэмбэлэлтийг маш тодорхой ойлголттой болж аваад бодлогыг яам тус бүрээс шаардах энэ үндэс суурь нь тавигдана.

Хоёрдугаарт, ингэж яам хэлсэн, тэр тэгж хариулсан гэсэндээ биш, энэ баримтжуулсан нотолгоо, хэрэглэсэн аргачлалтай болох ийм жишээ, жишгийг тогтоох саналтай байна.

О.Номинчимэг: Яах вэ, энэ асуудлаар гишүүний бүрэн эрхийн хүрээнд та энэ мэдээллийг бас авах нь зөв байх.

Яг төсвийн хөрөнгө оруулалтын эрэмбийн асуудал эрхлэх асуудлынхаа хүрээнд бас Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороонд очих учраас Байнгын хороо гэхээсээ илүү гишүүний бүрэн эрхийн хүрээнд үүнийг манай гишүүд бүгдээрээ санал гаргаад авах боломжтой.

Тэгэхээр энэ дээр манай энд сууж байгаа Сангийн яам, тэр төсвийн эрэмбэлэлтэй бүгдийг чинь нарийвчилсан Д.Ганмаа гишүүний тэр асуултад бичгээр тэр нарийвчилсан мэдээллүүдийг нь өгөөрэй гэж бас хэлмээр байна.

Жанчивын Галбадрах гишүүн үг хэлье.

Ж.Галбадрах: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Хоёр, гурван санаа байна.

Ер нь би сая Хүний хөгжил, нийгмийн бодлогын хороон дээрээ асуултуудаа асууя гээд орхисон байна. Сая асуудаг байж гэж бодож байна.

Эрэмбийн тухай асуудал яригдаад байна. Тэгээд би Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яаман дээр очиж ер нь боловсролын салбарын доторх эрэмбийн тухай ярьсан. 10 шатлалтайгаар очиж танилцуулж, хүмүүсийг нь суулгаж байгаад яриад энэ их чухал байгаа юм. Тэгээд өнөөдөр бид ингээд эрэмбэлээд үзэх юм бол боловсролын салбарт сургалтын чанар ярих нөхцөл алга.

Хамгийн нэгдүгээрт сургуулийн барилгын хүртээмж маш хангалтгүй байна. Боловсон хүчин, багшийн хомсдол бүр үнэхээр бодитоор нүүрлэчхээд байна. Бид багшгүй сургуультай болох гээд байна гэдэг асуудлуудаас тавьж байж байгаад бид танилцуулаад их ойлгомжтойгоор нэлээн ярьсан.

Тэгээд энэ дээрээс үндэслээд 108 сургууль, 95 цэцэрлэг гэдэг тоог бид хамтдаа гаргаж ирсэн. Нийслэлдээ хэдийг нь тэрийгээ барих юм, байгуулах юм. 3 жилээр бүр төлөвлөсөн. Хамгийн нэгдүгээрт алинаас нь эхлэх юм гэдэг эрэмбийг хүртэл бүр тэр дотор нь тогтоогоод.

Өнөөдөр ерөөсөө сургалтын чанар ярих тухай яригдахгүй байна шүү. Ерөөсөө л тэр чанарыг бүрдүүлэхэд анхан шатын анхдагч суурь нөхцөлийг

гаргах шаардлага байна л гэдгийг тавьж ярьсан. Тэгээд өнөөдөр энэ бодлого энэ дээрээсээ гарч ирэх ёстой гэж хүлээж байсан. Төсөв бодлогын толь байгаа. Тэгээд энэ дээр ерөөсөө тусаж орж ирээгүй. Харамсалтай байгаа.

Тэгээд Та бүхнийг яг энэ боловсролын салбарыг нь үнэхээр тэргүүлэх салбар гэж үзэж байна уу? Хүний хөгжил бол мега төслийн хэмжээнд авч үзнэ гэсэн Засгийн газрын бодлого нь эндээ тусаж байна уу гэдэг бас энэ боловсролын салбарт оруулж ирсэн. Үүнээс л харагдаж байна л даа.

Тэгээд ер нь хоёрдугаарт нь татвар төлөгчид ер нь бид нараас юу хүсээд байгаа юм. Ерөөсөө л хүүхдэдээ чанартай боловсрол л хүсэж байна. Хамгийн нэгдүгээрт Монгол Улсад.

Хоёрдугаарт, эмнэлгийн чанартай үйлчилгээ хэрэгтэй байна. Тэгээд энэ ядуурал, орлого олох. Тэгээд энэ талаар ярьж байна. Би боловсролынхоо чиглэлийг л ярьдаг хүн. Бид нараас хүсээд байгаа тэр чанартай боловсрол, тэр хүртээмж, тэр багшийн хомсдолыг арилгах талаар ялангуяа тэр багшийн хомсдол. Хүртээмжийн талаар бүр тодорхой гаргаад өгсөн.

Багшийн хомсдолын талаар 14 мянган багш 2028 он гэхэд 3 жилийн хугацаанд 14 мянган багш бид даруй бэлдэх шаардлагатай байна. Үүнийгээ хаана хаанаас бэлдэж болох вэ гэдэг бүр тооцооллыг хүртэл гаргаад, энэ дээрээсээ бид цааш нь ингээд төсөвтөө тусгаад явъя гэсэн. Үнэхээр багшийн хомсдолыг арилгах нь битгий хэл багшийн цалингаа нэмэхгүй ийм төсөв орж ирж байгаа учраас энэ гишүүдийн яриад байгаачлан багшийн ажлаас гарах энэ хурд нэмэгдэх гээд байна.

Тэгээд энэ багшийн ажлын хурд, ажлаас гарч байгаа хурд нь хэдэн жил ажилласан хүмүүстэй гараад байгаа юм. Яагаад ажлын байрны нөхцөл нь ямар байгаа юм. Тэр нөхцөлийг сайжруулах талаар ямар юм тусах юм гэдэг хүртэл тэр дотогшоогоо ерөөсөө орж чадахгүй байна.

Тэгээд Боловсролын яамныханд хандаж хэлэхэд ер нь бид багшийн цалин, барилга, хоёроо л ярьж байгаа. Зүгээр анхдагч юм. Үүнээс гадна бид нарт тэр сургалтын шинэчилсэн хөтөлбөрүүд, шинэчлэл хийх, шинэ технологи нэвтрүүлэх, дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхах талаар ямар төсөл, арга хэмжээнүүд төлөвлөж байгаа юм бэ. Ерөөсөө тэр төсөл, арга хэмжээнүүд бас байхгүй байгаа. Ер нь тэгээд боловсролд реформ хийхэд тэр реформ нь зэрэг хийгдэж явах ёстой. Явал энэ сайжрах ёстой юм гэдэг талын юмнууд алга байна. Тэгээд бид нөгөө... /минут дуусав/

О.Номинчимэг: Равжихын Эрдэнэбүрэн гишүүн үг хэлье.

Р.Эрдэнэбүрэн: Яах вэ, энэ төсөв цаашаа ингээд явах явахгүй нь бас нэлээн тодорхойгүй л байна. Тодорхойгүй болгож байгаа энэ байдлыг манай энэ эрх баригчдын гаргаж байгаа үйлдлүүдээс болж байгаа гэж хэлмээр байна

Хоёрдугаарт, Ерөнхий сайд энэ төсвийг хүнээ бодсон төсөв болсон гэж ингэж зарлаж хэлж байгаа. Мэдээж хүнээ бодолгүй яах вэ. Тэгэхдээ энэ хүнээ бодохын тулд мөнгөтэй байх ёстой, орлого олох ёстой. Энэ төсвийн нэг сул тал нь яаж орлогоо нэмэгдүүлэх гэж байгаа гэдэг нь тодорхойгүй байгаа. Хөрөнгө оруулалтууд нь яаж эрэмбэлэгдсэн юм бэ, яаж мөнгө олох гэж байгаа юм бэ гэдэг нь асар тодорхой бус байгаа. Зарлага л нэмэх юм яриад байгаа.

Одоо тэгээд цаашдаа улам зарлага нэмэгдэх юм байна. Одоо энэ зарлагын тэр 24 хувийг авъя гэж байна. Бүх сайд нар цалин юмаа нэмнэ гэж байна. Одоо тэгээд удахгүй 2027 он болно. Нөгөө Ерөнхийлөгчийн сонгууль гээд бас дахиад уралдана.

Тэгэхээр яаралтай орлого олох талаа анхаарахгүй бол хэцүү болох нь байна шүү л гэдгийг хэлмээр байгаа юм.

Тэгээд орлого олж байгаа төсөв рүүгээ хөрөнгө оруулалтаа хийж байгаа юм болов уу гэхээр бас байхгүй байгаа. Сангийн яам хэдэн боомтууд дээр хөрөнгө оруулж байгаа гэж байна. Боомтууд руу очихоос наана энэ баялаг чинь өөрөө.

Манай говь асар зөөлөн хүлээцтэй. Энэ улсыг тэжээж тэтгэж явах явж байгаа гэдэг дээрээ зөвшөөрөөд явцгааж байгаа. Хоёрхон л зүйл хүсэж байгаа шүү дээ. Энэ бэлчээр талхлаад болж өгөхгүй байна. 10, 20, 30 километр өргөн замууд гараад байна.

- ▶ Замтай болгоод өгөөч ээ.
- ▶ Усны төсөл хэрэгжүүлээд өгөөч ээ.

Усгүй болоод байна. Энэ уул уурхайгаас чинь болоод. Хоёулан дээр “тэг”. Энэ хөрөнгө оруулалтууд.

- ▶ Усны төсөв дээр “тэг”.
- ▶ Төсвүүд дээр “тэг”.
- ▶ Замууд “тэг”.

Сая С.Эрдэнэбат гишүүн хэлж байна. Тэр Ховдод нэг уул уурхайн ганц төсөл яриад улсын хэмжээнд бүр сонсгол яригдлаа. Бүх сумаа холбосон. Тэгэхдээ С.Эрдэнэбат нэг зүйлийг буруу хэлж байна. Тэр манай говиос сонгогдсон зам тээврийн сайд энэ сумдуудаа холбох нь битгий хэл бүсийнхээ аймгийн хоёр төвөө холбож чадахгүй яваад байгаа. Чойр, Мандалговийн зам дээр “тэг”.

Тийм учраас энэ дээрээ анхаарч өгөөсэй гэж бодож байна.

Гуравдугаарт нь, хэмнэлтийн хууль гээд энэ дээрээ зоригтойхон арга хэмжээ аваад явахгүй бол энэ ажил чинь явахгүй. Ялангуяа одоо ингээд эмх цэгцтэй болгож байгаа нь гээд бүгдийг нь хурааж аваад байх юм бол орон нутагт ч гэсэн юу ч хийж чадахгүй байна шүү дээ.

Цаг агаарын нөхцөл байдал, улирлын нөхцөл байдал ямар билээ. Бид мэдэж байгаа шүү дээ. Төсвөө дэг журамтай болгох гэж байгаа нь энэ гээд мөнгө олдог хөрөнгө оруулалтаа зогсоогоод байвал тэгээд яах юм бэ. Орлого олохгүй бол юу болох юм бэ. Эрүүл мэндийн төсөв нэмэгдсэн л гээд байна. Ноднин хэмнэлттэй хэлэхэд эрүүл мэндийн чинь хамаг төсөв нь хураагдаад л явсан шүү дээ. Боловсролын яамны хамаг төсөв нь хураагдаад л явсан. Хөрөнгө оруулалтууд нь.

Тэгэхээр энэ дээр нэг зоригтой шийдэл гаргаад энэ хэмнэлтийн хуулийг явуулах, явуулахгүйгээ шийдээд явахгүй жилийн эхний хэдхэн дулаан эхлээд ганц нэг сар болоогүй байхад нь хамаг юмыг нь зогсоох юм бол тэгээд мөнгө олдог юм байхгүй болох л, хөрөнгө оруулалт чинь байхгүй болно.

Хөрөнгө оруулалт байхгүй бол тэгээд мөнгө олдог юм чинь байхгүй болно. Тэгээд тэд хэдий хүртэл урсгал зардлаа хаанаасаа яаж. Эсвэл одоо тийм нуусан, дарсан их мөнгө байгаад байдаг юм уу гэж л хэлмээр байх юм.

О.Номинчимэг: Гишүүд үг хэлж дууслаа.

Өргөдлийн байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Хэлэлцүүлэг хийсэн талаарх танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ. Ажлын хэсэгт баярлалаа.

Дараагийн асуудалдаа оръё.

**Гурав.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан
иргэдийн өргөдлийг хэлэлцэх**

/Эмч, багш нарын цалинг нэмье гэсэн асуудлаар
ажлын хэсэг байгуулах, (үргэлжилнэ)/

Нийтийн өргөдлийн тухай. Манай Сангийн яамныхан байж байх байх. Тийм үү? Байж байгаарай.

Нийтийн өргөдлийн тухай буюу Монгол Улсын иргэн Б.Номингоос ирүүлсэн эмч, багш нарын цалинг нэмье гэсэн асуудлаар ажлын хэсэг байгуулах нийтийн өргөдлийг 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 21 цаг 02 минутад хүргүүлснийг Улсын Их Хурлын нийтийн өргөдөл, гомдлын системд 2025 оны 07

дугаар сарын 01-ний өдөр байршуулж, 33 мянган иргэний дэмжсэн санал авсан асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5-д нийтийн өргөдлийн цахим системд 30 хоногийн хугацаатай байршуулах ба уг өргөдлийг Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэдийн дэмжсэн санал хураах тоонд хүрсэн тохиолдолд Улсын Их Хурал авч хэлэлцэнэ гэж, 39.5.3-д тодорхой асуудлаар ажлын хэсэг байгуулах саналыг 33 мянга ба түүнээс доош тооны иргэн дэмжсэн бол гэж заасны дагуу Монгол Улсын иргэн Б.Номингоос ирүүлсэн “Багш, эмч нарын цалинг нэмье” гэсэн асуудлаар ажлын хэсэг байгуулах нийтийн өргөдлийг 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 21 цаг 02 минутад ирүүлснийг Улсын Их Хурлын нийтийн өр, өргөдөл, гомдлын системд 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр байршуулж, 33 мянган иргэний дэмжсэн санал авсан нийтийн өргөдлийг Байнгын хорооны 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаан дээр танилцуулсан.

Уг асуудлыг үргэлжлүүлж хэлэлцэнэ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Байнгын хорооны хуралдаанд оролцох албан тушаалтнууд. Ажлын хэсгийг оруулъя. Ажлын хэсгийг оруулаарай. Манай Байнгын хорооны ажлын албаныхан. Ажлын хэсгийн ширээн дээр наашаагаа сууцгаагаарай.

Албан тушаалтны нэрсийг танилцуулъя.

П.Наранбаяр Боловсролын сайд байна, Ж.Чинбүрэн Эрүүл мэндийн сайд байна, Ж.Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, В.Рэнцэнханд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын бодлогын газрын дарга, Б.Батжаргал дарга Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга байна. Өөр хэн байна? Эндээс.

Ц.Ганцэцэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга.

Ингээд болж байна уу? Бусад хүмүүс маань хаана байна? Сангийн яамныхан. Байнгын хороо руу орсон уу? Сайд нар маань байгаа учраас гол нь сайд нарыг бас байлцуулж хэлэлцэх нь зүйтэй гээд өмнөх хуралдаанаар хойшлуулсан байгаа.

Тус нийтийн өргөдөлтэй холбогдуулан үргэлжлүүлэн асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Энэ нөгөө багш, эмч нарын цалинг нэмэх талаар ажлын хэсэг байгуулъя. 33 мянган иргэдийн өргөдөл D-Petition дээр хугацаанд цугларсан учраас бид Өргөдлийн байнгын хороо заавал авч хэлэлцэх ёстой байгаа.

Ж.Галбадрах гишүүнээр тасалъя. Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхтуяа: П.Наранбаяр сайдаасаа л асууя даа. Түрүүн үг хэлэх таарсан.

Багш, эмч нарын цалинг 3 сая 500 болгохыг хүн бүхэн дэмжиж байгаа байх.

Ер нь нийгмийн хамгийн чухал хоёр салбараа хаяад сүүлийн 30 жил бид уруудал, доройтол руу ороод унаад өнөөдөр ямар байдалтай байгаагаа хүн бүхэн хараад мэдэж байгаа.

Тэгэхээр багш, эмч нарын цалин, хөлсийг 3 сая 500 болгох, тэр иргэн Б.Номингийн саналыг би 100 хувь дэмжиж байна. Тэгээд энэ ажлын хэсэгт нь бас орж ажилламаар байна гэж бодож байна. Ер нь бол.

Тэгээд П.Наранбаяр сайд маань бас энэ дээр ямар тактик төлөвлөгөөтэй байна. Багш, эмч нарын цалинг 3 сая 500 болгох дээр манай салбарын сайд ямар бодолтой, ямар байр суурьтай байна вэ гэж бас асуумаар байна. Сонирхож байна.

О.Номинчимэг: П.Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Ц.Мөнхтуяа гишүүний асуултад хариулъя.

Багш, эмч нарын цалинг нэмэх бодитой шаардлага өнөөдөр нүүрлээд ирсэн байгааг бүгд харж байгаа. Багш нар маань жагсаж байна. Цалин нэмэх шаардлагаа тавьж байна.

Өнөөдөр багшаар ажиллахаар нийслэлд багшаар ажиллаж орж ирж байгаа хүний анхных нь үндсэн цалин 1 сая 484 мянган төгрөг байна. Энэ бол амьдралаа аваад явах хэмжээний мөнгө ерөөсөө биш. Энэ бол багшаар ажиллах хүмүүст урам өгдөг, боломж өгдөг ийм цалин ерөөсөө биш л дээ.

Тэгэхээр бид цалин нэмэгдүүлэх асуудлаар 8 дугаар сард хоёр яам оролцсон. Сангийн яам, мөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам оролцож, Боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэл оролцож ажлын хэсэг дээр бид тооцоолол хийж үзсэн. Ингээд үзэхэд 25 хувь нэмэхэд 560 тэрбум төгрөг нэмэлтээр шаардлагатай байна гэсэн дүгнэлт гарсан байгаа.

Цаашдаа бид Ерөнхий сайдад энэ асуудлаа танилцуулсан. Танилцуулаад 3 жилийн багшийн цалинг нэмэх төлөвлөгөө боловсруулж ирэх үүргийг аваад ажиллаж байна. Энэ 3 жилийнхээ хүрээнд бид ямар ч байсан 3.5 саяд хүргэх тооцооллыг хийх ажлын хэсгээ байгуулж, мэргэжилтнүүдээс зөвлөгөөг аваад явж байна. Үүнийгээ бид Засгийн газраар оруулж улмаар Улсын Их Хуралд

өргөн барьж цалин нэмэх энэ асуудлыг нэг мөр шийдвэрлэх нь зүйтэй гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Ер нь яах вэ танд мэдээлэл өгөхөд бид бас энэ урсгал төсвөө ноднин жилийнхээ төсвийн тодотголын, энэ жилийн төсвийн тодотголын дараа урсгал төсвөө бид тодорхой хэмжээнд 54 тэрбум төгрөгөөр тэндээсээ дээшлүүлсэн ийм нөхцөл байдалтай. 59.4 тэрбум төгрөгөөр урсгал төсвөө нэмэгдүүлсэн. Хөрөнгө оруулалтаа 595.0 тэрбум буюу бараг 2.3 дахин нэмсэн төсвийг өргөн барьж байгаа.

Хүлээн зөвшөөрнө өө. Ер нь сургуулиуд бариад, дотор нь ажиллах багш чинь байгаа юм уу гэдэг энэ шүүмжлэл бодитой.

Ийм учраас багшийн цалинг өсгөх бодлогыг бид барих ёстой. Багшийн цалин өсгөх нь төрийн үйлчилгээний албанд байгаа эмч нарын цалинтай ч гэсэн уялдаж явах ёстой гэсэн байр суурьтай байгаа. Яагаад гэвэл энэ салбарт хамгийн муу цалин, ийм цалингийн тогтолцоо, бүтэц нь өөрөө эхэлж байгаа цалин нь ийм доогуур. Ингээд үндсэн цалингийнхаа бүтэц нь өөрөө алдагдаад цаашаагаа нэмэлтүүдийг нь нэмээд яваад байхаар 1-ээс 1.5 дахин их хэмжээний нэмэгдэл цалин авах боломжтой. Гэвч энэ нь хөдөө сумд ажиллаж байгаа хүмүүс, түүний зэрэгцээ 5-аас дээш жил олон жил багшилсан багш нартаа илүү тусахаар байгаа.

Гэхдээ энэ хоорондын зөрүү нь ийм их гарчхаад байгаа нь бас манай энэ салбарын бүтцийн асуудал бас эргэж харж үзэхгүй бол болохгүй ийм хэмжээнд хүрснийг харуулаад байгаа юм.

Цаашдаа бид төрийн захиргааны алба болоод мөн төрийн тусгай төрийн улс төрийн албанд байгаа улсуудын бусад цалинтай энэ салбаруудаа харьцуулж харж төрийн албан хаагчдын цалингийн бодлогыг бүхэлд нь шинэчлэх ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа. Бид Сангийн яам болоод мөн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатайгаа хамтраад энэ асуудлыг оруулна. Баярлалаа.

О.Номинчимэг: Ц.Мөнхтуяа гишүүн тодруулъя.

Ц.Мөнхтуяа: П.Наранбаяр сайд маань 3 жилийн нэг хөтөлбөр төлөвлөгөө гэж яриад байгаа юм. 3 жилд сайд өөрөө байх уу, үгүй юу. Энэ Засгийн газар байх уу, үгүй юу. Тийм ээ. Энэ нь болохоор нэг тийм заль мэх, аргацаасан, энэ хүмүүсийн нэг галыг унтраах гэсэн ийм нэг хөөрхийлөлтэй арга хэрэглээд байгаа юм.

Тэгэхээр энэ багш нар чинь 3 жил байтугай 3 сарыг ч хүлээхээргүй ийм хэцүү байдалд байна. Одоо жишээлбэл 1.4 сая төгрөгийн цалин авч байгаа залуу багш гар дээрээ 900 мянган төгрөг авч байгаа шүү дээ. Татвараа өгөөд, шимтгэлээ өгөөд. Тэгээд тэр 900 мянган төгрөгөө түрээсийн байранд өгөнгүүт

түрээсийн байр нь хамгийн багадаа сая 500, сая 200 мянга гэж байгаа. Тэгээд дахиад түрээсийн байран дээрээ хүнээс мөнгө зээлээд байрандаа өгдөг. Цаана нь юугаа идэх юм, юугаа өмсөх юм. Өдөр тутмын хэрэглээ байхгүй. Үүнийг худлаа ярьж байна гэж байвал би залуу багш нарын гэрээр яваад хийдэг юм уу, л нөгөө юу... /минут дуусав/

О.Номинчимэг: Дараагийн тодруулга. Сүүлийн 1 минутад нэмж өгье.

Ц.Мөнхтуяа: Тэгээд бодит амьдрал ярингуут намайг худлаа ярьж байгаа юм шиг нийгэмд яриад байдаг. Тийм ээ. Яриулаад байдаг, бичүүлээд байдаг. Гэтэл бодит амьдрал дээр өнөөдөр 1.4 сая төгрөг авч байгаа багш чинь гар дээрээ 900 мянган төгрөг авч байгаа гэдгийг би бүр тодорхой нотлох баримттай хэд хэдэн залуу багштай цуг хамт контент хийе гэж бодож байна. Ер нь сүүлийн үед.

Маш их дайралт, гүтгэлэгт орж байна шүү дээ. Үнэн шударга юм хэлснийхээ төлөө.

Тэгэхээр би энэ залуу багш нартайгаа нийлээд байдал ямар байгааг харуулъя. Боловсролын салбарын ажил хийж байгаа багш нарын 60 хувь нь залуучууд байгаа. Залуучууд яг 900 мянган төгрөгөөр л амьдарч байна.

Тэгэхээр энэ бодит байдлаа ярья. 2 сая 900 мянган төгрөгийн дундаж цалинтай гээд нэг тийм хөөсөрсөн худлаа тоо яриад хүмүүсийн юу гэдэг юм цээж амраагаад суумааргүй байна. Хэдүүлээ яг бодит үнэнтэйгээ нүүр тулмаар байна л гэж хэлмээр байна.

О.Номинчимэг: Хариулах уу? П.Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээрээ бодитой байдлаа хэн хэн нь харж байгаа. Жагсаалын багш нартай би өөрөө гарч уулзаж шаардлагыг нь хүлээн авч, тэдний хэлсэн хугацаанд нь хариуг нь өгнө.

Ер нь манай улсад татварын дараа авч байгаа цалин бага шүү дээ. Түүний зэрэгцээ ерөнхий боловсролын сургуулийн багшийн нийт улс орон даяар авч байгаа цалинг нь дундажлаад үзсэн тоо чинь 2 сая 928 мянга 854 төгрөг болж байгаа. Энэ нь татварын өмнөхөн нь юм байгаа юм.

Тэгэхээр яг асуудал бол үндсэн цалин бага. Үнэхээрийн тийм залуу багш нар дээр өнөөдөр амьдралд нь огт хүрэлцэхгүй байгааг бүрэн хүлээн зөвшөөрч байгаа. Ийм учраас цалин нэмэхийн төлөө яг энэ салбар хариуцсан сайдын хувьд ажиллаж байгаа гэдгээ л хэлье.

Тэгээд цаашдаа энэ чинь Улсын Их Хурал дээр л шийдэгдэх асуудал шүү дээ.

О.Номинчимэг: Улсын Их Хурал дээр л шийдэх асуудал шүү дээ гээд бас яахгүй. Тийм. Засгийн газар энэ чинь бодлогоо гаргаад, уг нь “Хүний хөгжил” гэдэг мега төсөл бол энэ асуудлуудаа хэлэлцээд төсвөө уг нь оруулаад л ирэх ёстой шүү дээ.

Орж ирчхээд тэндээ зөвшилцөж чадаагүй юмаа Улсын Их Хурал шийдэх ёстой шүү дээ гээд хэлж байж бас болохгүй шүү дээ. Салбарын сайд байж. Засгийн газрын гишүүд, хамт ажиллаж байгаа хүмүүс ч энд бас байна шүү дээ.

Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууя.

Д.Ганмаа: Одоо хэцүү юм аа. Тийм ээ. Энэ эмч, эмнэлгийн ажилчид, тэгээд салбар, зөвлөлийн уулзалт гэж хэд хэд зохион байгуулсан. Хөдөө орон нутгуудаар баахан эмнэлгүүдээр явсан. Зун төвийн Өвөрхангай, Баянхонгор, Архангай гээд л баахан аймгуудаар явсан. Сумууд, багууд, тэгээд ийм суурьшлын бүс болсон 10 мянга гаруй бараг хүн амтай газар Цагаан хад гэх мэтчилэн газруудаар явсан. Тэнд ажил хийж ж байгаа хүмүүс, эмнэлгийн нөхцөл байдал, тэр ажилчид, зөвхөн эмч нар ч биш асуудлууд үнэхээр хүнд байгаад байна.

Одоо үүнийг ярихаар бид. Одоо жишээлбэл заримаас нь ярья л даа. Тэгэхгүй бол өөрөө өөртөө байлгахад их хүндрэлтэй.

Энэ багийн эмч нарын жишээлбэл цалин мөнгөний асуудал, амьдарч байгаа нөхцөл байдал, тэр ажлынхаа үр ашгаас гарч байгаа эрсдэл, одоо жишээлбэл вирусийн халдвар аваад өөрөө элэгний үрэвсэл, тэгээд хавдар болоод, тэгээд эрүүл мэндээрээ хохироод, эсвэл дандаа нойргүй, хоолгүй хол явж байгаад гэмтэх бэртэх, эсвэл энэ чинь нойргүй дандаа ээлжээр ажиллаад байхаар хавдрын эрсдэл маш өндөр болдог.

Эдгээр асуудлууд байнгын маш удаан хугацаанд үргэлжлээд явж байгаа.

Цалин байхгүй болохоор зэрэг нийгмийн асуудал нь бага. Дээрээс нь эмч, эмнэлгийн салбарынхан маань бие бие рүүгээ дайрсаар байгаад салбарын нэр хүнд аягүй их муудаад олон нийтэд тийм эвгүй. Юу гэдэг юм. Тийм юу гараад байгаа.

Эдгээр асуудлуудыг том зургаар нь хараад бид зөвхөн эмч нар ч биш бусад хөдөө орон нутагт байгаа бага эмч нар, сувилагч нар. Одоо нөгөө тусламж хүртэж байгаа хүмүүс байгаа шүү дээ. Техникийн ажилтнууд. Даже цахимын технологийн ажилтнууд IT-ийнхан нь хүртэл бусад газрын IT-д ажиллаж байгаагаасаа цалин нь хамаагүй бага.

Тэгэхээр олдоц муутай. Ажил хийлгэх боломжгүй. Ингэснээр эмнэлэг үйл ажиллагаа явуулах тун тааруу. Үүнийг маш олон хүн мэдэж байгаа. Олон ч гиш гишүүд үүнийг ярьж байна. Тийм ээ.

Ингэхээр салбарын хувьд Ж.Чинбүрэн сайд яг ямар бодлогоор энэ Эрүүл мэндийн даатгалын сангийн тэнцлийг сайжруулж цалингийн эх үүсвэр нэмэгдэж үр ашгийг дээшлүүлснээрээ цалин мөнгө төгрөгийн асуудлыг нэмэх боломж байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ ажиллаад байгаа ажилчид, эмч нарын цалин жишээлбэл хамгийн бага нь хэд, хамгийн өндөр нь хэд. Тэгээд дан дунджаар яваад байхаар их аюултай. Тэр чинь нөгөө өндөр цалин авч байгаа дээрээ татагдаад гайгүй юм шиг харагдаад байдаг учраас “медиан” гэж тооцоо байдаг шүү дээ. Тийм ээ. Медиан нь яг хэд байдаг юм бэ?

Тэгээд хувийн болон хувьсгалын эмч, эмнэлгийн ажилчид бас туслах ажилчдын цалин мөнгө нь яг хэд байдаг юм? Ийм хоёр асуудал дээр хариулж өгөөч.

О.Номинчимэг: Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн сайд хариулъя.

Ж.Чинбүрэн: Нэгд, эрүүл мэндийн цалин, санхүү бол шууд даатгалын гүйцэтгэлтэй холбоотой болсон. 2020 оны цогц хуулиудын нэмэлт, өөрчлөлттэй холбоотой гарсан.

Энэ дээр бид нэг гаргасан том алдаа бол гүйцэтгэсэн болгонд өгнө гэдэг ийм уралдаан зарласан нь өөрөө салбарын нөхцөл байдлыг хүнд болгосон. Нэг ёсондоо нэхэмжлэл болгоныг хянах, чанар, гүйцэтгэлд нь суурилсан санхүүжилтийн тогтолцоо хийж чадаагүй.

Ковид цар тахлын үеийг Та бүхэн санаж байгаа байх. Эмч, эмнэлгийн ажилчид долоо хоног, 14 хоногоор хориотой бүсэд ажиллаад 7-гоос 10 сая хүртэл төгрөг авч болж байсан. Мундаг тэлсэн. Эрүүл мэндийн салбар, ялангуяа Монголоос өөр газар очиж эмчлүүлж чадахгүй болохоор эрүүл мэндийн салбарын чухлыг ойлгож, ямар их хөрөнгө оруулалт, санхүүжилт хийж байсныг бид бүхэн санаж байгаа.

Тэр том тэлэлтийнхээ дараа буцаад хумьж чадахгүй байгаа. Нэг ёсондоо буцаад илүү үр өгөөжтэй, таны хэлдэг нөгөө COST-EFFECTIVE байдал руугаа орж чадахгүй зүгээр л тэлсэн байдлаасаа гарч чадахгүй байсаар байгаад одоо бол бүр нөгөө тэлэлтээсээ бууж чадахгүй ийм хөөстэй.

Энэ байдлаас гарахын тулд одоо яах вэ гэхээр нэгд даатгалын тогтолцоо өөрөө институцлэгдэх ёстой. Корпорэйтив байдлаар болох ёстой, биеэ даах ёстой. Эрүүл мэндийн яамны харьяанд байх ёсгүй. Даатгал биеэ даасан жинхэнэ эрсдэлийг даадаг ийм тогтолцоо болох ёстой.

Энэ ч чиглэлээр Улсын Их Хуралд олон ажлын хэсэг байгуулагдаад, Эрүүл мэндийн даатгалын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хүртэл хуулийн төсөл Та бүхэн өргөн барьсан байгаа.

Тэгэхээр энэ ажлаа хурдлуулъя. Даатгалыг жинхэнэ иргэдийн эрсдэлийг даадаг байхаас биш зүгээр эрүүл мэндийн салбаруудын санхүүжилтийг гүйцээдэг байгууллага байж болохгүй.

Үүний нэг жишээ энэ шууд удирдлага доор байсан жишээ бол энэ ковид цар тахалтай тэр үеийн гарсан өр, авлага, түүнтэй холбоотой энэ тэнцэл алдагдаад одоо хүртэл тэр нь буцааж хийгдээгүй л явж байгаа. Тэгж ярих юм бүр тэр гарсан мөнгөө хүүг нь тооцоод хүртэл даатгал буцаагаад л өгөх ёстой шүү дээ. Тэгээд энэ ажлууд хийгдэхгүй байна. Энэ болгоноос эхэлж тогтолцоог эрүүл болгох ажил хамгийн эхний ажил гэж үзэж байгаа.

Тийм учраас 2026 оны төсвийг өргөн барихдаа Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог илүү сайжруулах, бэхжүүлэх 9 зорилго бүхий 30 ажлын төлөвлөгөө өргөн барьсан байгаа.

Би бас Та бүгдийг үзээсэй гэж бодож байна. Энэ бол 3 жилийн хугацаанд бид энэ даатгалыг өөрийн жинхэнэ биеийг нь даалгасан, ямар нэгэн улс төрөөс хамаарал бус жинхэнэ эрсдэлийг даадаг ийм тогтолцоо болох энэ систем рүү орно.

Энэ хөтөлбөр дотор бас нэг хийгдэх гэж байгаа чухал зүйл бол ерөөсөө л энэ төсвийн урсгал зардал дээрээ даатгуулагчдын төлж байгаа даатгалаа эрсдэлээ хамгаалуулах гэж өгч байгаа мөнгийг тэнд ордоггүй байхыг л бид оруулах ёстой.

Хоёрт, даатгалд нэг том дутагдаж байгаа зүйл бол бид төрөөс шимтгэлийг нь дааж байгаа иргэдийнхээ, тэд нарын авч байгаа тусламж, үйлчилгээг ингээд графикаар харьцуулаад судалгаагаа онуудаар харуулахад бараг 400-аас 500 тэрбум төгрөгийн зөрүүтэй. Нэг ёсондоо шимтгэлийг нь төр дааж байгаа. Нөгөө бага насны хүүхдүүд, хүүхдүүд, тэтгэврийн насныхан, группт байгаа иргэд, жирэмсэн ээжүүд, цэрэгт алба хааж байгаа, шоронд ял эдэлж байгаа гээд. Тийм ээ. Тэдгээр улсуудын эрүүл мэндийн тусламж авч байгаа энэ хоёрын зөрүү 500 тэрбум шүү дээ. Зөвхөн зөрүү нь.

Улсын төсвөөс тусламжийг нь дааж байгаа зөрүү жил болгон л 90-ээс 180 тэрбум руу тэлчихсэн. Нэг ёсондоо нөгөө даатгал өөрөө алдагдалтай ажиллаад байдаг. Даатгуулагчийн өгч байгаа санхүүжилт нь даатгуулагчийн эрсдэлийг даах биш харин эсрэгээр бүр алдагдалд ордог ийм тогтолцоо.

Тийм учраас эхний алхам ерөөсөө л энэ даатгалын тогтолцоогоо л сайжруулъя л гэдэг асуудал.

Хоёр дахь асуултад хариулахад 4-хөн секунд үлдлээ. Яах вэ.

О.Номинчимэг: Гүйцээж хариулъя. 1 минут. Ж.Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн ажилтны цалин, хөлсний талаарх мэдээлэл дэлгэрэнгүй байж байна. Одоо би үүнийг танд өгье гэж бодож байна.

Энэ дээр бид хамгийн чухал манай эрүүл мэндийн салбарт ажлын ачааллаас болоод ажлаас халшрах хам шинжийн хүрээнд сувилагчийн дутагдалд орох гээд байна.

Би зүгээр сувилагч нарын цалинг яг хэлээд өгье. Ерөнхий мэргэжлийн сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлдэг сувилагч буюу ТҮ-3 ангиллаар ажиллаж байгаа Засгийн газрын 2024 оны 238 тушаалаар 1 сая 347 мянган төгрөг. Үндсэн цалин нь 1 сая 347-г авч байна.

Нийгмийн ажилтан, биологич ТҮ-6 нь 1276, жолооч, цахилгаанчин, слесарь ТҮ-3 1 сая 52 мянган төгрөг, асрагч буюу ТҮ-2 бол 1 сая 3 мянган төгрөг авч байх жишээтэй.

О.Номинчимэг: Гүйцээж. Түрүүн асуусан хувь, хувьсгалын ажилчдын цалингийн зөрүү байгаа юм уу? Хувийн эмнэлгийн эрүүл мэндийн салбарынхан: улсынх. Тэр дээр гүйцээж хариулаач гэж байна.

Ж.Чинбүрэн сайдын микрофоныг өгье.

Ж.Чинбүрэн: Байгаа байгаа. Байлгүй яах вэ.

Ер нь эрүүл мэндийн ачааллыг жигд үүрч чадаж байгаа тэр ачааллыг хуваалцаж байгаа эмч, эмнэлгийн ажилчдын цалин жигд байна уу гэхээр үгүй шүү дээ. Тийм ээ. Ялангуяа эрчимт эмчилгээ, яаралтай тусламж, энд ажиллаж байгаа, улсын эмнэлэгт ажиллаж байгаа 24, 24 бараг тулаан хийж байгаа энэ ажилчдын цалин хангалттай. Яг нөгөө Хөдөлмөрийн хуулиараа цалин нэмэгдээд өгөгдөж байна уу гэхээр үгүй. Зарим тохиолдолд биеэр нь амрах байдлаар хүртэл өгч цалин санхүүжилт ямар хүнд байгааг бид бүхэн мэдэж байгаа.

Тийм учраас зарим хувийн хэвслүүд нь зөвхөн өрмийг нь аваад ачаалал хамт үүрэлцэхгүй байгаа тогтолцоо хүртэл байж байна.

Мэдээж хувийн эмнэлгийнх нь хамгийн нэр хүндтэй сайн эмч нарыг авч ажиллуулж зах зээлээ татах зах зээлийн хуулиараа сайн эмч нарыг ажиллуулж, тэдгээр нь өндөр цалин авч байгаа. Энэ зөрүү байлгүй яах вэ. 3, 4 дахин зөрүү байгаа гэдгийг хэлж байна.

О.Номинчимэг: Жанчивын Галбадрах гишүүн асууя.

Ж.Галбадрах: Өнөөдөр бид багш, эмч нарын цалин ярьж байна. Тэгээд энэ цалин маань ярьж байгаа гол үндэслэл нь багш, эмч нарын маань хомсдол бодитоор нүүрлээд байгаа.

Тэгэхээр одоо бид эмчгүй болох, багшгүй болох гэсэн ийм зүйл бид нарт тулгараад байгаа учраас бид өнөөдөр багшийнхаа цалинг зайлшгүй нэмэх шаардлагатай гэдэг үүднээс бид үүнийг ярьж байгаа.

Тэгээд эцсийн зорилго бол багш нараа цалинг нь нэмлээ. Тэгвэл тэгээд тэр чанартай багш нар маань ажилдаа хариуцлагатай хандаад сургалтын чанар дээшлэх гэсэн л ийм логигоор бид ярьж байгаа юм.

Тэгээд асуулт байна. Багш нар, багш, эмч нарын цалин хамгийн бага байгаа. Ялангуяа залуу багш, эмчийн цалин сая 500 хүрэхгүй байна гэж байна. Нийт багш, эмч нарын хэдэн хувь нь ийм цалин авч байгаа вэ? Сангийн яамаас асуухад. Энэ тооцооллыг хийж үзсэн үү? Ажлаас гарч буй хүмүүсийн дунд энэ залуу багш нар, залуу эмч нарын эзлэх хувь нь хэдэн хувь байна гэдгийг асууя.

Боловсролын яамнаас түрүүн багшийн цалинг 20-оос 25 хувь нэмэхэд 520 гаруй тэрбум төгрөгийн ачаалал ирнэ гэлээ. Тэгвэл үндсэн цалинг хэд болговол 3.5. Одоо энэ чинь 3.5 сая гэдэг тоог бид бас анхаарч үзэх ёстой. Яагаад гэвэл багш нарын үйлдвэрчний эвлэлээс бид нарт ийм шаардлага ирчхээд байгаа. Тэгвэл төсөвт тэгээд үүнийг бүрдүүлэхийн тулд үнэхээр бид мэдэж л байгаа. Одоо ингээд хий попорч ярих биш. Угаасаа орлого дутаад байгаа. Тэгвэл энэ төсөвт орлогыг яаж төвлөрүүлэх боломж ер нь байгаа юу? Би Сангийн яамнаас л асууя гэж бодож байна л даа.

Тэгээд бид одоо энэ үйлдвэрчний эвлэл энэ тэрдээ тэр иргэн Б.Номинд бид ямар хариу өгөх ёстой вэ? Ийм зүйлийг асууя.

Дараа нь багшийн ажлын байрны ачаалал Боловсролын яамнаас асуухад.

Ер нь ачааллын талын судалгаа хийсэн үү? Энэ нь цалинд ямар нөлөө үзүүлэлт юм бэ? Гүйцэтгэлийн үнэлгээг бид бас их шүүмжилж ярьж байгаа. Гүйцэтгэлийн үнэлгээг бүр хасъя гэж ярьдаг ч юм байна. Зарим нь байлгая гэж байна.

Тэгэхээр энэ гүйцэтгэлийн үнэлгээ маань багш нарын ажлаас гарах, багш нарын цалин мөнгөтэй ер нь хэр уялдаж байгаа вэ? Энэ талын судалгаа байвал тоонууд хэлж өгөөч ээ гэж хүсэж байна.

Тэгээд ер нь бид эцсийн дүнд энэ багш нарыгаа л хөгжүүлж байж, багш нарыгаа бас ажилдаа цалингаас гадна ямар хүчин зүйлүүд тэр багшийг хөгжих

боломж нь. Би түрүүн хэллээ. Багшийн ажлын байрны ачаалал гэж хэлсэнчлэн багш нарын тэр карьер, тэр багш нарын нийгмийн баталгааны тал дээр одоо энэ төсөвт ямар зүйлүүд тусгагдсан бэ гэдгийг хэлж өгөөч ээ гэж хүсэж байна. Баярлалаа.

О.Номинчимэг: Сангийн яам болон Боловсролын яамнаас асуулаа.

Боловсролын яам П.Наранбаяр сайд эхлээд хариулж байх уу? Ж.Галбадрах гишүүний асуусан асуултуудад. Сангийн яам хажуу тийшээ төсвийн хэлэлцүүлэгт Төрийн байгуулалтад орсон байна. Одоо хүрээд ирнэ.

П.Наранбаяр сайдын микрофоныг өгье. Асуусан асуултад.

П.Наранбаяр: Баярлалаа.

Тэгэхээр өнөөдөр манай яг энэ багшлахуй дээр байгаа багшилж байгаа хүмүүсийнхээ насны бүтцийг нь аваад үзэх юм бол 41 хувь нь 35-аас доош насныхан байгаа юм. 5 жил багшилсан багш нарын ер нь бараг 60 орчим хувь нь байсан. Ажлаасаа гаръя, арна гэсэн. Гараад явж байгаа ийм тохиолдлууд байгаа юм.

Ачааллын хувьд нийслэл дээр түлхүү байдаг. Тэгээд ер нь бүлэгт Монгол Улсад нийтдээ 24 мянга 189 бүлэг байгаа.

- ▶ 30 хүртэлх бүлэг нь 10 мянга 522,
- ▶ 30-аас 40 хүртэлх бүлэг 9653,
- ▶ 40-өөс дээш хүүхэд дүүргэлттэй бүлэг 4014 байж байгаа.

Тэгэхээр энэ дээр маш их ачаалал үүсдэг.

Тэгэхээр бид ажлын ачаалалд нь тохируулсан цалингийн бодолтыг хийх ёстой гээд бидний гол зорилго энэ дээр байсан. Үндсэн цалин дээр нь шингээж үүнийг нь оруулах ёстой, тооцох ёстой гэсэн ийм бодлого барьж цалингийнхаа нэмэгдлийн тооцоог хийсэн.

Тэгээд түрүүн асуултад хариулахдаа би хэлсэн. Бид ер нь 25 хувиар нэмэх юм бол 560.0 тэрбум төгрөг нэмэлтээр хэрэгтэй байна. Яг одоо 3.5 сая төгрөг бол 3.3 их наяд төгрөг хэрэгтэй байна. Тэгээд үүнийг яг жилийн дотор хийж чадах уу, үгүй юу гэдэг бол өөрөө бас их тийм асуултын тэмдэгтэй зүйл болоод байгаа юм.

Эндээс бид ямар гаргалгааг яаж энэ төсөв дээр орон зайг бий болгох вэ гэдэг бол энэ Сангийн яамны зүгээс, бусад Эдийн засаг, хөгжлийн яам, түүний зэрэгцээ бас энэ эдийн засгийнхаа бодлогыг барьдаг энэ мэргэжлийн байгууллагууд нь хариулах байх.

Зүгээр миний харж байхад тэр төсвийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх зарлагын хэмжээг 24 хувиар улсын яг энэ төлөвлөгөөндөө хязгаарласан явдал бас энэ дээр цалин нэмэхэд нэлээн хүндрэл учруулж байгаа юм байна гэж харж байгаа.

Хоёрдугаарт нь, нийгмийн даатгал болоод тэтгэврийн сангуудын энэ бичилтийг урсгал зардал дээр бичээд яваад байгаа нь бас энэ цалин нэмэхэд тодорхой хэмжээгээр боогдуулах гэдэг юм уу, энэ боломжийг бас хаагаад байна гэж харж байгаа.

Түүний зэрэгцээ мэдээж үр дүнгүй гэж үзэж байгаа иймэрхүү төсөл, хөтөлбөрүүдийг зогсоож эндээсээ цалин нэмэх бодлого бас байж болно. Иймэрхүү зүйлүүдээр нэмэх боломж байх юм болов уу гэж харж байна.

Ер нь цаашдаа багшийн ажлыг хамгийн чадварлаг, хамгийн сэтгэлтэй хүмүүс нь аваад явдаг ийм салбар. Энэ дээр бид залуу хүмүүсийг, ялангуяа багшаар ажиллах хүсэл тэмүүлэлтэй хүмүүсийг эхнээс нь л дэмжиж ажиллахад цалингийн зөв бодлого л хэрэгтэй гэсэн энэ байр суурь дээр байгаа.

Юуны хувьд бид энэ 3 жилийн төлөвлөгөөгөө гаргаж, энэ дээрээ бас ярилцаж явж эдийн засгийнхаа энэ өсөлт, орлогын тал дээр харж байж энэ цалингийн нэмэгдлүүдийг илүү оруулах ёс гэсэн ийм байр суурьтай байгаа.

Ер нь хүний хөгжлийг дэмжих, боловсрол дээрээ хөрөнгө оруулсан нь улс орны ирээдүйн хөгжлийг авч явахад хамгийн оновчтой хөрөнгө оруулалт болдог гэдэгтэй 100 хувь санал нийлж байгаа. Ийм учраас Засгийн газраас энэ 3 жилийн төлөвлөгөөг нь хэлэлцүүлээд танилцуулах болно гэдгийг хэлье. Баярлалаа.

О.Номинчимэг: Сангийн яамны Зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ орж ирсэн байна. Энэ асуулт дээр нэмэлтээр хариулах уу? 6 дугаар микрофоныг нь асааж өгье.

Сая асуултыг хэлсэн. Тийм ээ.

П.Бат-Эрдэнэ: Сангийн яамны зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ. Гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр Сангийн яаман дээр байдаг цалин, хөлсний нэгдсэн системээс гардаг мэдээллээр багш нарын цалинг бид бас судалгаа хийж үзсэн. Энэ дээр орон нутаг болон нийслэл, орон нутгийн нэмэгдлээрээ ялгаатай байгаа. Багш нарын хувьд.

Бусад зүйлүүд нийслэл болон орон нутгийн хувьд ялгаа байхгүй.

Бидэнд байгаа мэдээллээр нийслэлд 0-ээс 5 жил ажиллаж байгаа багш нар хамгийн бага цалинтай хэсэг нь болж байгаа. 7600 багш байгаа. Нийт 52.7 мянган багшаас нийслэлд 0-ээс 5 жил ажиллаж байгаа 7600 багш хамгийн бага цалин, хөлстэй байна. Эдгээр багш нарын нийт авбал зохих цалин, хөлс нь 2.1 сая. Тэгээд үүнээсээ нийгмийн даатгалын шимтгэл болон татвараа суутгуулсан дүнгээр... /минут дуусав/

О.Номинчимэг: Минутыг нь сунгая. 6 номер.

П.Бат-Эрдэнэ: Нийслэлд нийслэлд 0-ээс 5 жил ажиллаж байгаа буюу залуу багш нар хамгийн бага цалин, хөлс авч байгаа. Энэ дээр орон нутгийн нэмэгдэл болон ажилласан жилийн нэмэгдэл байдаггүй учраас бага цалин авч байгаа.

Гэхдээ ачааллын хувьд харах юм бол нийслэлд хүүхдийн тоо илүү олон байдаг учраас ачаалал орон нутгаас харилцан адилгүй байгаа. Үүнийг шийдвэрлэх зорилгоор Их Хуралд Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд ерөнхий боловсролын хувьсах зардлыг 100 тэрбумаар нэмэгдүүлсэн. Энэ зардлаар ачаалал ихтэй байрлалд байгаа багш нарын асуудлыг шийдэх чиглэлээр манай Боловсролын яам хувилбараа боловсруулаад ажиллаж байгаа. Тэгээд төсөв батлагдсаны дараагаар үүнийг хэрэгжүүлээд явна. Баярлалаа.

О.Номинчимэг: Ж.Галбадрах гишүүн тодруулъя.

Ж.Галбадрах: Тийм. Энэ хариултууд бид нарын яг мэдэж байгаа юмыг л хэлээд байна л даа. Хүн болгоны ярьдаг, чуулган дээр ч ярьдаг, энд ч ярьдаг.

Бид Сангийн яамнаас ингэж асуугаад байгаа юм. Одоо шаардлага тавиад хүмүүс 3.5 сая болгоё гээд ороод ирлээ. Тэгээд түрүүн П.Наранбаяр сайд хэлсэн дээ. Шууд үндсэн цалинг нь 3.5 болгох гээд байгаа юм биш.

Ер нь нэмэгдэлтэйгээ ороод ирэхэд цалин нь хэд байвал 3.5-д хүрэх юм бэ гэхээр 2 сая хүрсэн байхад нөгөө нэмэгдлүүдээ нэмсэн цалин нь 3.5-д хүрэх юм гэсэн нэг тооцоолол гарч ирээд 2 сая нь түрүүний нөгөө 560.0 тэрбум гэдэг дээр бас ачаалал нэмэгдэхээр.

Тэгэхээр энэ 560.0 тэрбум төгрөг олох шаардлагатай байна гэдэг тооцоо гарч байгаа бол тэрийг олох орлогын эх үүсвэрийг Сангийн яам энд цаашаагаа асуудал хүндрээд явна. Бид Өргөдлийн байнгын хороон дээр хэлэлцэж байна. Ямар хариулт өгөх юм? Ямар бид нарт боломж байх вэ гэдгийг л асуусан юм байгаа юм.

Тэгээд бид нарын хувьд нэг ийм зүйлийг л бас мэдэх хэрэгтэй байгаа юм. Тэгээд... /минут дуусав/

О.Номинчимэг: Ахиад 1 минут.

Ж.Галбадрах: Ер нь нэг товчхон санаа хэлэхэд Та бүхэн яам ч тэр, Сангийн яам ч тэр хэлж байгаа нь залуу багш нар хамгийн хүнд. 1-ээс 5 жил. Энэ чинь ирээдүй байхгүй юу. Багш нарын маань.

Залуу багш нар хүнд гээд сая П.Наранбаяр сайд 60 хувь нь ажлаасаа гардаг. 5 жилийн дотор. Энэ бол хурд нь 15 хувь жилд хүрсэн байна лээ. Урьд нь 5, 6 хувь байсан. Ажлаас гарах хурд ингээд нэмэгдсэн.

Тэгвэл үүнийг яаж барьж тогтоох юм бэ? Бид ингээд багш болоод орсон хүнийг. Гардаг юм гээд гаргаад явуулах юм уу гэвэл. Одоо энэ дээр нутгийн хишиг гэдэг шиг багшийн хишиг ч юм уу. Эхний 5 жил нь хүнд гээд байгаа бол бүгдийг нь цалинг нь нэмж чаддаггүй юм бол энэ дээр багшийн хишиг гээд 5 жил байгаа залуу багш, эмчид зориулсан ийм арга хэмжээ тэтгэлэг маягаар өгч бас болохгүй юу гэдэг асуудлуудыг бид бас хөндөж ярьж гарц гаргалгаа хайх ёстой юм байна л гэсэн санааг Та бүхэнд ээ бас хэлж байгаа юм.

Тэгээд одоо энэ үйлдвэрчний эвлэлээс өгч байгаа шаардлага, энэ бүгдэд бид ингээд хамтдаа бас энэ хариултыг өгөхөд Та бүхнээсээ... /минут дуусав/

О.Номинчимэг: Үг хэллээ. Равжихын Эрдэнэбүрэн гишүүн асуулт асууя.

Р.Эрдэнэбүрэн: Багшийн цалин хангалттай байгаа, эмчийн цалин хангалттай байгаа гэж хэлж байгаа нэг ч хүн байхгүй. Бүгдээрээ л нэмэгдүүлэх юм сан л гэж бодож байгаа.

Би одоо Сангийн яамнаас асууя. Сая Боловсролын сайдын хэлж байгаагаар 25 хувь нэмэхэд 560.0 тэрбум төгрөг хэрэгтэй гэж байна. Ийм эх үүсвэр байгаа юм уу? Ажлын хэсэг байгуулагдаад шийдвэр гаргахаар олдох юм уу? Ийм мөнгө байсан бол засаг дээрээ шийдэх боломжтой байгаагүй юу? Хэрэв эх үүсвэр байхгүй бол хаанаас яаж олох гэж байгаа юм бэ? Сангийн яам.

Эх үүсвэргүй бол одоо бид энэ ажлын хэсэг гараад тэгээд Засгийн газар одоо чинь ч хэлж байх шиг байна. Их Хурал шийдэх гэж байгаа гэж ярих юм байна.

Тэгээд энэ 560.0 тэрбум хамгийн багаар бодоход хаана байна гэдгийг л асуумаар байна. Байгаа юм уу? Олдох юм уу?

О.Номинчимэг: Сангийн яам 6 номер хариулъя.

П.Бат-Эрдэнэ: Сангийн яамны Зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ. Гишүүний асуултад хариулъя.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2026 оны төсвийн төсөлд урсгал зарлагын хэмжээ 24.5 их наяд төгрөг байгаа. Энэ нь 2025 оны тодотгосон төсвөөс 600.0 тэрбумаар нэмэгдсэн ийм дүнтэй.

Энэ тоо маань дотоодын нийт бүтээгдэхүүний 24 хувиар хязгаарлагдаж байгаа. Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх урсгал зарлагын хэмжээг 24 хувиар барих. Мөн нийт зарлагын хэмжээг бас тодорхой хэмжээнд хязгаарлах замаар эдийн засаг дахь төрийн оролцоогоо бууруулах энэ зүйлийг даалгасан. Энэ хүрээнд Засгийн газар Их Хурлаас баталсан бодлогын баримт бичигт нийцтэйгээр бүх төсвийг өргөн мэдүүлсэн.

Тэгэхээр 24.5 дээр одоо ямар нэгэн байдлаар урсгал зарлага нэмэх боломжгүй байгаа. Яг 24 хувьдаа тулсан.

Тийм учраас гишүүний асуултад Засгийн газар яг ингээд багтаах ёстой зардлуудаа багтаахын тулд төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд зардлуудыг бууруулах замаар нэлээн таналтыг хийгээд 24 хувьдаа багтааж орж ирсэн.

Тийм учраас нэмэлт эх үүсвэр одоогийн хувьд маш хүнд гэдгийг хэлэх байна.

О.Номинчимэг: Тодруулах юм уу? Р.Эрдэнэбүрэн гишүүн тодруулъя.

Р.Эрдэнэбүрэн: Тэгээд мөнгө байхгүй. Ажлын хэсэг байгуулагдаад л баахан ярих юм шиг байна шүү дээ.

Эсвэл тэр 24 хувь дотроо 20 хэдэн их наяд байгаа билээ. Урсгал зардал чинь. 26.5 дотроо зохицуулалт хийж болох юм уу? Хэнээс нь хасах юм? Яах вэ Засгийн газар би үхэхээр чи үх л гэж л хэлж байна шүү дээ.

Хэчнээн ажлын хэсэг гаргаад шийдвэр гаргаж чадахгүй. Мөнгө байхгүй юм чинь одоо тэгээд ямар ч шийдвэр гаргах вэ? Мөнгө байхгүй байна л гэж хэлнэ биз дээ. Ингэж цаг үрж байх тийм... /минут дуусав/

О.Номинчимэг: Тийм. Манай Байнгын хороо D-Petition дээр үүссэн иргэдийн саналыг хуулийнхаа дагуу заавал авч хэлэлцэх ёстой эрхлэх Байнгын хороо болоод байгаа юм. Ийм ажлын хэсэг байгуулаадхаач ээ гэдэг санал ирсэн. Бид үүнийг хэлэлцэнэ. Байнгын хороогоороо санал гаргана.

Тэгэхээр үнэхээр Байнгын хороо бид бодлогын орон зай байгаа юм уу, ямар үр дүн гарах юм гэдгийг л өнөөдөр одоо ингээд хэлэлцэж байгаа гэсэн үг. Байгуулбал.

Тэгээд энэ дээр бас нэг юман дээр Р.Эрдэнэбүрэн гишүүнтэй санал нэг байгаа нь манай салбарын хоёр сайд маань орж ирээд харин тийм ээ, бид

цалин нэмэх хэрэгтэй байна гээд. Улсын Их Хурал шийднэ дээ гээд ийшээ ингээд явж байгаа нь бас болохгүй.

Засгийн газар энэ хүрээ хязгаартай бүх юмаа уг нь боогоод л орж ирсэн байх. Хэрвээ үнэхээр Та бүхэн маань энэ аягүй маш тулгамдсан асуудал. Бид заавал дахиж ингээд ярих ёстой гэвэл төсвөө татаж аваад Засгийн газар дотроо дотроо дахиад тэрийгээ яриад энд асуудлуудаа судлаад. Ёстой тэр танах ёстой юмнаасаа танаад багш, эмч нарын цалин дээрээ тавиад орж ирэх ёстой шүү дээ.

Тэгэхгүй ингээд Сангийн яам нь энд нь боломжгүй гээд. Хоёр сайд нь, Боловсролын сайд нь дахиад ийм мөнгө хэрэгтэй байна. Та нар шийдээд өгөөч гээд байгаа нь бас боломгүй л харагдаад байгаа юм.

Тэгээд хоорондоо ойлгоцоогүй юмаа Улсын Их Хурал руу шидээд та нар нэг шийдээдхээч гэж байгаа юм.

Тэгээд процессын хувьд манай Байнгын хороо хуралдаад санал, дүгнэлтээ Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд өгөх ёстой. Тэгээд тэрний дараа Төсвийн байнгын хороо бас хэлэлцэхээр. Гурван Байнгын хороонд энэ асуудлыг Улсын Их Хурлын даргаас чуулганаар хуралдаан дээр хуваарилсан байгаа юм.

Тэгэхээр энэ асуудлуудыг бас сайн боломж бололцоо юу байна, ямар арга замаар бид үүнийг хийх вэ гэдгийг манай гишүүд ч гэсэн бас яг одоо энэ асуулт хариулт, хэлэлцүүлгийн үеэр санал бодлоо хэлнэ байх гэж бодож байна.

Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асууя.

Б.Пунсалмаа: Баярлалаа. D-Parliament дээр иргэн Б.Номингийн оруулсан эмч, багш нарын цалинг өсгөх энэ санал санаачилгыг дэмжиж байгаа.

Ер нь л монгол хүмүүс дунджаараа 3.5 сая төгрөгийн дундаж цалинтай болмоор байгаа юм. Ингэх юм бол бид ерөөсөө халамжаасаа ангижраад хөдөлмөр гэдэг энэ зүйлээ бүтээхэд хамгийн түлхэц болох шийдвэр байгаа юм.

Тэгэхээр Сангийн яамнаас нэг зүйл асуумаар байна. Бид түрүү жил Төсвийн тогтвортой байдлын тухай хууль батлахад урсгал зардлын хэмжээ 30 хувь гэж ер нь баталсан юм.

Тэгэхээр одоо бид энэ урсгал зардлынхаа хүрээнд нэмж болох бидэнд боломжит төсөв тэдэн хувь байна? Үүнийгээ нэг гаргаад ирмээр байгаа юм.

Тэгээд сая гишүүд хэлээд байна шүү дээ. Бид ерөөсөө дандаа байшин барилга, бүтээн байгуулалт, зардал гэдэг юмыг зардал дээр тавьж байхаар эргүүлээд орлого олдог үйлдвэр, энэ уул уурхайн бус үйлдвэрлэлүүд дээрээ

илүү анхаармаар байна. Ингэж байж хүмүүс тэнд чинь ажлын байр бий болно. Дундаж цалин өснө. Эдийн засаг чинь томорч байж бид цалингаа өсгөнө шүү дээ.

Тэгэхээр энэ тал дээр манай энэ төсөв энэ жил бас л ер нь их учир дутагдалтай ажиллалаа гэж харж байгаа байхгүй юу.

Тэгэхээр одоо бидэнд байгаа урсгал зардал дээр ер нь ямар боломж байна. Тавигдсан төсвүүдийг үйлдвэр лүү шилжүүлэх, аж үйлдвэржилтийн парк, Эмээлт аж үйлдвэржилтийн парк гээд бид нарт боломжууд байгаа байхгүй юу. Эд нуруудыгаа яаралтай оруулах бодлогоо Та бүхэн минь бидэнд нэг гаргалгаа гаргаад хэлмээр байна.

О.Номинчимэг: Сангийн яам. 6 номер.

Тэр зардлаа 30 хувь болгох юм бол хэдэн тэрбум төгрөгийн орон зай байгаа вэ гэдэг тоон мэдээллийг. П.Наранбаяр сайд сая тайлбар хийхээр байсан уу? Эхлээд тайлбараа хийе П.Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Тэгэхээр асуудалд ажил хэрэгчээрээ хандаж байгаа Та бүхэнд талархал илэрхийлье.

Засгийн газраас хувьсах зардалд шингээх замаар 100 тэрбум төгрөгийн нэмэгдлийг оруулж энэ төсөв дээр багш нарын цалин, хөлсийг нэмэгдүүлэхэд бас оруулж ирсэн юм.

Бидний тооцоогоор 25 хувь нэмэхэд 560.0 хэрэгтэй. Үлдсэн эх үүсвэрийг яах вэ гэдэг асуудал дээр. Түрүүн С.Эрдэнэбат гишүүн хэлээд байна. Бас гишүүд яриад байна. Тэр 24 хувьтай бас холбогдоод байгаа юм.

Тэр 24 хувь нь өнөөдөр тэр дээд зах дээрээ хүрчхээд. Гэтэл хуулиараа 30 хувь гэсэн байгаа. Тэгэхээрээ бид энэ дээр хэрвээ дотоодын нийт бүтээгдэхүүний төсвийн урсгал зардал, зарлагыг л хэлээд байгаа.

Тэгэхээр энэ дээр хэрвээ бид тодорхой хэмжээнд 24 хувийг өсгөж чадах юм бол ер нь цалин, хөлс нэмэх бүрэн боломжтой ийм орон зай гарч ирэх нь л гэж харж байгаа юм. Нэгэнт одоо жилийн төлөвлөгөөгөө батлахдаа 24 гээд баталсан ийм нөхцөл байдал үүсээд байгаад асуудал байгаа. Сангийн яам ч гэсэн үүнийг тайлбарлаад яриад байгаа. Ийм нөхцөл байдалд байгаа.

Тэгэхээр энэ дээр хэрвээ бид ярилцаад асуудлыг урагшлуулах тал дээр нь ярилцаж Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хороо зэргээс хэлэлцээд үүнийгээ оруулж ирж чадах юм бол энэ төсөв маань урсгал зардал тал дээрээ нэмэх боломж гарах нь л гэж харж байгаа.

Маш их сайн шахаж бүх зүйлүүдээ оруулж ирсэн ийм төсөв гэж харж байгаа. Төрийн албыг маш олон талаас нь танаж хасаж, 9 хувиар зардлыг нь бууруулж оруулсан төсөв. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл ч гэсэн энэ удаагийн төсөв дээр бас эерэг дүгнэлт өгөөд байгаа ийм нөхцөл байдалтай байгаа.

Тийм учраас боломж тэнд байгаа юм болов уу гэсэн утгаар нь миний зүгээс хэлж байгаа шүү. Тэгэхдээ энэ бол ярилцаж байж шийдэх асуудал гэдгийг дахин дахин хэлье. Баярлалаа.

О.Номинчимэг: 6 номер. Сангийн яам. Тэгээд тэр 5 их наяд 30 хувь руу болохоор чинь урсгал зардал чинь ихэснэ.

Тэгэхээр алдагдлаа 1 их наяддаа байхын тулд нэмэх шаардлага гарах уу? Тэгээд төсвийн орлогоо өөдрөгөөр төсөвлөх хэрэгтэй юм уу гээд бүхэлд нь. Тийм. Б.Пунсалмаа гишүүний асуултад хариулт өгөөч.

П.Бат-Эрдэнэ: Сангийн яам. П.Бат-Эрдэнэ. Б.Пунсалмаа гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр урсгал зардал Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагаар дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хүртэл хувь байж болно. Үүгээр бодохоор 30 их наяд болж байгаа юм. Ер нь бол. Одоогийнх нь 24.5 гэхээр цааш нь 5.5 их наядын боломж байгаа.

Гэхдээ энэ өөрөө орлогоороо бас давхар хязгаарлагдаж байгаа байхгүй юу. 2026 оны төсвийн төсөлд тэнцвэржүүлсэн орлого 31.6 их наяд төгрөг. Энэ бол Засгийн газраас нүүрсийг 90 сая тонн ч гэдэг юм уу. Тийм ээ. Нөгөө макро үзүүлэлтэд суурилж гарч ирсэн орлого учраас бид энэ дээр ямар нэгэн байдлаар цаашаа орлого нэмэх үнэхээр боломж байхгүй. Энэ засаг дээр маш олон удаа ярьсан. Сангийн яаман дээр маш их хэмжээний тооцоолол хийгдэж гарч ирсэн орлого учраас энэ орлого талаас саад бас хязгаарлагдаад байгаа юм.

Тийм учраас нийт өргөн барьсан зарлага маань өөрөө 32.9 их наяд төгрөг байгаа. Энэ дотроо... /минут дуусав/

О.Номинчимэг: Гүйцээж хариулъя. 6 номер.

П.Бат-Эрдэнэ: Энэ дотроо ямар нэгэн байдлаар зохицуулалт хийгээд явах зүйл байгаа юм.

Гэтэл урсгал зардлынхаа бүтцийг харах юм бол 2026 оны төсөв дээр:

- **9 их наяд төгрөг** буюу нийт урсгал зардлын **27 хувь** нь

- ахмадын тэтгэвэр,
- халамж,
- хүүхдийн мөнгө.

- **7.5 их наяд нь** төрийн албан хаагчдын цалин,
- **1.3 их наяд нь** зээлийн хүүгийн төлбөр,
- **900.0 тэрбум нь** төсвийн байгууллагын үйл ажиллагааны зардал,
- **700.0 тэрбум нь** төсөвт байгууллагуудын байр ашиглалтын зардал.

Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж, хөдөө орон нутгийн тэтгэмж нийлээд 300.0 тэрбум.

Ингээд үндсэндээ төсөв дотор өөрөө ямар нэгэн байдлаар дотроо маневр хийх боломж маш бага байгаа юм.

Тийм учраас Засгийн газар аль болох бүх юмыг нь багтаах байдлаар л төсвөө өргөн барьсан байгаа. Боломж маш хэцүү гэдгийг би өмнө нь хэлсэн.

О.Номинчимэг: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Энэ боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилчдын цалингийн асуудлыг маш олон хүмүүсээс өргөдөл, саналууд ирсэн.

Зөвхөн тэр нэг иргэн биш. Олон нийт масс дэмжиж байна гэсэн илэрхийлэл. Мөн дээрээс нь үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудаас маш тодорхой шаардлагууд ирсэн. Боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбоо гэхэд үндсэн цалин 3.5 сая хүргэ гээд шаардлага тавиад байгаа байхгүй юу. Тэгээд бид болохоор 25 хувь гэхээр үндсэндээ 2 сая ч арай хүрэхгүй. Тэгээд энэ тоо нэлээн хол байгаа юм. Хоорондоо.

Тийм учраас төсвийн тодорхой хязгаар нь 30 хүртэл хувь байгаа учраас би тэр төсвийн хязгаарт нь яагаад тодорхой хэмжээний эх үүсвэрийг тавьж өг өө. Тэгэхгүй жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний 24.1 гэдэг дээрээ баригдаад. Тэр чинь үгүй л гэсэн үг шүү дээ. Ер нь цаагуураа.

Тийм учраас үнэхээр тэр жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө дээр чинь жил болгон цалин нэмнэ гэсэн байгаа. Би бүр горимын санал юу оруулж байж, дахин дахин ярьж байж Их Хурал олонхоороо дэмжсэн. Жил болгон хэдүүлээ ер нь цалингаа тодорхой хэмжээгээр нэмье.

Тийм учраас энэ тал дээр Эдийн засгийн яам, Сангийн яам оруулж ир ээ.

Хоёрдугаарт, энэ хэлэлцээрүүдийн тодорхой үүрэг хүлээсэн заалтууд байгаа байхгүй юу. Боловсролын салбар гэхэд жилд доод тал нь 30 хувь нэмнэ гэж.

Түрүүний П.Наранбаяр сайдын яриад байгаа тэр үйл ажиллагааны 3 жилийн төлөвлөгөө гэдэг дээр нэгэнт багш нарын цалин, хөлс орлогыг. Бид чинь бараг 3 жилийн юм ярьж байна шүү дээ. Төсвийн хүрээний мэдэгдэл 2028 он хүртэл. Тэр үедээ ер нь яах вэ гэдэг итгэл өгмөөр байгаа юм.

Тэгэхээр сая сайдын хэлж байгаа 60 хувь нь 5 жил ажиллаад л гараад явна гэдэг бол хайран цаг хугацаа, үнэт капитал байгаа байхгүй юу. Бид бараг үүнийг төсвийн алдагдлаас ч илүү үнэлэх ёстой байгаа юм. Бэлдэж өгөөд, сургаж өгөөд, дадаад ирэнгүүт нь 60 хувь нь гараад явдаг. Ер нь манай төрийн алба тийм л юм билээ л дээ.

Тэгэхээр энэ нь хүн капиталын гарах урсгалыг хаах. Нөгөө талаараа ер нь чи багшаар ажилласан тохиолдолд тэдэн жил ажиллахад 2028 он гэхэд цалин чинь нэг ийм болно. Ийм ийм нийгмийн хамгаалууд бий болно. Дээрээс нь орон сууцад орохоор ийм баталгааг чинь хангаж өгнө гэдэг ийм зүйлээр ярихгүй бол болохгүй байгаа юм.

Эрүүл мэнд дээр ч гэсэн мөн ялгаа байхгүй. Би түрүүн бас хэлсэн. Үндсэн цалингийнх нь доод дээд хязгаар гэдэг зүйлийг нь авч хаяхгүй бол тэр эмнэлэг болгон тэр үндсэн цалингуудаа өөрсдийнхөө тэр гүйцэтгэлийн үнэлгээ л юм бол бүгд ижилхэн цалинтай байх албагүй. Тэрийг нь нэмэх эх үүсвэрүүдийг нь тодорхой хэмжээгээр тавьж өгөх шаардлага байна.

Тийм учраас би Сангийн яам, Хөдөлмөрийн яамнаас асуухад та хэд энэ гурван талт хэлэлцээр гэдэг зүйлээ хийсэн юм уу? Хэдэн хувиар ярьж гэж тохирсон юм? Энэ бүх яамд оролцоод хийдэг шүү дээ. Түүгээрээ ер нь цалингийн юм ярьсан юм уу, яриагүй юм уу? Тэгээд ганцхан Боловсролын яам нь мэднэ биз гэдэг байдлаар, эсвэл Эрүүл мэндийн яам нь мэднэ биз гэдэг байдлаар хаяад байж болохгүй.

О.Номинчимэг: Аль альнаас гэдэг нь Боловсролын яам уу, Сангийн яам уу? Сангийн яам 6 номер.

П.Бат-Эрдэнэ: Сангийн яам П.Бат-Эрдэнэ. Гишүүний асуултад хариулья.

Тэгэхээр төсвийн төслийг боловсруулахад сайд нар дээр Сангийн сайд сайд нартай уулзалт хийсэн. Яах вэ гэдэг гарц гаргалгаагаа маш олон удаа ярьсан. Засгийн газар дээр мөн төсвийн төслийг хоёр удаа хэлэлцсэн. Тэгээд л өргөн баригдаж байгаа төсөв.

Бүх макро үзүүлэлт дээр үндэслэсэн орлогоор үнэхээр тэр мөнгө нь байхгүй бол бид яг байгаа мөнгөндөө тааруулаад л оруулж ирж байгаа төсөв.

Тийм учраас зүгээр нэг жилдээ нийт төрийн албан хаагчдын цалин, хөлс нэмэхийг тэвчээд явъя гэсэн ийм агуулгаар л орж ирж байгаа төсөв л дөө.

Ингээд үнэхээр орлого нь байхгүй бол тэгээд л зарим нэг зардлаа нэмж чадахгүй тохиолдол гарах үе байна. Тэгээд 2026 оны хувьд яг тийм л зүйл болоод байгаа юм.

Бид статистик өсөлт болон ахмадын тэтгэвэр нэмэхтэй холбоотой зардал 900.0 тэрбум төгрөг автоматаар ороод ирж байгаа юм. Дээрээс нь мөн урсгал зардал дээр хуулийн дагуу нэмэгдэж байгаа зардлууд байгаа. Үүнийгээ оруулаад 24 хувь гэсэн Их Хурлаас баталсан бодлогын баримт бичигт заасан шаардлагаа хангахын тулд зарим нэг зардлыг бууруулсан. 600.0 тэрбум төгрөгөөр зардлаа бууруулж байж ингэж барьж орж ирсэн төсөв байгаа.

Тэгэхээр Сангийн яамны хувьд орлогыг маш бодитой төлөвлөөд. Үнэхээр байхгүй орлого дээр бид ямар нэгэн ийм хий орлого нэмээд цалин нэмэх юу гаргалтай нь байна шүү дээ. Тийм ээ. Засгийн газар талд ийм зовлон байна.

Тэр гурван талт тын асуудлыг манай Нийгмийн хамгааллын яам хариулах нь зөв байх. Баярлалаа.

О.Номинчимэг: Гурван тал дээр хэн хариулах вэ? 3 номер. Л.Мөнхзул дарга.

Л.Мөнхзул: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул. Гишүүний асуултад хариулъя.

2024-2026 онд хэрэгжих 3 жилийн хугацаанд байгуулсан улсын хэлэлцээр байгуулагдсан. 2026 оны 7 дугаар сард дахин шинэчлэх асуудал яригдах ёстой.

Улсын ерөнхий хэлэлцээр дээр жил бүр төрийн албан хаагчдын цалин, хөлсийг. Үүн дотор эмч ба багш нарын цалин, эрүүл мэнд, боловсролын салбарт нийт ажиллагчдын цалинг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ гэсэн ийм ерөнхий заалт байгаа.

Түүнчлэн салбарын хэлэлцээрүүд хийгдсэн. Эрүүл мэндийн салбарын болон боловсролын салбарын хэлэлцээрүүд.

Эрүүл мэндийн салбарын хэлэлцээрийн хүрээнд 3 жилийн хугацаанд дундаж цалинг 30 хувиар нэмэгдүүлнэ гэсэн заалт орсон. Мөн түүнчлэн боловсролын салбарт хийгдсэн салбарын хэлэлцээрийн хүрээнд 3 жилийн хугацаанд эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалинг мөн 3 саяд хүргэнэ гэдэг ийм зорилт... /минут дуусав/

О.Номинчимэг: С.Эрдэнэбат гишүүн 1 минут тодруулъя.

С.Эрдэнэбат: Сангийн яамнаас асуухад жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд яг зэрэгцээд байгаа хоёр заалтын нэгийг нь аваад нөгөөдхийг нь

авахгүй л гээд байгаа юм байна л даа. 24-ийг авна. Нөгөө талд нь цалин нэмэхийг больё гэж.

Тэгэхдээ үүнийг Сангийн яам, хэдэн сайд нар сууж байгаад ер нь цалингаа нэмэхээ больё гэдэг асуудал. Энэ чинь цаанаа Их Хурал, парламент чинь өөрөө жил болгон цалин нэмнэ гээд бүх улс төрийн намууд мөрийн хөтөлбөрөө дэвшүүлээд, түүнд нь итгэж хүмүүс саналаа өгөөд, энэ чинь нийгмийн хэлэлцээр байхгүй юу, итгэлцэл байхгүй юу.

Тэгэнгүүт нь ер нь бид ингэж бодож байгаа юм гэж тавингуутаа нөгөө талд нь тэр хөрөнгө оруулалт нэртэй. Яг ний нуугүй хэлэхэд тэр өөрөө яг нийт ард түмэнд хүртээмжтэй байна уу, үгүй байна уу? Ингээд харахад маш их юм байна. Би үүнийг төсвийн нарийвчилсан юман дээр нэлээн ярья гэж бодож байна.

Тийм учраас Сангийн яам, сайд нар ярьж байгаад тодорхой яг тэр төсвийнхөө хэрэгцээтэй юмнуудаа гаргаад ирээч ээ. Яг хэдэн төгрөг хэрэгтэй байна вэ?

О.Номинчимэг: Үг хэллээ. Гишүүд энэ асуудалтай холбоотойгоор асуулт асууж, хариулт авч дууслаа.

Уг асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? С.Эрдэнэбат гишүүнээр тасаллаа. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн үг хэлье.

Л.Мөнхбаясгалан: Эмч нарын цалинг нэмэхгүй юм байна. Багш нарын цалинг нэмэхгүй юм байна. Тэтгэврийнхний тэтгэврийг бас нэмэхгүй юм байна.

6 хувь нь аманд ч үгүй, хамарт ч үгүй хуулиараа явах юм байна. Үүнийг Засгийн газар, сайд нар хангалттай хэллээ. Мэдээж сайд нар ингэж хэлэхдээ баяр хөөртэй байгаагүй байх гэж би бодож байна

Тэгэхээр одоо яах юм тэгээд. Гүйцэтгэх засаглал Засгийн газар ажлаа хийх ёстой шүү дээ. Та нар Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллага. Засгийн газар төсвөө батлахдаа үүнийгээ бодож олох ёстой. Хэрвээ мөнгө байхгүй та нар олох ёстой.

Тэгэхгүй Их Хурлын гишүүдэд авчирч хаячхаад чаддаг юм бол та нар өөрсдөө нэмэхгүй юу. Хаанаас мөнгө олох юм. Хаана ч мөнгө байхгүй гээд байх юм бол энэ төсвийг бас Улсын Их Хурал буцааж болно. Бүрэн эрхийн асуудал.

Ардчилсан намын бүлгийн зүгээс энэ асуудлыг бас тавьсан байгаа.

Монгол Ардын нам өөрсдөө засгаа огцруулсан. Өөрсдөө дахиад байгуулсан. Бид оролцоогүй. Та нар өөрсдөө энэ ажлаа хийх ёстой. Чадахгүй бол улсын төсвийг буцааж болно.

Эмч нарынхаа, багш нарынхаа, тэтгэврийн настуудынхаа тэтгэвэр цалинг нэмж чаддаггүй ийм Засгийн газар, ийм Их Хурал байгаад бид өнөөдөр Монголын төрийг барьж тоглоод энд бие биеийнхээ цагийг үрээд өглөөнөөс хойш хоорондоо юм яриад байх ямар ч хэрэггүй л дээ.

Тэгэхээр төсвийг буцааж болно. Төсвөө хэрвээ бид тогтсон хугацаандаа хуулийн хугацаанд баталж чадахгүй бол Улсын Их Хурал тарж болно. Бүр сайхан тарж болно. Ийм чадамжгүй төр, ийм сэтгэлгүй ажил хийж чадахгүй байгаад ер нь яах вэ дээ.

Тэгээд Монголын ард түмэн шууд хэлье.

- Багш нар аа, цалинг чинь нэмж чадахгүй юм байна.
- Эмч нар аа, цалинг чинь нэмж чадахгүй юм байна.
- Ахмад настууд аа, тэтгэврийг чинь нэмж чадахгүй юм байна.

Энэ ажлыг хийж чадаагүй Засгийн газарт төсвийг нь буцаах хэрэгтэй. Төсвөө баталж чадахгүй Улсын Их Хурал тарах л хэрэгтэй. Шинээр байгуулагдъя. Тоглоомын дүрмээ шинэчилье. Энэ дээр Ардчилсан нам шийдвэрээ ер нь гаргаж байгаа. Бид өчигдөр мэдэгдэл хийсэн байгаа.

Тэгэхээр одоо хариуцлагаа үүр дээ. Олонх Монгол Ардын нам хариуцлагаа үүр, ажлаа хий. Бид сайн сөрөг хүчин байя.

О.Номинчимэг: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Хэдүүлээ нэгдүгээрт, нэг зүйл дээр тохирьё гэж бодож байна.

Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний 24 хувьд барина гэдэг юмаа толгойноосоо авч хаяя. Энэ дээр манай Ардчилсан намынхан ч хамаатай. Урсгал зардал нэмээр л болохоо байдаг гэдэг байдлаараа хамтарч байхдаа хэдүүлээ чинь нэг сайхан юм гаргаад ирсэн. Энэ дээрээ би санал нэгтэй. Одоо манай гишүүд санал нэгтэй байна гэж бодож байна. Үүнийгээ эхлээд аваад хаяя. Одоо нааштай гишүүд байгаад би баяртай байна.

Яах вэ, тухайн үед бид хэд хөөрцөглөөд зам, гүүр барья гээд нэлээн өөдрөг байсан. Одоо хөрсөн дээрээ зарим талаар жоохон буугаад.

Тэгэхээр одоо манай бүх намын гишүүд бүгдээрээ л нэмье гэдэг байр суурьтай байгаа дээр би баяртай байна.

Гэхдээ энэ дээр Засгийн газар өөрөө асуудлаа оруулж ирэх ёстой. Их Хурлын гишүүдээр таавар таалгаж болохгүй. Бүх төсвөө нэгдүгээрт, зардлаа танах юмаа танаад, тодорхой хэмжээний алдагдал энэ тэр байх юм үүнийг бас

ойлгоно шүү дээ. Тодорхой хэмжээний боловсрол, эрүүл мэндийнхээ салбар луу хөрөнгө оруулж байгаа учраас алдагдалтай тавья.

Явцын дунд байгаа төсвүүд 05 сарын 01 хүрэхгүй бол тэр төсөл, арга хэмжээгээ буцаад татъя гэдэг энэ арга руугаа ч орж ирэхэд төсөв хэмнэгдэнэ. Жилийн эцсээрээ бас балансаа бариад гайгүй орж ирэх боломжтой байх. Ийм зүйлүүд байгаа.

Зарим нь ний нуугүй хэлэхэд зураг, төсөл хэзээ хэрэгжих хэрэгжихгүй нь мэдэгдэхгүй маш олон төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүд байгаа.

Хоёрдугаарт, боловсролын салбар, эрүүл мэндийн салбар. Энэ хоёр төсвөөс Засгийн газар санал авсан гэсэн. Хамгийн их нь боловсрол, эрүүл мэндийн салбарын хүмүүсийнхээ цалин, хөлсийг нэмье гэдэг дээр хамгийн их санал өгсөн байна гэж ойлгосон.

Тэгэхээр үүнийгээ санал авсан юм бол хэрэгжүүлэх ёстой. Тэгэхгүй саналаа өг. Тэгж байгаад бид байхгүй гээд хэлье гэдэг ийм байдлаар төсөв тавьж болохгүй л дээ.

Тийм учраас энэ тал дээр гишүүд санал нэг байна.

Тэр 100 тэрбум бас нэг арга хэмжээ мөн шүү. Бид алгассан. Тэр 40-өөс дээш, 50-иас дээш хүүхэдтэй байгаа тэр хувьсах зардлаар нь хүүхдүүдийнх нь нэмэгдэл цалингуудыг нь олгох ёстой. Эсвэл тэр нэмэлт багш нарыг нь ажиллуул. Тэр 70 хүүхэд, 60 хүүхэд, 50 хүүхэдтэй ажиллаж байгаа багш нараас ямар ч үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээ нэхээд нэмэр байхгүй шүү дээ. Ийм зүйлийг хэлмээр байна.

Эрүүл мэнд дээр Ж.Чинбүрэн сайд аа, та өөрөө сайдын хувьд, салбарын хувьд тодорхой эмч нарынхаа цалинг нэмэгдүүлэхэд нэг ийм хэмжээний мөнгө хэрэгтэй байна гэдэг тоогоо оруулж ир ээ. Бид энэ дээр чинь бас нэг баримжаа авмаар байна.

Боловсрол дээр П.Наранбаяр сайд 25 хувь л гээд байгаа. 560.0 тэрбум төгрөг хэрэгтэй гээд байгаа. Бүтцийн хувьд яаж нэмэх вэ гэдгээ бас бодоорой. Тэр дээрээ одоо тэр хувьсах зардал 100-г нь олсон. Одоо 460 гэж яриад байна. Гэтэл энэ үйлдвэрчний эвлэлд чинь цаанаа үндсэн цалинг нь 3.5 гэдэг бүр нэлээн том тоо тавьчихаад байгаа.

Тэгэхээр энэ тал дээрээ нэг хэлэлцээр хийгээч. Тэр Хөдөлмөрийн яам дахиж хэлэлцээрээ хий. Бид чинь төсөв орохоос өмнө хэлэлцээрээ хийгээд цалин дээрээ тохироод ороод ирдэг шүү дээ. Тэгээд 7 сард хийх ёстой байсан. Хийгээгүй. Одоо хүртэл юу хийдэг юм. Тэр бүх сайд нарыг нь суулгаж байгаад тэр хувийн хэвшил ч гэсэн дэмжиж байна гэдгээ илэрхийлж байгаад.

Боловсрол, эрүүл мэнд дээр бид дэмжинэ шүү л гэж хэлнэ шүү дээ. Манай хувийн хэвшлийн салбарынхан бол.

Тийм учраас ойрын хугацаанд тал тал талдаа ажлаа хийгээд хэдүүлээ нэг тоон дээрээ уулзъя. Сангийн яам бол хүссэн хүсээгүй Их Хурал дээр үүнийг шаардана. Гишүүд дийлэнх нь шаардана. Энд сууж байгаа Өргөдлийн байнгын хорооны гишүүд бараг 100 хувь дэмжиж байгаа болов уу гэж би бодож байна.

Тийм учраас энэ тал дээр тодорхой тоо оруулж ир ээ. Огт нэмэхгүй, нэмэх хоёрын хооронд нэлээн зай байна шүү дээ.

Тийм учраас Өргөдлийн байнгын хороо энэ тал дээр дэмжээд энэ асуудал хариуцсан Хөдөлмөрийн яам, Боловсролын яам, мөн холбогдох Төсвийн байнгын хороо, Эрүүл мэндийн яаманд нь тодорхой саналаа боловсруулж орж ир гэдэг ийм зүйлээр шийдвэрлэх нь зүйтэй гэж бодож байна.

О.Номинчимэг: Ганзоригийн Лувсанжамц гишүүн үг хэлье.

Г.Лувсанжамц: Юуны өмнө чуулганыг үзэж байгаа, энэ саналыг оруулж ирсэн иргэддээ маш их баярлалаа. Өргөдлийн байнгын хорооны үүрэг бол иргэд, аж ахуйн нэгжүүдээс өгсөн саналыг ажил хэрэг болгож явдаг, ажлын хэсэг байгуулдаг, Засгийн газрын шийдэж чадахгүй байгаа зүйлийг нь шийдлийг нь гаргаж өгөх тийм чиг үүрэгтэйгээр байгуулагдсан.

Тэгэхээр олон хүмүүс энэ Өргөдлийн байнгын хороог ашиглаасай, хандаасай, санал, шийдлээ хүргүүлээсэй гэж хүсэж байна

Хоёрдугаарт, багш, эмч нарын цалинг нэмэх бүрэн боломжтой. Нөгөө талдаа бид юуг хийх юм бол нэмэх боломжтой вэ гэхээр төрийн өмчит компаниуд, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд. Эд нарыгаа цэгцлэх хэрэгтэй байна.

Төр нь өөрөө бизнес хийдэг, байшин барьдаг, зам засдаг, цэвэрлэдэг, тэгээд ашиггүй ажилладаг.

Нийтдээ 107 төрийн өмчит компани 9 яам, агентлаг дээр байгаа. Төсөв дээр энэ нь тусдаггүй. Тэгээд бид орлогогүй байна, хэцүү байна гээд төсөв байхгүй учраас багш, эмч нарын цалинг нэмж чадахгүй гээд суудаг. Төрийн өмчит компани дээр хэн сууж байна гэхээр олон жил улс төрч хийсэн ах нарын хамаатан садан, цүнх барьсан залуучууд нь суугаад ашиггүй ажилладаг.

Нийт ногдол ашгийн 90 хувийг нь “Эрдэнэс Монгол” бүрдүүлээд, бусад энэ 100 гаруй төрийн өмчит компаниуд нь 10 хувь хүрэхгүй байгаа байхгүй юу. Эд нарыгаа татан буулгаад бид энэ зардлуудаа танаад явах юм бол бүрэн боломжтой. Сангийн яам үүнийг маш сайн мэдэж байгаа. Яагаад Их Хурал дээр гишүүдэд хэлж чаддаггүй вэ гэхээр дээр нь ах нар сууж байгаа юм чинь. Нэгийг

нь татан буулгаад гарахад нэг даргынх нь л хамаатан садан нь явах гээд байдаг.

Тэгэхээр Өргөдлийн байнгын хороо дээрээ энэ асуудлыг өргөн хүрээгээр авч үзээд, шийдэл гаргаад явцгаая. Тийм л зорилготой 126 гишүүнтэй парламент болсон. Нам харгалзахгүйгээр шийдлээ гаргаад явдаг. Тухайн шийдэл дээр нь шаардлагатай мэдэгдлийг нь бид яамдаасаа авдаг. Манай яамд сайн ажиллаж байгаа яамд байгаа. Энд сууж байгаа зарим гишүүд зарим яамыг болох бүтэхгүйгээр нь дуудаад бараг салж уналаа гэсэн юм ярьдаг. Өдөр болгон Байнгын хороон дээр хүрч ирээд шийдлээ яриад л, чадлаараа хийгээд ажиллаад явдаг. Бид эсрэгээрээ төрийн өмчит компаниуд руу орох ёстой байгаа байхгүй юу. Тэрийг Та бүхэн маань бас иргэний хувьд Өргөдлийн байнгын хороонд хандах бүрэн боломж бас төрийн албан хаагчдад маань байгаа шүү.

Та хэд маань төрийн албан хаагчийн хувьд боломжгүй тийм зүйл байдаг бол иргэний хувьд та хэд маань энэ Байнгын хороондоо хандаасай гэж хүсэж байна.

Тэгээд хэдүүлээ энэ 2026 ондоо боломжгүй гэж байгаа бол энэ байгуулах гэж байгаа ажлын хэсгээрээ төрийн өмчит компаниудын асуудлыг авч хэлэлцье.

Сая Р.Эрдэнэбүрэн сайд шийдэл байхгүй юм байна. Шийдэл байхгүй юм чинь ажлын хэсэг байгуулаад яах юм гэж хэлж байсан. Шийдлийг нь олъё хэдүүлээ. Тэгээд 2027 оны төсөв дээрээ эд нарыг нь суулгаад нэмэх ажлыг хийнэ.

Харин шаардлагатай төсөв тооцоог нь та хэд маань Эрүүл мэндийн яам, Боловсролын яам ач холбогдлын эрэмбээр нь гаргаж өгөх хэрэгтэй шүү.

Өчигдөр Азийн хөгжлийн банкны зээлийн гэрээ орж ирсэн. 41 сургууль, цэцэрлэг барина гэсэн ч талыг нь хөдөө орон нутаг дээр барина гээд ороод ирж байгаа юм. Улаанбаатар хотод эмнэлэг байхгүй байна. Улаанбаатар хотод сургуулийн анги, танхим хүрэлцэхгүй байна гэж байхад орон нутаг руу нь тавиад ороод ирдэг. Шалтгааныг нь ойлгож байна л даа. Орон нутгаас сонгогдсон гишүүдийнхээ саналыг авч чадахгүй чуулган дээр унаж ч магадгүй байна.

Гэхдээ Улаанбаатарт нөхцөл байдал хэцүү байгаа гэдгийг бүгдээрээ мэдэж байгаа. Д.Ганмаа гишүүн сая хэлсэн ач холбогдлын эрэмбэ, шалгуур үзүүлэлт. Тэрийгээ маш тодорхой гаргаж өгөхийг хүсэж байна. Тэгээд хэдүүлээ хамтраад ажиллая. Хэрүүл хийдэг газар биш шүү дээ. Энд шийдэл гаргадаг газар. Ийм уриалгыг хэлж байна. Баярлалаа.

О.Номинчимэг: Дүгэрийн Рэгдэл гишүүн үг хэлье.

Д.Рэгдэл: Тэгэхээр манай Монголчуудын маань үндсэндээ 5 хувь нь цалин нэмэх асуудлыг дэмжиж оруулж ирсэн. Ийм учраас энэ дээр маш

нухацтай ярьж, асуудлыг шийдэх ёстой байгаа юм. Зүгээр цааш нааш нь гүйлгээд аргалаад өнгөрөх ямар ч боломж байхгүй.

Тэр хязгааруудыг давах хуулийн боломжууд бүгд байгаа. Цалингаа шинэчлэн тогтоох эрх мэдэл нь зөвхөн Засгийн газарт байдаг.

Тэгэхээр Засгийн газар энэ дээр онцгой анхаарч ажиллах ёстой. Бид Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороон доор боловсролын салбарын төсвөөр нэлээн сайн ярилцаж хэлэлцсэн. Сайд нь илтгэлээ тавьсан.

Тэгэхээр эрүүл мэндийн салбарт ч, боловсролын салбарт ч ялгаагүй энэ тооцоонууд байгаа. Хэчнээн төгрөг дутаад байна вэ, цалин нэмэхэд. Энэ тооцоонууд их нарийвчилж гарсан гэдэгт би эргэлзэхгүй байна.

Тийм учраас энэ тооцоогоо Байнгын хорооноос ажлын хэсэг гарч магадгүй юм шиг байна. Энд өгөөд, гарцаа хамтарч ярилцаад явах нь зохимжтой. 3

Зүгээр өнөөдөр бид өргөдөл ирсэн учраас багш, эмч нарын цалинг ярьж байна. Үнэн хэрэг дээрээ энэ бол төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн тухай асуудал болж хувирах ёстой. Яагаад гэвэл тэд хамгийн бага цалинтай. Тэр бага цалингаараа арай ядан амьдардаг.

Одоо манай шинжлэх ухааны салбар гэхэд дундаж цалин 1 сая 720 мянга. 1 сая 720. Энэ 1 сая 720 мянгаас доогуур хамгийн шинэ улсуудын авдаг цалин боловсролынхтой төстэй. 1 сая 470 мянга. Шинэ хүмүүс. Эд нар хэзээ нэмэгдлээ авдаг вэ гэхээр удаан жилийн нэмэгдлээс бусад нэмэгдлийг ажилд орсноосоо 10 жил, 15 жил болж байж бусад нэмэгдлүүддээ хүрэх нөхцөлийг хангадаг.

Боловсролын салбарыг сонсож байхад цалингийн нөхцөлд шинжлэх ухааны салбараас арай дээр. Би хэрвээ буруу санаж байгаа биш бол дундаж цалин 2 сая 500-гаар гарч ирдэг.

► Хөдөө орон нутагт **2.9 сая**.

► Нийслэлд **2.3 сая** төгрөг байна. Дундаж цалин.

Тэгэхээр П.Наранбаяр сайд дундаж 2.5 саятай саяын цалинтай энэ өргөн хүрээний маневр хийх, менежмент хийх боломж бас энэ дотор байж магадгүй. Энэ одоо байгаа цалиндаа маневр хийгээд үзвэл яасан юм. Шинэ орж байгаа улсуудынхаа цалинг ахиухан нэмж өгөөд. Цөөхөн хүн авдаг онцгой нэмэгдлүүдээ, их нэмэгдлүүдээ танах талаар эхний ээлжид бодлого бодоод Байнгын хорооны энэ гарч магадгүй ажлын хэсэг дээр танилцуулбал ийм боломж байгаа болов уу гэж бодож байна. Ингээд явбал бас яах нь вэ. Ингэ гэсэн үг биш. Ингэж тооцоод үзэх ийм том далайд байгаа хүн учраас үүнийгээ бас хараад явбал зүгээр.

Эрүүл мэндийн салбарын хувьд ер нь үүнээсээ арай бага цалинтай байх гэж би боддог. Тэгээд эрүүл мэнд, боловсрол хоёр чинь ер нь эцсийн эцэст энэ Монгол Улсын хүний хөгжил төдий биш, Монгол Улсын хөгжлийн суурийг л энэ хоёр маань бэлдэж өгдөг учраас Байнгын хороо онцгой анхаараад бүх боломжийг нь гаргуулах, тэр гаргуулах талаар эрх зүйн боломжуудыг нь нээж өгөх, энэ талаар Байнгын хорооны ажлын хэсэг ажиллаад явахад болохгүй юм байхгүй байх л гэж бодож байна.

О.Номинчимэг: Баярлалаа. Даваасамбуугийн Ганмаа гишүүн үг хэлье.

Д.Ганмаа: Манай Байнгын хороо бусад Байнгын хорооноос үнэхээр зарчмын ялгаатай. Мэргэжлийн гэхээсээ илүү ганц иргэдтэй холбож, иргэдийн дуу хоолойг парламентад хүргэж байгаа. Тэгснээрээ төрийн хямралыг бий болгохгүй байх маш том хариуцлага бүхий Байнгын хороо. Энэ дээр асуулт асууя.

Эрүүл мэндийн ажилтнууд ажил хаялт хийвэл хэн хариуцлага хүлээх вэ? Яг одоо. Засгийн газрынхаа бодлогыг нягтралтай, уялдаатай хийж, эрүүл мэндийнхээ бодлогыг эрэмбэ дараатай засгийн өмнө хариуцаж эрэмбэлж гаргаж чадаагүй, бодлогоо гаргаагүй тухайн салбарын сайд уу, эсвэл иргэд үү, эсвэл эмч, сувилагчдын буруу болох уу?

Ер нь иргэдийн эрүүл мэндийн даатгалд сар болгон шимтгэл төлж байгаа. Гэтэл тэр даатгалын мөнгө нь эмч, сувилагч, мэргэжилтнүүдийн сайжруулах цалин нөхцөл нь болохгүй юм бол төр иргэдийнхээ итгэлийг яаж даах юм бэ?

Өнгөрсөн болсон явдлуудыг ярьж зовлонд тоочхоосоо илүү яг тодорхой бодлогыг гаргаж өгөөд, тэгээд тоо баримттай засагтаа гаргаж өгөх шаардлагатай байна.

Салбараас жишээлбэл, эмч, сувилагч нар хэт ачаалалтай ажилласан, шөнө ээлж дараалалд осолд орсон, сэтгэл гутрал, BURNOUT болсон эдгээр талаар бодитой тоон мэдээлэлтэй тийм баримт шаардлагатай байна.

Цалин бага байгаа нь BRAND DRAIN буюу эмч, сувилагч нар гадагшаа гарч яваад байгаагийн хувь нэмэр. Энэ нь эмнэлэг, тусламжид яаж нөлөөлөөд байгаа дээр энэ урсгалтай тоо баримт.

Эмч сувилагчдын дутагдлын тоо. Үүнийг чанартай хүртээмжид хүргэж чадахгүй байгаатай тоо баримт.

Төсвийн ерөнхий зохицуулалт нь эрүүл мэнд, боловсролд 30 хувь хүртэл байх ёстой гэдэг боловч энэ зөвлөмж мөрдөхгүй байгаа яг үндэслэл, шаардлага, шалтгаан.

Тэгээд эмч, сувилагчдын дундаж цалин бусад төрийн агентлагууд, дарга нарын цалин мөнгөнөөс хамаагүй бага байгаа энэ асуудал.

Эдгээр бүх асуудал дээр тоо баримттай, үндэслэлтэйгээр нь цаашаа Сангийн яам, Эдийн засгийн яаман дээр оруулах ийм саналтай байна.

Ингэж байж бид өөрчлөлт, шинэчлэлт, цалингийн яг нэмэлт бодитой эх үүсвэрийг гаргаж ирнэ. Тэгж байж бид цалин мөнгөө нэмэх боломж нь гарна. Энэ дээр яах аргагүй бодлого, манлайлал дутагдна.

О.Номинчимэг: Гишүүд маань үгээ хэллээ.

Ер нь манай Байнгын хорооны эрхлэх хоёр чухал асуудлын нэг нь энэ иргэдийн санал гомдол байгаа. Нийтийн эрх ашгийг хөндсөн. 33 мянган хүн саналаа өгсөн энэ асуудлыг бид Байнгын хорооны хувьд нухацтай л авч хэлэлцэх ёстой.

Тэгээд яах вэ, өнөөдөр яг энэ асуудал дээр Сангийн яам нь ямар ч боломжгүй гээд. Хоёр сайд нь та нар шийдээд өгөөч ээ. Бид нарт ийм хэрэгцээ байна гээд байж байгаа.

Нэгдүгээрт, Засгийн газар өөрийнхөө Засгийн газрынхаа түвшинд ажиллаж байгаа байдал хангалтгүй байгаагийн л илрэл. Иргэдийн дуу хоолой яг нөхцөл байдлыг бид төрийн бодлогод тусгах. Тийм ээ. Юу болоод байна гэдгийг тусгах үүрэгтэй Байнгын хорооны хувьд бид үүнийг цааш нь нухацтай авч хэлэлцээд л гарах ёстой.

Тэгээд энэ дээр түрүүн төсвийн хэлэлцүүлэг дээр ярьж байсан. Манай Засгийн газар, Сангийн яам тэр 2026 оны улсын төлөвлөгөөндөө дотоодын нийт бүтээгдэхүүний 24 хувиас дээшгүй урсгал зардал байна гэдэг заалтыг маш сайн чанд мөрдөж орж ирсэн мөртлөө төрийн өмчит компаниудын зардлыг 15 хувь бууруулж, бүтээмжийг 30 хувь ихэсгэнэ гэдэг заалтыг барилгүй л ороод ирсэн байгаа байхгүй юу. Тийм юм байхгүй гэдгээ протоколд хэллээ шүү дээ.

Тэрийгээ л Засгийн газар хийгээд тэндээсээ эх үүсвэрээ гаргах ёстой шүү дээ. Эх үүсвэрээ гаргаад энд өнөөдөр яах вэ энэ асуудал дээр эмч нар, багш нарын цалин ч яригдаж байна.

Дараагийн асуудал бидэнд ахмадуудын тэтгэврийн асуудал ороод ирсэн байгаа. Угаасаа иргэдийн бодит амьжиргаа ийм л байна шүү дээ. Үнийн өсөлтөөс чинь үүдээд ийм л болсон байна шүү дээ. Үнийн өсөлтөө үүнийг чинь хязгаарлах асуудал хаана хаанаа бид анхаарч л явах ёстой байсан. Барьж чадахгүй байна. Ингээд ирэхээр боломжгүй, боломжгүй гэхээсээ илүү хаана хаанаа боломжоо гаргаж харсан нь дээр байх л гэдэг байр суурьтай байна.

Тэгэхээр гишүүд одоо ийм байгаа юм. Манай Байнгын хороо ахалж үүнийг хэлэлцээд, үүнийг мэргэжлийн Байнгын хороод буюу Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хороо хэлэлцэнэ. Ялангуяа 2026 оны төсвийн төсөл хэлэлцэгдэж байна.

Тэгэхээр энэ дээр С.Эрдэнэбат гишүүн хөндөж ярьсан тэр 24 хувийн хязгаарлалтыг яах юм гэдэг асуудал дахиад шат шатны мэргэжлийн Байнгын хороодуудаар хэлэлцэгдэх байх.

Нөөц бололцоонуудыг тэгвэл хаанаас гаргах вэ гэдэг асуудал дахиад бусад Байнгын хороод дээр, ажлын хэсэг дээр яригдах байх.

Тэгэхээр хэрвээ энэ асуудлыг үнэхээр 2026 оны төсөвт тусгаж явна гэх юм бол тусад нь Байнгын хороо, ажлын хэсэг гэхээсээ илүү бараг тийшээгээ санал, дүгнэлтээ өгмөөр байгаа юм. Төсвийн ажлын хэсэг байгуулахад. Энэ хоёр Байнгын хороонд. Энэ дээр анхаар. Ийм чиглэлээр бид хэлэлцлээ гэдэг.

Үнэхээр боломжгүй гэх юм бол 2026, 2027 онд тэгвэл яах юм гэдгээр энэ чинь бүр том системийн асуудал. Тийм ээ. Эрүүл мэндийн салбарын үр ашигтай байдал, боловсролын яамны санхүүжилт, цалингийн тогтолцоо, орон нутгийн нэмэгдэл, гүйцэтгэлийн санхүүжилт гээд олон асуудал руу орох нэлээн том ажил болох гээд байна.

Тэгээд энэ удаад энэ өргөдлийг гурван Байнгын хороонд хуваарилж өгсөн байгаа.

Тэгэхээр эхний ээлжид бид зарчмын хувьд энэ асуудлыг дэмжээд ер нь орон зайг хайж ажиллаж, төсвийн хязгаарлалтууд дээр өөрчлөлт гаргах тал дээр Улсын Их Хурал бид угаасаа шийдвэр гаргах ёстой. Шийдвэр гарсан тохиолдолд энэ дээр бид нөөц бололцоо бага хэмжээгээр ч хамаагүй гарах байх гэж бодож байна.

Тэр тохиолдолд үүнийг тусгаж ажиллах талаар санал, дүгнэлт санал хураалгаж болж байна. Үүнийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хороон дээр хэлэлцээд тэгээд энэ чинь яг гол асуудал гурав дахь хэлэлцүүлэг дээрээс чуулган дээр хэлэлцээд, гурав дахь хэлэлцүүлгээс явах болов уу л гэсэн ийм байгаад байна.

Үүнийг өнөөдрийн хэлэлцүүлгийн шийдэл болгож хэрвээ Та бүхэн маань санал нэгдэж байвал зарчмын хувьд энэ өргөдлийг. Ажлын хэсэг байгуулж болно. Гэхдээ ажлын хэсэг байгуулах шийдвэр гурван Байнгын хороонд хуваарилж өгсөн учраас Улсын Их Хурлын даргын захирамжаар гарах юм.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Өргөдлийн байнгын хороо гурваас хамтарсан ажлын хэсэг угаасаа даргын захирамжаар байгуулах ёстой байгаа юм.

Тэгэхээр тэр ажлын хэсэг мэдээж хэрвээ гурван байнгын хороогоор дэмжигдсэн тохиолдолд байгуулагдах боломжтой болно.

Өнөөдрийн хэлэлцүүлгийн шатад бид энэ асуудлаар нийтийн өргөдлийг зарчмын хувьд дэмжээд, бусад эрхлэх асуудлын хүрээнд Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хороонд 2026 оны төсвийн төслийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан энд орж байгаа тэр хүрээ хязгаар өөрчлөгдөх тохиолдолд энэ саналыг тусгуулж шийдвэрлэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя гэсэн ийм саналтай байна.

Тэгээд энэ дээр саналын томьёолол дээр саналтай гишүүн байна уу? Болж байна уу? Зарчмын хувьд цааш нь энэ асуудлаа анхаараад л явъя гэсэн асуудал байгаа шүү дээ. Тийм ээ.

Саналаа хураая. Монгол Улсын иргэн Б.Номингоос ирүүлсэн эмч, багш нарын цалинг нэмье гэсэн асуудлаарх нийтийн өргөдлийг зарчмын хувьд дэмжиж, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хороогоор хэлэлцэхдээ Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг хэлэлцүүлж байгаатай холбогдуулан хүрээ хязгаарт өөрчлөлт оруулах эсэхээс шалтгаалан бодлогын шийдвэр гаргахыг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад бэлдье гишүүд ээ.

Санал хураалтад гишүүд бэлдсэн бол санал хураалт явуулъя. /алх цохив/

73.3 хувиар 11 гишүүн дэмжсэн тул санал дэмжигдлээ.

Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ? Нийгмийн бодлого дээр байгаа. Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд байна уу? С.Эрдэнэбат гишүүн үү? Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн танилцуулъя.

Дараагийн асуудалдаа оръё. Баярлалаа. Ажлын хэсэгт баярлалаа.

Дөрөв. Байнгын хорооны тогтоолын төсөл
/Ажлын хэсэг байгуулах тухай/

Дахиад хоёр Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа. Манай гишүүд санал хураалт байна.

Хоёр Байнгын хорооны тогтоолын төсөл батлахаар байгаа.

Нэгдүгээрт, Монгол Улсын Их Хурлын дарга болон Өргөдлийн байнгын хорооны дарга, гишүүдэд хандан “Ахмадын дуу хоолой” хөдөлгөөний ахмадууд, ахмадуудын зөвлөлийн төлөөлөл, н.Алтанзул нараас ахмадын тэтгэвэр нэмэгдүүлэх, тэтгэврийн зээлийн хүүг бууруулах, ахмадуудад зориулсан эрүүл мэндийн болон асрах үйлчилгээг сайжруулах асуудлаар ирүүлсэн өргөдлийг судлан үзэж санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий “Ажлын хэсгийг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Энэ тогтоолын төсөлтэй холбоотойгоор асуулт асуух гишүүн байгаа юу?

Ер нь энэ бол олон мянган ахмадууд маань олон хоног гадаа жагсаж тэтгэврээ нэмүүлэх асуудлыг шат шатны хүмүүст, Байнгын хороонд, гишүүдэд ирүүлсэн байгаа. Улсын Их Хурлын даргад ч гэсэн ирүүлсэн байгаа.

Энэ асуудал дахиад мэдээж яг энэ 2026 оны төсвийг хэлэлцүүлж байгаа энэ үе шатад бид зайлшгүй бас авч үзэж, орон зайг нь судалж. Тийм ээ. Түрүүний ярилцсан цалин, тэтгэмжийн асуудал, 36 сарын төрийн албан хаагчдын тэтгэмж гээд олон асуудлыг бид эрэмбэ дарааг нь гаргаж, төсөв дээрээ суулгах асуудлуудыг харах ёстой байгаа юм.

Тэгэхээр энэ Байнгын хороог бид байгуулж байгаа нь манай Улсын Их Хурлын хуулиар болон дэгийн хуулиар бид иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг хэлэлцүүлэхдээ мэргэжлийн Байнгын хорооны саналыг үндэслэж энэ асуудал дээр санал, дүгнэлт гаргаж хэлэлцүүлэх, санал, дүгнэлтээ танилцуулах ажлын хэсгийг байгуулж ажиллах үүрэгтэй байгаа.

Үүнийхээ дагуу Сүхбаатарын Эрдэнэбат гишүүнээр ахлуулан, Д.Рэгдэл гишүүн, П.Мөнхтулга гишүүд нарын ажлын хэсэг ажиллаж, холбогдох яам, мөн Монголбанк ахмадуудад өгч байгаа эрүүл мэнд, бусад үйлчилгээний хүртээмж гээд гурван асуудлаар ямар боломжууд байна, шийдлүүдийг гаргах ажлын хэсгийг байгуулахаар Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа.

Асуулт асуух гишүүн байна уу? Асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Д.Рэгдэл гишүүнээр тасаллаа. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэбат: Ямар ч байсан ахмадын талаар бас нэлээн том хүлээлт бүхий асуудал байж байгаа. Тэгээд энэ тал дээр ажлын хэсэг Байнгын хорооноосоо байгуулахыг дэмжиж байна.

Дээрээс нь асуудлын эзэн болсон Монголбанк, манай Сангийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, бас нэлээн олон субъектүүд оролцож байж энэ тавиад байгаа асуудлууд. Эрүүл мэндийн яам. Нөгөө тусламж, үйлчилгээтэй холбоотой. Эдгээрт шаардлагатай дэмжлэг тусалцаа, мэдээлэл хүргэхийг тогтоолын төсөл дээр нэмж тусгаж өгвөл хэрэгтэй байна.

Өөрөөр хэлбэл ахмадын өргөдөлтэй холбоотой, тэтгэврийн зээлтэй холбоотой асуудлууд нь гол зүйлүүд байгаа.

Тийм учраас энэ тал дээр шаардлагатай юуг нь тавихгүй бол одоо Монголбанк гэхэд тухайлбал бид тэтгэврийн зээлд оролцохоо больсон гээд шууд өөрсдөө татаж байгаа байхгүй юу. Асуудал үүсгээд.

Тэгэхээр энэ тал дээр ажлын хэсэг дээр нэмэлт байдлаар тэдгээр субъектүүдийг оролцохыг даалгаж өгөх хэрэгтэй.

Хөдөлмөрийн яам бол оролцоод яваад байгаа. Нийгмийн даатгалын газар.

Эрүүл мэндийн яам ахмадын тусламж, үйлчилгээтэй холбоотой учраас, ахмадын эрүүл мэндийн асуудал учраас Эрүүл мэндийн яамнаас тодорхой албан тушаалтнуудыг оролцуулах л хэрэгтэй юм билээ гэдгийг л хэлмээр байна.

О.Номинчимэг: Байнгын хорооны тогтоолын төсөл Та бүхэнд тараагдсан байгаа.

Хоёрдугаарт, ажлын хэсгийн үйл ажиллагаанд мэргэжил арга зүй, техник зохион байгуулж, шаардлагатай бусад туслалцаа, дэмжлэг үзүүлэхийг Байнгын хорооны ажлын албанд даалгасан байна.

Тэгэхээр энэ асуудал угаасаа яг С.Эрдэнэбат гишүүний хэлж байгаачлан бүхий л. Тийм ээ. Монголбанк, Гэр бүл, нийгмийн хамгааллын яам, Сангийн яам, бусад юу байдаг юм. Энэ яамдын оролцоо, Төсвийн байнгын хороотой нэлээн мэдээлэл солилцох асуудлууд явагдах байх.

Та өөрөө бас Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо болохоор тэнд бодлогын уялдааг хангах. Тийм ээ. Гэх мэтчилэн энэ эрх, үүргүүд 2 дугаар тогтоолоор Д.Наранцэцэг, ажлын алба маань энэ дээр танд дэмжлэг үзүүлээд явахаар тусгагдсан байна.

Дараагийн асуулт. Д.Рэгдэл гишүүн асуулт асууя.

Д.Рэгдэл: Ажлын хэсэг байгуулахыг дэмжиж байгаа.

Хоёр жижигхэн асуулт байгаа юм. П.Мөнхтулга гишүүн энд орж ажиллана гэдгээ мэдэж байгаа болов уу? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт. Ер нь энэ саналаа яаралтай бэлтгэж хуралдаанд танилцуул гэж байгаа юм.

Тэгэхээр яаралтай гэдэг жаахан ойлгомжгүй. Тийм учраас энд хугацаа зааж өгөх нь зөв гэж бодож байна.

О.Номинчимэг: Тэгье. П.Мөнхтулга. Бүрэлдэхүүн дээр бол С.Эрдэнэбат гишүүн ажлын хэсгийн ахлагчтай зөвшилцсөн байгаа. Тийм ээ. Өөрөө холбогдоод хэлсэн байх. Тэгэхээр болж байгаа байх.

Хугацааны хувьд бид бас яг энэ 2026 оны төсвөө баталж байгаа үед ч үүнтэйгээ уялдуулах шаардлагатай.

Тэгэхээр бид нарын хувьд энэ өөрөө төсвийн цаглавар байгаа. Хэлэлцүүлгийн үе шат байгаа. Үүнээс өмнө Нийгмийн хөгжлийн байнгын хороон дээр ч гэсэн энэ асуудал яригдаж байгаа юм билээ.

Тэгэхээр уялдааг нь холбоод, орон зайг нь тэнд бас ярилцаад тэгээд боломжууд нь энэ байна гэдгийг гаргаж ирэх л ажлын хэсэг байгаа учраас төсвийн гуравдугаар хэлэлцүүлэг дээр. Энэ чинь өөрөө зарчмын зөрүүтэй санал гарч байж л цаашаа шийдэгдэх асуудал байгаа учраас энэ хугацаанаас өмнө гэж ер нь бас ойлгож болно. Ингэж байж цаашаагаа илүү үр дүн нь гарах ажил болов уу л гэж ойлгож байна.

Асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд гайгүй байх. Тийм ээ. Байнгын хорооны ажлын хэсгийн тогтоол учраас.

Тэгвэл “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

9 гишүүн буюу 60.0 хувь нь дэмжиж, Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Дараагийн асуудалдаа оръё.

Б.Пунсалмаа гишүүнийг дэмжсэнээр авъя. 10 гишүүн дэмжсэн байна.

Тав.Байнгын хорооны тогтоолын төсөл
/Ажлын хэсэг байгуулах тухай/

Сүүлчийн асуудал. Байнгын хорооны тогтоолын төсөл.

Бид бас шинээр Өргөдлийн байнгын хороо байгуулагдсантай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар Монгол Улсын Их Хурлын нийтийн өргөдөл гомдлын систем буюу **petition.mn**, **parliament.mn** гээд байгаа. Нийтийн өргөдөл хүлээн авах, санал авах, шийдвэрлэлтийн талаар өргөдөл гаргагчид

мэдээлэх, үйл ажиллагааг нь зохион байгуулах журмын төслийг шинээр боловсруулах ажлын хэсгийг байгуулж байна.

Өмнө нь энэ асуудал Инновац, цахим хөгжлийн байнгын хорооны журмаар явж байсан.

Гэхдээ бид шинэ Улсын Их Хурлын тухай хуулиар Байнгын хороо нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ батлах эрхгүй. Энэ бол хориглогдож байгаа.

Улсын Их Хурлын тогтоолоор л бид **d-petition** дээр нийтийн өргөдөл гомдлын системийг саналаа аваад, шийдвэрлээд, яаж процессыг нь явуулах вэ гэдэг энэ журмыг шинэчилж батлах шаардлагатай байгаа.

Тэгээд энэ дээр одоогийн байгаа хууль, манай дэгийн тухай хууль дээр ч гэсэн яг ямар шийдвэр яаж гаргаж, ямар үр дүнгийн хяналт хийх вэ гэдэг дээр бас нэлээн нарийвчилсан асуудлуудыг ярилцах шаардлагатай байгаа учраас Байнгын хороо энэ ажлын хэсгийг байгуулахаар Байнгын хорооны тогтоолын төсөл боловсруулсан байгаа.

Төслийг Та бүхэнд өчигдөр тараасан байгаа. Тийм ээ. Ж.Золжаргал гишүүнээр ахлуулаад, Ж.Золжаргал гишүүн өөрөө Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга байхдаа энэ асуудлаар бас нэлээн судалж, журмыг шинэчлэх ажлыг эхлүүлж байсан.

Ингээд бусад намын төлөөллүүд болох Х.Баасанжаргал гишүүн, С.Замира гишүүн, Л.Мөнхбаясгалан гишүүн, П.Мөнхтулга гишүүн, М.Сарнай гишүүн, С.Эрдэнэбат гишүүдээр бүрдсэн Ж.Золжаргал гишүүнээр ахлуулсан ийм 7 бүрдсэн ажлын хэсгийг байгуулж, 12 сарын 15-ны дотор Улсын Их Хурлын тогтоолын төсөл хэлбэрээр боловсруулж, Байнгын хороонд танилцуулах ажлын хэсгийг байгуулж байгаа юм.

Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Л.Мөнхбаясгалан гишүүнээр тасаллаа. Л.Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Би энэ ажлын хэсгийг Байнгын хорооны референтээс асуусан л даа.

Тэгээд энэ дээр дэгийн хуулиа оруулна гэж ойлгох уу? Дарга аа. Энэ ажлын хэсэгт. Эсвэл тусдаа юу? Эсвэл энэ дээрээ ярилцаад тэрнээсээ цаашаа шийдвэрлэх юм болов уу?

Би нэрээ татах гээд л байна л даа.

О.Номинчимэг: Энэ ажлын хэсэг бол ерөнхийдөө d-petition, нийтийн өргөдлийн системийг яаж бид иргэдээсээ саналыг нь аваад, ямар шалгуураар нийтлээд, яаж шийдвэрлээд.

Одоо бусад Байнгын хороодтойгоо яаж хамтарч ажиллах юм гээд нэлээн том үйл ажиллагааны журам байгаа юм. Үүнийг Улсын Их Хурлын тогтоолоор батлах ёстой. Үүний шинэчлэл гэсэн үг.

Үүнтэй холбогдуулаад тэгвэл дэгийн асуудал хөндөгдөж магадгүй.

Гэхдээ тэрийг мэдээж энэ ажлын хэсгийн хүрээнд л гарч ирнэ. Дэгийн асуудал гарсан тохиолдолд Улсын Их Хурлын тухай хуулиараа Ёс зүй, дэгийн дэд хороо гэж байгаа. Тийм ээ. Төрийн байгуулалтын байнгын хорооны доор. Энэ дээр илүү ярилцаж дэгийн асуудал тэндээс орох ёстой.

Гэхдээ санал мэдээж энэ ажлын хэсгийн хүрээнд гарч ирэх юм.

Тэгээд яах вэ, энэ дээр сая бид Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бундестагийн Өргөдлийн байнгын хороон дээр очиж ажиллаад, тэнд ер нь ямар зарчмаар ажилладаг юм, ямар зохион байгуулалттай байдаг юм гэдгийг нэлээн сайн танилцсан.

Тэгэхээр энэ мэдээллийг авч ажилласан гишүүдээсээ түлхүү оруулсан нь зүйтэй гэсэн байдлаар энэ нэрсийг өгсөн юм. Болох уу? Баярлалаа.

Тэгвэл энэ Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн. Эхлээд санал хураалтын бэлтгэл ажил.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Нийт 9 гишүүн буюу Д.Рэгдэл гишүүнийг дэмжсэнээр дэмжсэнээр тооцъё. Нийт 10 гишүүн дэмжсэнээр Байнгын хорооны тогтоолын төсөл батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье.

Байнгын хорооны гишүүддээ баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 3 цаг 31 минут үргэлжилж, 12 цаг 57 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

ЦАЛТАН-ОД